



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ТООЛЛОГО 2021
ААНБ, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу Аж ахуйн нэгжийн долоо дахь удаагийн тооллогыг 2021 онд амжилттай зохион байгуулж, төр, засгийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлж, бизнес эрхлэгчдийн цогц мэдээлэл бүхий их өгөгдлийн санг байгуулах суурийг бүрдүүлэх зорилтоо амжилттай хэрэгжүүлж, 151.6 мянган аж ахуйн нэгж, 4.6 мянган төсвийн байгууллага, 23.9 мянган төрийн бус байгууллага, 53.9 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамрагдлаа.

АЖ АХУЙН НЭГЖИЙН 2021 ОНЫ ТООЛЛОГО

НЭГДСЭН ҮР ДҮН

Улаанбаатар
2022 он



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

АЖ АХУЙН НЭГЖИЙН 2021 ОНЫ ТООЛЛОГО

НЭГДСЭН ҮР ДҮН

Үндэсний Статистикийн Хороо

Улаанбаатар хот
2022 он

ННА - 60.6
ДАА - 310
А - 31

Хянасан:

Б.Батдаваа	Дарга
Д.Лхамсүрэн	Дэд дарга
Э.Эрдэнэсан	Нэгдсэн статистикийн газрын дарга
Ш.Ариунболд	Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга
Д.Оюунбилэг	Бизнесийн бүртгэл, тооллогын хэлтсийн дарга

Бичиж боловсруулсан:

Н.Амарбаясгалан	Бизнесийн бүртгэл, тооллогын хэлтсийн ахлах статистикч
Э.Гантуяа	Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн ахлах статистикч
Ц.Амаржаргал	Бизнесийн бүртгэл, тооллогын хэлтсийн статистикч
Ч.Бүжинлхам	Бизнесийн бүртгэл, тооллогын хэлтсийн статистикч
Л.Мөнхцэцэг	Бизнесийн бүртгэл, тооллогын хэлтсийн статистикч
Л.Элбэгсайхан	Бизнесийн бүртгэл, тооллогын хэлтсийн статистикч
Ц.Янжиндулам	Судалгаа, шинжилгээ, түүврийн хэлтсийн статистикч

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
Утас: (976-11)-326414, (976)-70141212
Лавлах утас: 1900-1212
Цахим хуудас: www.nso.mn
Цахим шуудан: information@nso.mn

ISBN 978-9919-9907-0-1

АГУУЛГА

АГУУЛГА	3
ТОВЧИЛСОН ҮГ	7
ӨМНӨХ ҮГ	10
ХУРААНГУЙ	13

1 БҮЛЭГ 1. АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТҮҮХ 15

2 БҮЛЭГ 2. АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	21
ТООЛЛОГЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ	22
ТООЛЛОГЫН УДИРДЛАГА	22
ТООЛЛОГЫН АСУУЛГА	23
АНГИЛАЛ, КОД	24
ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ АЖИЛ	24
СУРГАЛТ	25
ТООЛОГЧ	26
МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА	26
СУРТАЛЧИЛГАА	26
МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ	27
МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ	28

3 БҮЛЭГ 3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА 29

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, БАЙРШЛААР	30
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭРЭЭР	34
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ӨМЧИЙН ХЭЛБЭРЭЭР	35
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР	37
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	39

4	БҮЛЭГ 4. ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ	43
	ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ХЭЛБЭР	44
	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ	47
	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ БАЙР, ГАЗРЫН ЭЗЭМШИЛ	54
	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ.....	57
	ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ	64
	ЗЭЭЛИЙН ХАМРАГДАЛТ	65
	ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМД ХОЛБОГДСОН БАЙДАЛ.....	67
	ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТ	70
	СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭЛТ	72
	АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХЭРЭГЦЭЭ	73
	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ БАРИМТ БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ	76
5	БҮЛЭГ 5. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	79
	АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД.....	80
	АЖИЛЛАГЧДАД ОЛГОСОН ЦАЛИН	85
	ОРЛОГО.....	90
	ХӨРӨНГӨ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	95
	ШИЙДВЭР ГАРГАЛТАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО	101
	ОЛОН УЛСЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНД НЭГДСЭН БАЙДАЛ	103
	БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭКСПОРТ.....	103
	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДАЛ.....	105
	ХОРШООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ.....	108

6 БҮЛЭГ 6. БИЗНЕСИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ХАНДЛАГА 113

АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ	114
ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ	118
АЖ АХУЙН НЭГЖИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДСАН БАЙДАЛ	121
ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН БИЗНЕСИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ХАНДЛАГА	126
АЖ АХУЙН НЭГЖИЙН ХҮЧИН ЧАДЛЫН АШИГЛАЛТ	128
АЖ АХУЙН НЭГЖИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ	129
АЖ АХУЙН НЭГЖИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТ	131
АЖ АХУЙН НЭГЖИЙН ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ	133
АЖ АХУЙН НЭГЖИЙН БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БОДЛОГЫН ТҮВШИНД НЭН ТЭРГҮҮНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	134

7 БҮЛЭГ 7. ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ 137

ИННОВАЦ	138
СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ	149
ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ҮР ДҮН	156

8 БҮЛЭГ 8. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА..... 159

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОО	160
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ	167
ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	170
ӨГӨГДЛИЙН САН	174

9 БҮЛЭГ 9.
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА 179

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТОО 180

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 187

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ 190

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ 192

10 БҮЛЭГ 10.
ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД 195

ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ТЭДГЭЭРИЙН БҮТЭЦ 196

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ 201

ДҮГНЭЛТ 211

ЗӨВЛӨМЖ 213

ХАВСРАЛТ 214

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ББН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ЗБН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СБР	Статистикийн бизнес регистр
СХА	Судалгаа хөгжүүлэлтийн ажил
ТБ	Төсвийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ХАА	Хөдөө аж ахуй
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХЭ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
ЭЗБТҮАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
ISIC	International Standard Industrial Classification

УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

КОМИССЫН ДАРГА

КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА



БОЛДЫН ЖАВХЛАН
Сангийн сайд



БАТМӨНХИЙН БАТДАВАА
Үндэсний статистикийн
хорооны дарга

КОМИССЫН ГИШҮҮД



Х.НЯМБААТАР
Хууль зүй, дотоод
хэргийн сайд



Л.ЭНХ-АМГАЛАН
Боловсрол, шинжлэх
ухааны сайд



Б.БАТЦЭЦЭГ
Гадаад харилцааны
сайд



Б.МӨНХБААТАР
Барилга, хот
байгуулалтын сайд



Г.САЙХАНБАЯР
Батлан хамгаалахын
сайд



Б.БАТ-ЭРДЭНЭ
Байгаль орчин, аялал
жуулчлалын сайд



А.АРИУНЗАЯА
Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд



Ч.НОМИН
Соёлын сайд



С.ЭНХБОЛД
Эрүүл мэндийн сайд



Н.ТАВИНБЭХ
Эрчим хүчний сайд



Л.ХАЛТАР
Зам, тээврийн
хөгжлийн сайд



Г.ЁНДОН
Уул уурхай, хүнд
үйлдвэрийн сайд



З.МЭНДСАЙХАН
Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн
сайд



А.ЭНХМАНЛАЙ
Газар зохион байгуулалт,
геодези, зураг зүйн
газрын дарга



Д.БАЯРСАЙХАН
Санхүүгийн
зохицуулах хорооны
дарга



Б.ЗАЯАБАЛ
Татварын ерөнхий
газрын дарга



Б.ЦЭНГЭЛ
Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын
газрын дарга



Д.ДЭЛГЭРСАЙХАН
Улсын бүртгэлийн
ерөнхий газрын дарга



Ж.БОЛД
Цагдаагийн ерөнхий
газрын дарга



Д.ЗАГДЖАВ
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэх ерөнхий
газрын дарга

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Э.ЭРДЭНЭСАН
ҮСХ-ны Нэгдсэн
статистикийн газрын дарга

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД, АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН ДАРГА Б.ЖАВХЛАН



ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Статистикийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 315 тоот тогтоол, тооллогын Улсын комиссын хурлын шийдвэрийн дагуу Аж ахуйн нэгжийн долоо дахь удаагийн тооллогыг 2021 онд амжилттай зохион байгуулж дууслаа.

Энэ удаагийн тооллого нь манай улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийн ажил, үйлчилгээний чиглэл, хэмжээ, төвлөрөл, байршил, нөхцөл байдлыг судалж, төр, засгийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлж, тухайн мэдээллийг төрийн байгууллагууд цахим хэлбэрээр солилцох, түүнчлэн бизнес эрхлэгчдийн цогц мэдээлэл бүхий их өгөгдлийн санг байгуулах суурийг бүрдүүлэх зорилтоо амжилттай хэрэгжүүллээ.

Тооллогыг амжилттай зохион байгуулахад хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу төр, захиргааны байгууллага, Монгол Улсын Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нар онцгой ач холбогдол өгч ажилласан.

Тооллогын ажлыг улс орон даяар нэгдсэн удирдлага, аргачлал, заавраар хангаж, зохионбайгуулалт сайтай явуулж, үрдүнг богино хугацаанд боловсруулж, Тогтвортой хөгжлийн зорилгын 9.3.2, 9.5.1, 9.5.2, 12.6.1 дүгээр шалгуур үзүүлэлтүүдийг тооцон гаргах болон ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг дүгнэхэд шаардлагатай үзүүлэлтүүдийг бий болгоход гол үүрэг гүйцэтгэсэн Үндэсний статистикийн хороо, түүний салбар нэгжийн ажилтан, нийт албан хаагчдад Аж ахуйн нэгжийн тооллогын Улсын комиссын нэрийн өмнөөс гүн талархал дэвшүүлье.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА Б.БАТДАВАА



ӨМНӨХ ҮГ

Статистикийн тухай хуулийн дагуу “Аж ахуйн нэгжийн тооллого”-ыг таван жил тутам зохион байгуулдаг. Аж ахуйн нэгжийн анхны тооллогыг 1991 онд улс даяар явуулснаас хойш анх удаа цахим хэлбэрээр 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 3-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, ийнхүү долоо дахь удаагийн тооллогын үр дүнгээ танилцуулж байна.

Энэ удаагийн тооллогын хүрээнд төрийн байгууллагуудын мэдээллийн санг уялдуулан холбож, аж ахуйн нэгж, байгууллагын бүтцэд шинжилгээ хийх, дотоодын нийт бүтээгдэхүүн, нөөц ашиглалтын хүснэгт, үндэсний тооцооны данс, хөрөнгө, хөрөнгө оруулалт, төрийн бус байгууллагын үйлдвэрлэл, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ зэрэг макро түвшний үзүүлэлтийг нарийвчлан тооцов. Мэдээлэл болон бизнесийн төлөв байдал, хандлага, томоохон аж ахуйн нэгж, байгууллагын хамаарал бүхий нэгж, мэдээллийн технологи, судалгаа хөгжүүлэлт, инновацтай холбоотой үзүүлэлтүүдийг нэлэнхүй ажиглалтаар цуглуулав. Мөн тооллогод хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамруулж, эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл, бизнес эрхлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл, Ковид-19 цар тахлаас үүдэн орлого, зардал хэрхэн өөрчлөгдсөнийг судалж, цаашид хийх судалгааны хүрээг бий болгохыг зорилоо.

Энэхүү тооллогын нэгдсэн үр дүнгийн тайлан нь 10 бүлэг танилцуулга, тооллогын үндсэн үзүүлэлтийн хавсралт хүснэгтүүдээс бүрдэж байна. Тооллогын үр дүнгийн тайланд оруулсан, олон нийтэд нээлттэй болгосон анхдагч мэдээлэл нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, эрдэмтэн судлаачид болон статистик мэдээлэл хэрэглэгчдэд үнэ цэнтэй мэдээллийн эх үүсвэр болж, эдийн засгийн бүтэц, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох суурь мэдээлэл бүрдүүлэх, гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийх зэрэгт зохих хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Тооллогын үеэр тулгарсан бэрхшээл, үр дүнд үндэслэн цаашид холбогдох байгууллагуудтай хамтран зарим мэдээллийг нэг эх үүсвэртэй болгох, төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудыг уялдуулах, олон жил үйл ажиллагаа явуулахгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан буулгах шийдвэр гаргуулах зэрэг ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Энэ удаагийн тооллогыг амжилттай зохион байгуулахад удирдлага, зохицуулалтаар хангаж ажилласан тооллогын Улсын комисс, зохион байгуулалтыг

ханган ажилласан бүх шатны тооллогын ажлын хэсэг, орон нутгийн тооллогын комисс, ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газар, Бизнесийн бүртгэл, тооллогын хэлтэс, Мэдээллийн технологийн газар болон ҮСХ, нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн хамт олон, тооллогын сурталчилгааны цахим зурвасыг хэрэглэгчдэдээ үнэ төлбөргүй хүргэсэн харилцаа холбооны оператор компаниуд Мобиком Корпорац ХХК, Скайтел ХХК, хамтран ажилласан хэвлэл мэдээллийн байгууллагууд, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, тооллогод хамрагдаж мэдээллээ өгсөн аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэдээ талархал илэрхийлье.

ХУРААНГУЙ

Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогод 180.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан нь 2016 оны тооллогын дүнгээс 61.3 мянга (51.7%), 2011 оны тооллогын дүнгээс 114.8 мянга (2.8 дахин), 2006 оныхоос 147.6 мянга (5.6 дахин), 1998 оныхоос 161.1 мянга (9.5 дахин)-аар тус тус нэмэгдсэн байна.

Тооллогод хамрагдсан 180.0 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 130.0 мянга (72.2%) нь Улаанбаатар хотод байгаа нь ААНБ-ын төвлөрөл нийслэлд их байгааг харуулж байна. Үлдсэн ААНБ-ын 32.5 мянга (18.1%) нь Хангайн болон Төвийн бүсийн аймгуудад байршиж байгаа бол 17.5 мянга (9.7%) нь Баруун болон Зүүн бүсийн аймгуудад байршилтай байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын 151.6 мянга (84.2%) нь аж ахуйн нэгж, 4.6 мянга (2.6%) нь төсвийн байгууллага, 23.9 мянга (13.3%) нь төрийн бус байгууллага байна. Үүнээс 52.4 мянга (29.1%) нь 2020 онд үйл ажиллагаа явуулсан бөгөөд тэдгээрт нийт 705.0 мянган хүн ажиллаж байна. Мөн 151.6 мянган аж ахуйн нэгжийн 56.8 мянга (37.5%) нь тооллогын хугацаанд үйл ажиллагаа явуулсан байна. Эдгээрийн 23.0 мянга (40.5%) нь худалдааны салбарт, 19.1 мянга (33.6%) нь үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 46.0 мянга (30.4%) нь сүүлийн 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байна. Харин сүүлийн хоёр жил тасралтгүй үйл ажиллагаа явуулаагүй 105.5 мянган аж ахуйн нэгжийн 14.9 мянга (14.1%) нь татан буугдах хүсэлтэй байна. Сүүлийн 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 41.6 мянга (90.3%) нь 2020 онд үйл ажиллагаа явуулж, 75.7 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн байна. Эдгээр аж ахуйн нэгжийн 19.8 мянга буюу 43.1 хувь нь үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахдаа төрийн байгууллагад аливаа баримт бичиг, тодорхойлолт хүргүүлдэг байна. Тухайлбал, нэг аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахдаа төрийн байгууллагуудад дунджаар 11 баримт бичиг; тодорхойлолт; гэрээ, дүгнэлт, үнэлгээ гаргуулахдаа тус бүр гурван баримт бичиг; тодорхойлолт бүрдүүлж өгдөг байна.

Үйл ажиллагаа явуулаагүй төлөвтэй 94.7 мянган аж ахуйн нэгжийн 45.9 мянга (48.5%) нь түр зогссон, 29.5 мянга (31.1%) нь эхлээгүй, 18.8 мянга (19.8%) нь бүрэн зогссон, 0.6 мянга (0.6%) нь бусад шалтгаантай байна. Эдгээр аж ахуйн нэгжийн 42.8 мянга (45.2%) нь худалдааны салбарт, 5.7 мянга (6.0%) нь хөдөө аж ахуйн салбарт байна.

Энэ удаагийн тооллогоор Ковид-19 цар тахлын аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийн талаар судалсан. Сүүлийн 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан 39.5 мянга (85.9%-)н аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Ковид-19 цар тахал сөргөөр нөлөөлсөн байна. Мөн эдгээр аж ахуйн нэгжийн 44.4 хувь нь хатуу хөл хорионы үед үйл ажиллагаагаа хязгаарлагдмал хүрээнд явуулсан байна. Хатуу хөл хориотой холбоотойгоор аж ахуйн нэгжийн 37.5%

нь ажлын байраа хадгалахад хүндрэлтэй байсан, 19.9% нь төр, засгаас гаргаж буй шийдвэрийн ойлгомжгүй, уялдаа холбоогүй байсан учир хүндрэл бэрхшээл гарсан гэж хариулсан байна.

Тооллогод 4.6 мянган төсвийн байгууллага хамрагдсан нь 2016 оны тооллогын дүнгээс 5.1 хувиар, 2011 оны тооллогын дүнгээс 16.1 хувиар тус тус нэмэгдсэн байна. Төсвийн байгууллагын 2.3 мянга (49.3%) нь хүний нөөцийн дутагдалтай байна. Төсвийн байгууллагын 67 нь өөрөө удирдан хөгжүүлдэг 157 өгөгдлийн сантай байна.


Тооллогод 23.9 мянган төрийн бус байгууллага хамрагдсаны 7.8 мянга нь үйл ажиллагаа явуулж байгаа ба 4.7 мянга (60.9%) нь нийгэмд үйлчилдэг, 3.0 мянга (39.1%) нь гишүүддээ үйлчилдэг байна.

Энэ удаагийн тооллогод хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийг анх удаа цуглуулсан ба нийт 53.9 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамрагдлаа. Эдгээрийн 61.5 хувь нь тогтсон ажлын байртай, 38.5 хувь нь тогтсон ажлын байргүй байна. Тогтсон ажлын байртай ХХЭ-ийн 83.1 хувь нь дэлгүүр, зах, үйлчилгээний төвд үйл ажиллагаа явуулж байхад тогтсон ажлын байргүй ХХЭ-ийн дийлэнх нь гэртээ үйл ажиллагаа явуулж байна.

1

БҮЛЭГ

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТҮҮХ



БҮЛЭГ 1.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТҮҮХ

1.1 АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ТУХАЙ

Аж ахуйн нэгжийн тооллого нь манай улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эрхэлж байгаа ажил, үйлчилгээний чиглэл, байршлыг тогтоож, тэдгээрийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, үүнтэй холбогдон гарах бодлого, шийдвэрт шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой юм. Үндэсний статистикийн хороо нь аж ахуйн нэгжийн тооллогыг 1991, 1994, 1998, 2006, 2011, 2016, 2021 онуудад нийт 7 удаа зохион байгууллаа.

Аж ахуйн нэгжийн 1991, 1994 оны тооллогод эдийн засгийн үйл ажиллагааны зарим хэсгийг хамруулж, тоолох нэгжийн ажиллагчдын тоонд суурилан хязгаар тавьж, цөөн үзүүлэлтийг цуглуулж байсан бол 1998 оноос хойш тооллогод өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан. Тооллогыг зохион байгуулах үеийн нийгэм, эдийн засгийн байдал, тооллого зохион байгуулахтай холбоотой гарсан тогтоол, шийдвэртэй уялдан тооллогын асуулгын хуудасны агуулга өөрчлөгдөж ирсэн.

1.2 АЖ АХУЙН НЭГЖИЙН 1998 ОНЫ ТООЛЛОГО

ҮСХ нь “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 143 дугаар тогтоолын дагуу аж ахуйн нэгжийн тооллогыг 1998 оны 10 дугаар сарын 12-23-ны өдрүүдэд улс даяар зохион байгуулсан.

Тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд бүх аймаг, нийслэл, дүүргийн тооллогод хамрагдвал зохих аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг гаргаж, Үндэсний статистикийн газар (хуучин нэрээр)-аас төлөөлөгч томилон орон нутагт ажиллуулж, заавар өгч, тооллогын асуулгыг аймаг, дүүрэгт нь шалган компьютерт шивж байжээ. Уг тооллогод өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилал (ISIC)-ын 2.0 хувилбарыг нэвтрүүлж, Үндэсний статистикийн газарт бизнес регистрийн санг анх удаа байгуулан, баяжилтыг улирлаар хийх, түүвэр судалгааны хамрах хүрээ болгон ашиглах боломжийг бүрдүүлсэн байна. Тооллогын үр дүнд

регистрийн дугааргүй аж ахуйн нэгж, байгууллага, салбар нэгжүүд нэлээд байгааг илрүүлж, тэдгээрт шинээр регистрийн дугаар олгох ажлыг хийжээ. Уг тооллогод төв, орон нутгийн нийт 654 албан хаагч ажилласан байна.

1.3 АЖ АХУЙН НЭГЖИЙН 2006 ОНЫ ТООЛЛОГО

1998 оны тооллогоос хойш аж ахуйн нэгж олноор байгуулагдсан, томоохон компаниуд өөрийн охин компани, салбар нэгжийг байгуулан өргөжсөн. Уг нөхцөл байдалтай уялдан аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төрөл, үйл ажиллагааны талаарх мэдээллийг бий болгох хэрэгцээнд тулгуурлан 2006 оны тооллогыг зохион байгуулсан. Тооллогыг “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2006 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн “Аж ахуйн нэгжийн тооллого явуулах” тухай 44 тоот захирамжид үндэслэн 2006 оны 6 дугаар сарын 5-20-ны өдрүүдэд улс даяар зохион байгуулсан байна. Аж ахуйн нэгжийн 2006 оны тооллогын хүрээг тогтоох мэдээллийн гол эх үүсвэр нь 1998 оны тооллогоор бий болгож, улирал тутам баяжилт хийж ирсэн “Бизнес регистрийн сан” байлаа.

Уг тооллогод Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төсвийн болон төрийн бус байгууллагаас гадна орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулж, мэдээллийн санг бүрдүүлжээ.

Аймаг, нийслэлийн бүх шатны ажлын хэсгийг өдөр тутмын удирдлагаар хангаж, ажиллах үүрэг бүхий Улсын комиссыг Сангийн сайд, Үндэсний статистикийн газар (хуучин нэрээр)-ын даргын хамтарсан тушаалаар байгуулсан. Аж ахуйн нэгж, байгууллагыг тооллогоос орхигдуулахгүй, давхардуулан тоолохгүй байх үүднээс тооллогод хамрагдсан байгууллагын бүртгэлийн гэрчилгээний ард тооллогод хамрагдсан болохыг гэрчлэх тусгай тэмдэглэгээг хийж, баталгаажуулсан. Энэ тооллогод төв, орон нутгийн нийт 685 албан хаагч ажилласан байна.

1.4 АЖ АХУЙН НЭГЖИЙН 2011 ОНЫ ТООЛЛОГО

Энэ удаагийн тооллогыг “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “Аж ахуйн нэгжийн тооллого явуулах” тухай 61 тоот тогтоолд үндэслэн 2011 оны 4 дүгээр сарын 15-наас 5 дугаар сарын 15-ны өдрүүдэд улс даяар зохион байгуулсан. Уг тооллогод эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилал (ISIC)-ын шинэ хувилбар (4.0)-ыг нэвтрүүлж, олон улсын стандартад нийцсэн статистик нэгжийг байгуулах суурийг тавьж, тооллогын үр дүнгээр газар зүйн мэдээллийн санг анх удаа бүрдүүлсэн.

Тооллогын асуулгад аж ахуйн нэгж, байгууллагын нийт хөрөнгө, мэдээллийн технологийн холбогдолтой үзүүлэлтийг нэмэлт байдлаар дэлгэрэнгүй оруулсан нь тооллогын мэдээллийн хэрэглээг улам нэмэгдүүлсэн. Энэ тооллогод төв, орон нутгийн нийт 512 албан хаагч ажиллажээ.

1.5 АЖ АХУЙН НЭГЖИЙН 2016 ОНЫ ТООЛЛОГО

2016 оны тооллогыг “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 163 дугаар тогтоолын дагуу 2016 оны 4 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний өдрүүдэд улс даяар зохион байгуулсан. Тооллогын мэдээллийг цуглуулахдаа дараах хоёр аргыг ашигласан. Үүнд:

1. **Цахим арга:** ААН-ийн тооллогын цахим хуудас (<http://aanb.nso.mn/login.aspx>)-ыг Гааль, татварын ерөнхий газар (хуучин нэрээр)-ын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2016 оны 1 дүгээр улирлын цахим тайлан (<http://etax.mta.mn/portail>)-тай холбож, 2016 оны 4 дүгээр сарын 1-нээс 4 дүгээр сарын 20-ны өдрүүдэд мэдээллийг цуглуулсан.
2. **Уламжлалт арга:** Тоологч нар цахимаар тооллогод хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагад очиж, удирдлага, холбогдох ажилтанд тооллогын асуулгыг биечлэн танилцуулж, мэдээллийг 2016 оны 4 дүгээр сарын 1-30-ны өдрүүдэд цуглуулжээ.

Энэхүү тооллогод уламжлалт цаасан асуулгын хуудсаар мэдээлэл цуглуулахаас гадна цахим аргаар мэдээлэл цуглуулснаараа онцлог болсон. Мөн ААНБ-ын үйл ажиллагаагаа явуулж байгаа байршлын цэгийг тэмдэглэж, газар зүйн мэдээллийн санг шинэчилсэн. Тооллогын асуулгад интернэт захиалга авч, үйлчилгээ үзүүлдэг эсэх, байгаль орчныг хамгаалахад зарцуулсан зардал, хөрөнгө оруулалтын мэдээллийг нэмэлтээр оруулсан байна. Энэ тооллогод төв, орон нутгийн нийт 1372 албан хаагч ажилласан.

1.6 АЖ АХУЙН НЭГЖИЙН 2021 ОНЫ ТООЛЛОГО

Аж ахуйн нэгжийн ээлжит тооллогыг 2021 оны 11 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 3-ны өдрүүдэд улс даяар зохион байгуулж, тооллогын мэдээллийг цахим асуулгын аргаар цуглуулж, тооллогод хамрагдсан тухай онлайн гэрчилгээ олгосон. Ингэхдээ:

- Аж ахуйн нэгж, байгууллага нь тооллогод зориулан үүсгэсэн цахим хуудас (<https://toologo.1212.mn/>)-нд Татварын ерөнхий газрын нэгдсэн нэвтрэлт (<https://etax.mta.mn>)-ийн хэрэглэгчийн нэр, нууц үгийг ашиглан нэвтэрч, тооллогын асуулгын хуудасны мэдээллийг нөхөх;
- Нэгдсэн нэвтрэлтийн системд бүртгэлгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчид нь ҮСХ-ны “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-д регистрийн дугаар, эцэг/эхийн болон өөрийн нэрийг оруулж, нэвтэрснээр тооллогын асуулгын хуудасны мэдээллийг нөхөх;
- Цахим асуулгын аргаар мэдээлэл өгөх боломжгүй ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчтэй тоологч уулзах эсвэл утсаар холбогдож, тооллогын асуулгыг байгууллагын удирдлага болон холбогдох бусад ажилтнуудтай хамтран нөхөх замаар мэдээллийг цуглуулсан.

Тооллогын үеэр тусгай лавлах утас (7533-1212) ажиллуулж, тооллогод хамрагдах нэгжүүдэд тухайн орон нутгийн тооллогын комисс нь шаардлагатай тодруулга, мэдээлэл өгсөн.

Энэ удаагийн тооллогоор анх удаа хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эдийн засгийн үзүүлэлт, үндсэн болон хоёрдогч үйл ажиллагаа, үйл ажиллагаа явуулж эхэлсэн огноо, байрны эзэмшил, Ковид-19 цар тахлын нөлөө, бизнесийн төлөв байдал, зээлийн мэдээлэл, цахим төлбөрийн баримтын систем (ebarimt.mn)-д холбогдсон эсэх талаарх мэдээллийг бүрдүүлснээрээ онцлогтой. Энэхүү тооллогоор хаягийн орон зайн мэдээллийн санд суурилан ААНБ-ын үйл ажиллагаагаа явуулж байгаа байршлыг тодорхойлж, газар зүйн мэдээллийн санг шинэчилсэн.

Тооллогын асуулгад ААН-ийн үйлдвэрлэл, үйлчилгээний газрын эзэмшлийн хэлбэр; цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байдал; тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулсан эсэх; стандартыг нэвтрүүлсэн байдал; хүний нөөцийн дутагдал, шаардлагатай мэргэжлийн чиглэл; үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад төрийн байгууллагаас шаардагдах баримт бичиг; шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо; олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн байдал; экспортод гаргадаг бүтээгдэхүүн, үйлчилгээ; үйлдвэрлэлийн зориулалттай машин, тоног төхөөрөмжтэй эсэх, түүний хүчин чадал ашиглалт; Ковид-19 цар тахлын нөлөө; бизнесийн төлөв байдал, хандлага; инновац, судалгаа хөгжүүлэлтийн талаарх асуултууд оруулж, холбогдох мэдээллийг цуглуулсан. Тооллогод аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах, тэдгээрийн оруулсан мэдээллийг шалгаж, баталгаажуулах ажлыг нийт 1934 тоологч гүйцэтгэсэн байна.

2

БҮЛЭГ

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



БҮЛЭГ 2.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТООЛЛОГЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Аж ахуйн нэгжийн ээлжит тооллого явуулахад дараах хууль, тогтоол, шийдвэр нь хууль, эрх зүйн үндэслэл болсон. Үүнд:

- Статистикийн тухай хууль (7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “з” заалт);
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Компанийн тухай, Хоршооны тухай, Нөхөрлөлийн тухай, Төрийн бус байгууллагын тухай, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулиуд;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Аж ахуйн нэгжийн улсын тооллого явуулах” тухай 315 тоот тогтоол.

ТООЛЛОГЫН УДИРДЛАГА

Тооллогын бүхий л шатны үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн туслалцаа үзүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тооллогод бүрэн хамруулах, тооллогын явцад хяналт, үнэлгээ хийх, шаардлагатай арга хэмжээ авах, тооллогын ажлыг дүгнэх, үр дүнг Засгийн газарт танилцуулах үүрэг бүхий тооллогын Улсын комиссыг Сангийн сайдаар ахлуулан байгуулсан. Тооллогын Улсын комисс нь дараах чиг үүрэгтэйгээр ажиллалаа. Үүнд:

1. Аж ахуйн нэгжийн тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулж, явуулах;
2. Аж ахуйн нэгжийн тооллого явуулах бэлтгэлийг хангаж, батлагдсан асуулга, заавар, нэгдсэн удирдамжийн дагуу арга зүйн удирдлагаар ханган ажиллах;
3. Аж ахуйн нэгж бүрийг тайлан тэнцэл гаргадаг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллын дагуу бүртгэж, кодлуулах;
4. Аж ахуйн нэгжийн тооллогын ажлын явцыг хариуцсан асуудлаар дүгнэлт, санал гаргах;
5. Комиссын гишүүд нь аж ахуйн нэгжийн тооллогыг зохион байгуулах Улсын комиссын өмнөөс өөрийн чиг үүргийн салбарын тооллоготой холбогдолтой асуудлыг хариуцах.

Үндэсний Статистикийн Хороо нь тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулах, аймаг, нийслэл, дүүргийн тооллогын комиссын гишүүд, Статистикийн газар,

хэлтсийн албан хаагчдыг мэргэжил, арга зүйн шуурхай удирдлагаар хангах, удирдамж, чиглэл өгч ажиллах ажлын хэсгийг байгуулж ажилласан. Мөн аж ахуйн нэгжийн тооллогын бэлтгэлийг орон нутгийн түвшинд хангаж, тооллогыг удирдан зохион байгуулж явуулах зорилго бүхий тооллогын Комиссыг аймаг, нийслэлд байгуулсан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын Комисс нь дараах чиг үүрэгтэй ажиллав. Үүнд:

1. Тооллогыг өөрийн орон нутагтаа зохион байгуулж, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах;
2. Тооллогыг зохион байгуулахад Орон нутгийн комиссын удирдамжийг мөрдлөг болгон ажиллах;
3. Тоологчийг ажиллуулж, сургалт явуулах, ажлын үр дүнг тооцох;
4. Тооллогын явц болон тулгарч буй асуудлын талаар Үндэсний Статистикийн Хорооны ажлын хэсэгт мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;
5. Үндэсний статистикийн хорооны ажлын хэсгийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
6. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналтын ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй ажилласан байна.

Тооллогыг орон нутагт удирдан зохион байгуулах, явц болон тулгарч буй асуудлын талаар ажлын хэсэгт мэдэгдэж байх, холбогдох арга хэмжээ авч, ажиллах үүрэг бүхий аймаг, нийслэл, сум, дүүргийн Комисс, ажлын хэсгийг тухайн шатны Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулсан.

Тухайн шатны Засаг дарга дараах үүрэгтэй ажилласан. Үүнд:

- Сум, дүүргийн тооллогын комиссыг байгуулах
- Тооллогын зардалд дэмжлэг үзүүлэх

ТООЛЛОГЫН АСУУЛГА

Тооллогын асуулгыг зорилго, хамрах хүрээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлага, өмнөх тооллогын үр дүнтэй харьцуулагдах байдлыг харгалзан боловсруулж, 22 яам, агентлагаас саналыг авч нэгтгэн, ҮСХ-ны Арга зүйн байнгын зөвлөл, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ҮСХ-ны даргын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/167 тоот тушаалаар баталсан. Тооллогоор хаягийн мэдээлэл, ерөнхий үзүүлэлт, мэдээллийн технологийн үзүүлэлтийг тооллого зохион байгуулагдах үеийнхээр, эдийн засгийн үзүүлэлтийг 2020 оны дүнгээр, инновац, судалгаа хөгжүүлэлтийн үзүүлэлтийг 2018-2021 оны байдлаар цуглуулсан. Энэ удаагийн тооллогод 5 төрлийн асуулгаар дараах мэдээллийг цуглууллаа. Үүнд:

1. **Аж ахуйн нэгжийн тооллогын асуулга (ААНТ-1):** Аж ахуйн нэгжийн хаягийн үзүүлэлт, ерөнхий үзүүлэлт, үйл ажиллагааны байдал, шалтгаан, Ковид-19 цар тахлын нөлөөлөл, мэдээллийн технологи, орлого, зардал, хөрөнгө, хөрөнгө оруулалт, бизнесийн төлөв байдал, хандлага, инновац, судалгаа хөгжүүлэлтийн мэдээлэл;

- 2. Төсвийн байгууллагын тооллогын асуулга (ААНТ-2):** Төсвийн байгууллагын ерөнхий үзүүлэлт, хаяг, эдийн засаг, мэдээллийн технологи, өгөгдлийн сангийн мэдээлэл;
- 3. Төрийн бус байгууллагын тооллогын асуулга (ААНТ-3):** Төрийн бус байгууллагын ерөнхий үзүүлэлт, хаягийн болон эдийн засгийн үзүүлэлт, төрийн бус байгууллагын төрөл, үйл ажиллагааны чиг үүрэг, гишүүдийн тоо, санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгийн зарцуулалт, мэдээллийн технологийн мэдээлэл;
- 4. Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын тооллогын асуулга (ААНТ-4):** ААНБ-ын салбар, нэгж, төлөөлөгчийн газрын хаяг, эдийн засгийн үзүүлэлт, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл зэрэг мэдээлэл;
- 5. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тооллогын асуулга (ААНТ-5):** Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ерөнхий үзүүлэлт, хаяг, эдийн засгийн үзүүлэлт, үндсэн болон туслах үйл ажиллагаа, байрны эзэмшил, Ковид-19 цар тахлын нөлөө, бизнесийн төлөв байдал, зээлтэй эсэх, зээлийн мэдээлэл, цахим төлбөрийн баримтын систем (ebarimt.mn)-д холбогдсон талаарх мэдээллийг цуглуулсан.

АНГИЛАЛ, КОД

Энэхүү тооллогод олон улсад мөрдөгдөж байгаа болон төрийн захиргааны бусад байгууллагын мэдээллийн санд мөрдөж буй албан ёсны ангилал, кодыг ашигласан.

Үүнд:

- Монгол Улсын бүсчлэлийн код
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, код-4.0
- Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, код
- Хөрөнгийн ангилал
- Хариуцлагын хэлбэрийн ангилал, код
- Өмчийн хэлбэрийн ангилал, код
- Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны ангилал, код

ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ АЖИЛ

Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай Засгийн газрын тогтоолыг батлуулж, Улсын Комиссын хурлыг хуралдуулж, холбогдох шийдвэрийг гаргуулах;
- Яам, агентлагуудаас аж ахуйн нэгжийн тооллогыг хариуцан зохион байгуулах ажилтнууд томилогдон цахим сургалтад хамрагдсан. Тооллогын ажлыг чанартай зохион байгуулах тухай албан тоотыг тооллогын Улсын комиссын гишүүдэд хүргүүлсэн. Зарим яам, агентлаг тооллого зохион байгуулах Комисс байгуулж ажилласан;

- ҮСХ-ны дэргэд тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажилласан;
- ААН-ийн тооллогын бэлтгэлийг хангаж, хамралтыг нэмэгдүүлэх, тооллогын бүхий л үйл ажиллагааг хамарсан нэгдсэн удирдамжийг боловсруулж, орон нутгийн тооллогын Комисст хүргүүлсэн;
- Бизнес регистрийн мэдээллийн санг Хуулийн этгээдийн бүртгэл, Татвар, Нийгмийн даатгал, Санхүүгийн тайлангийн мэдээллийн сан, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн цахим төлбөрийн баримтын мэдээллийн сан, вакцинжуулалтын мэдээллийн сангуудтай уялдуулан тооллогын хамрах хүрээг бүрдүүлж, цахим программд оруулсан;
- Тооллогын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны газар, Нийслэл, дүүргүүдийн хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Хөдөө аж ахуйн хоршоологчдын нэгдсэн холбоо, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажилласан;
- ҮСХ, яам, агентлаг, орон нутгийн нийт 501 албан хаагчдыг тооллогын мэдээлэл цуглуулалтын явцыг онлайнаар хянах боломжийг бүрдүүлсэн;
- Барилга, хот байгуулалтын яам; Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар; Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам; Байгаль орчин, аялал жуулчлалын яам; Боловсрол, шинжлэх ухааны яам; Эрүүл мэндийн яам; Соёлын яам; тэдгээрийн харьяа байгууллагуудын тусгай зөвшөөрөл олгосон нийт 16.1 мянган ААН-ийн мэдээллийг тооллогын хүрээтэй уялдуулсан.

СУРГАЛТ

Тооллогын орон нутгийн сургагч багш нар, яамдын тооллогын асуудал хариуцсан ажилтнууд, тоологч нарт тооллогын зохион байгуулалт, тоологч, шалгагчийн үүрэг, мэдээлэл цуглуулах цахим программ, хаягийн орон зайн мэдээллийн санд суурилан ААНБ-ын байршлыг тодорхойлох, асуулгын хуудсыг нөхөхөд шаардагдах ангилал, код, нөхөгдсөн мэдээллийн үнэн зөвийг шалгах болон тооллогын 5 төрлийн асуулгын хуудсыг нөхөх зааварчилгаа өгөх сургалтыг 3 үе шаттайгаар цахим хэлбэрээр зохион байгуулж, гарын авлага, холбогдох материалыг бэлтгэж, сургалтын видеог цахим хуудсанд байрлуулсан. Үүнд:

- Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нарыг оролцуулсан 133 албан хаагчдад орон нутгийн сургагч багш нарын сургалтыг 2021 оны 10 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан.
- 22 яам, агентлагийн тооллогын асуудал хариуцсан 61 ажилтанд сургалтыг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан.
- Орон нутгийн сургагч багш нар нь тоологчийн цахим сургалтыг 2021 оны 10 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулсан.

ТООЛОГЧ

Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тооллогод хамруулах, тэдгээрийн оруулсан мэдээллийг шалгаж, баталгаажуулах ажлыг тоологч гүйцэтгэсэн. Улмаар аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч олонтой зарим дүүрэгт нэмэлт тоологчийг ажиллуулсан. Тоологч нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийг цуглуулах, аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл, ажил, мэргэжлийг кодлох, тодруулгын дагуу өөрчлөлтийг тусгах чиг үүрэг хүлээсэн.

Аймаг, сум, дүүрэгт статистикийн газар, хэлтсийн мэргэжилтэн, санхүү, төрийн сангийн мэргэжилтэн, бүртгэлийн бүртгэгч, татварын байцаагч, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн нар тоологчоор ажилласан.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА

Цахим болон уламжлалт аргаар тооллогын мэдээллийг цуглуулсан. Тухайлбал:

- Цахим хуудас ашиглан мэдээлэл цуглуулах арга (CAWI) - Аж ахуйн нэгж, байгууллага цахим хуудас (<https://toollogo.1212.mn/>)-нд асуулгын хуудасны дагуу мэдээллийг нөхөх замаар тооллогод хамрагдсан.
- Уламжлалт арга - Цахим асуулгын аргаар мэдээлэл өгөх боломжгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчидтэй тоологч биечлэн уулзах эсвэл утсаар холбогдож, тэдэнтэй хамтран зааврын дагуу тооллогын асуулгыг нөхсөн.
- Тооллогын мэдээлэл цуглуулах цахим хуудсанд ухаалаг төхөөрөмж (гар утас, таблет)-өөс нэвтэрч, мэдээллийг нөхөх боломжийг хангасан.

СУРТАЛЧИЛГАА

Тооллого явагдах хугацаанд тооллогын зорилго, ач холбогдлыг олон нийтэд таниулах, мэдээлэл цуглуулалтыг эрчимжүүлэх зорилгоор сурталчилгааны төлөвлөгөө боловсруулж, хэвлэлийн бага хурал, телевиз, сонин, цахим хуудас, олон нийтийн сүлжээний ярилцлага, медиа сурталчилгааны дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

- ААНБ-ын төлөөллөөс бизнесүүдийн нөхцөл байдал, тооллогод хамрагдахын ач холбогдлын талаар санал бодлыг нь харуулсан 20 постер, 9 видео бэлтгэж, тооллогын идэвхжүүлэлт, сурталчилгааны ажилд ашигласан. Тухайлбал: Ник ХК, Шангри-Ла Улаанбаатар, Наран фүүдс ХХК, Говь ХК, НоминТав Трейд ХХК, Хамтын Дэлхий ТББ хамрагдсан.
- ААНБ-ын олон нийтэд танигдсан нөлөө бүхий удирдлагууд, нийгмийн сүлжээнд олон дагагчтай хүмүүсээр уриалуулах, сурталчлах ажлыг зохион байгуулсан.
- ААН-ийн улсын тооллогын сурталчилгааны шторк, видео контентуудыг МҮОНРТ болон өргөн нэвтрүүлгийн 18 сувгаар (ТВ 25, UBS, ТВ5, ТМ, SBN, ТВ8, С1, ТВ9, Central television, NTV, Ийгл ньюс, Монгол ТВ, Стар, VTV, ETV,

- Боловсрол суваг телевиз, Сүлд, Малчин) олон удаагийн давтамжтай цацсан.
- Гадна талбайд байрлах “Бодь” дэлгэцээр, ААН-ийн улсын тооллогын шторк, сурталчилгааны баннерыг өдөрт 100 удаагийн давтамжтай байршуулж, олон нийтэд хүргэсэн.
 - “Нарантуул” худалдааны төвийн гадна самбарт ААН-ийн улсын тооллогын сурталчилгааны самбарыг 14 хоногийн туршид байршуулсан.
 - Ikon.mn, News.mn, Newspress.mn зэрэг сайтуудын холбоонд бүртгэлтэй 80 гаруй сайтад тус бүр 10 хоногийн туршид ААН-ийн тооллогын баннер, постеруудыг байршуулсан.
 - ҮСХ-ны удирдлагууд телевиз, сонин, цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр ААН-ийн тооллогын зорилго, ач холбогдлын талаар 19 удаагийн ярилцлага өгсөн.
 - Скайтел ХХК, Мобиком Корпорац ХХК-тай хамтран тооллогод хамрагдахыг уриалсан агуулга бүхий 5 удаагийн масс зурвас ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд илгээсэн.
 - Тооллогыг эрчимжүүлэх зорилгоор олны танил хүмүүсээр live хийлгэсэн.
 - Төрийн байгууллагуудад тооллогын сурталчилгааны зурагт хуудас, видео хүргүүлж, цахим хуудсанд нь байршуулсан.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Тооллогын мэдээлэл цуглуулах ажлыг Засгийн газраас тогтоосон товын дагуу 11 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 3-ны өдрүүдэд цахим хэлбэрээр, улс даяар зохион байгуулсан. Тус ажлыг ҮСХ-ны тооллогын ажлын хэсэг нэгдсэн удирдлагаар хангаж, орон нутгийн тооллогын Комисс зохион байгуулсан. Тооллогыг улсын хэмжээнд чанартай зохион байгуулах, удирдлагын шуурхай байдлыг хангаж ажиллах зорилгоор сонгогдсон аймаг, нийслэлийн төвийн дүүрэгт ҮСХ-ны албан хаагчид нэгдсэн удирдамжийн дагуу ажиллаж, тооллогын ажилд дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгч, тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэсэн. Тооллогын ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөөг батлуулж, ажлын хэсэг байгуулж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Ажлын хэсгийн гишүүд өөрсдийн хариуцсан аймаг, дүүргийн зах худалдааны төвүүдийн удирдлагуудтай уулзаж, тооллогын зорилго, ач холбогдлыг ойлгуулах, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тооллогод хамруулах;
- Орон нутгийн комисст тооллогыг эрчимжүүлэх албан тоот хүргүүлэх, өөрийн хариуцсан аймаг, дүүргийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Тооллогын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагт хэрэгжүүлж байгаа шинэлэг, үр дүнтэй үйл ажиллагааг бусад аймаг, дүүргүүдэд нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Орон нутгийн тооллогын Комисст тухайн шатны татвар, нийгмийн даатгалын байцаагчдыг татан оролцуулах.

Тооллогын мэдээлэл цуглуулалтад тулгарч буй хүндрэл, бэрхшээл, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, цаашдын төлөвлөгөөний талаарх мэдээллийг өдөр бүр орон нутгийн тооллогын Комиссоос авч, нэгтгэн, ҮСХ-ны тооллогын ажлын хэсэгт танилцуулж, холбогдох арга хэмжээг авсан.

Тооллогын шуурхай хуралдааныг 7 хоног бүрийн Лхагва гарагийн 8.30-09.30 цагт тооллогын ажлын хэсгийн гишүүд, нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн дарга нарыг оролцуулан цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр боломжит бүх эх үүсвэрээс аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчидтэй холбоо тогтоох утасны дугаарын мэдээллийг авч, тооллогын системд оруулах ажлыг хийж гүйцэтгэв.

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Тооллогоор цуглуулсан мэдээллийн үзүүлэлтийн бүрэн бүтэн байдал, уялдаа холбоо, бусад эх үүсвэрүүдтэй уялдуулах шалгалт, шаардлагатай тодотголыг орон нутаг, ҮСХ-нд хийсэн.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, ажил мэргэжлийн ангилал, хариуцлагын болон өмчийн хэлбэр, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны ангилал, кодлолыг нэг бүрчлэн шалгаж, өөрчлөлтийг тусгасан. Эдийн засгийн үзүүлэлтийг статистик, татвар, санхүү, нийгмийн даатгалын тайлангуудтай уялдуулан шалгах дүрэм, түүний алгоритмыг боловсруулж, программчилсан. Мэдээллийг шалгах үйл ажиллагаанд ҮСХ-ны Бизнесийн бүртгэл, тооллогын хэлтэс, Үндэсний тооцооны хэлтэс, Эдийн засгийн статистикийн газрын ажилтнууд оролцсон.

Тооллогын мэдээллийг шалгахад шилэн данс, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, тусгай зөвшөөрөл олгодог яам, агентлаг, төрийн байгууллагуудын цахим хуудас, хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудын цахим хуудсыг ашигласан. Тооллогын үр дүнгийн үзүүлэлтийг MSSQL, SPSS 26.0, ArcGIS программыг ашиглан тооцож боловсруулсан.

3

БҮЛЭГ

А Ж АХУЙН НЭГЖ, **Б** АЙГУУЛЛАГА




БҮЛЭГ 3. | АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА


АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, БАЙРШЛААР

Энэ бүлэгт ААНБ-ын тооны өөрчлөлтийн талаарх мэдээллийг хүргэж байна. ААНБ-ын төвлөрөл нь засаг захиргаа, байгаль, цаг уурын нөхцөл, газар зүйн онцлог, хүн амын шилжих хөдөлгөөн, хүн амын нягтрал зэргээс үүдэн газар зүйн бүс нутгаар нэлээд ялгаатай байдаг. ААНБ-ын тоо 2021 оны тооллогоор 180.0 мянгад хүрч, 2016 оны тооллогын дүнгээс 61.3 мянга (51.7%-аар, 2011 оны тооллогын дүнгээс 114.8 мянга (2.8 дахин)-аар, 2006 оны тооллогын дүнгээс 147.6 мянга (5.6 дахин)-аар, 1998 оны тооллогын дүнгээс 161.1 мянга (9.5 дахин)-аар тус тус нэмэгдсэн байна. Тоологдсон ААНБ-ын 84.2 хувь нь аж ахуйн нэгж, 13.3 хувь нь төрийн бус байгууллага, 2.6 хувь нь төсвийн байгууллага байна. Нийт 151.6 мянган аж ахуйн нэгжийн 74.4 хувь нь, төрийн бус байгууллагын 68.2 хувь нь Улаанбаатар хотод байршиж байна.

ЗУРАГ 3.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, тооллого явагдсан оноор



ЗУРАГ 3.2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, төрөл, 2021 он



ХҮСНЭГТ 3.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, бүс, төрлөөр, 2021 он

Бүс	Аж ахуйн нэгж	Төсвийн байгууллага	Төрийн бус байгууллага
Бүгд	151 557	4 597	23 852
Баруун	8 784	963	1 660
Хангайн	11 473	1 070	2 415
Төвийн	13 968	1 101	2 476
Зүүн	4 613	481	1 031
Улаанбаатар	112 719	982	16 270

Аж ахуйн нэгжийн тоо 2021 оны тооллогоор 151.6 мянга болж, 2016 оны тооллогоос 50.1 мянга (49.4%)-аар, төсвийн байгууллагын тоо 4.6 мянгад хүрч, өмнөх тооллогоос 0.2 мянга (5.1%)-аар, төрийн бус байгууллагын тоо 23.9 мянга болж, өмнөх тооллогоос 11.0 мянга (85.6%)-аар тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 3.2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, төрөл, тооллого явагдсан оноор

Он	Бүгд	Байгууллагын төрөл		
		Аж ахуйн нэгж	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага
1998	18 950	14 040	3 835	1 075
2006	32 410	26 841	3 398	2 171
2011	65 204	55 366	3 959	5 879
2016	118 686	101 463	4 372	12 851
2021	180 006	151 557	4 597	23 852


Нийт 180.0 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 130.0 мянга нь Улаанбаатар хотод байршилтай байгаа нь 2016 оны тооллогын дүнгээс 52.4 хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 3.3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
бүс, аймаг, нийслэл, тооллого явагдсан оноор

Бүс, аймаг, нийслэл	2006	2011	2016	2021	2021	%
					2016	
Бүгд	32 410	65 204	118 686	180 006		151.7
Баруун бүс	2 703	4 466	7 737	11 407		147.4
Баян-Өлгий	543	975	1 529	2 316		151.5
Говь-Алтай	433	520	886	1 265		142.8
Завхан	681	877	1 690	2 328		137.8
Увс	438	925	1 615	2 287		141.6
Ховд	608	1 169	2 017	3 211		159.2
Хангайн бүс	3 488	5 984	10 519	14 958		142.2
Архангай	506	689	1 235	1 607		130.1
Баянхонгор	442	745	1 231	2 153		174.9
Булган	428	717	1 187	1 652		139.2
Орхон	1 101	2 237	3 574	5 051		141.3
Өвөрхангай	531	817	1 445	2 105		145.7
Хөвсгөл	480	779	1 847	2 390		129.4
Төвийн бүс	4 506	7 059	11 229	17 545		156.2
Говьсүмбэр	113	189	385	581		150.9
Дархан-Уул	1 114	1 831	2 988	4 053		135.6
Дорноговь	544	748	1 127	1 951		173.1
Дундговь	420	554	824	1 180		143.2
Өмнөговь	486	866	1 745	3 531		202.3
Сэлэнгэ	1 068	1 711	2 418	3 739		154.6
Төв	761	1 160	1 742	2 510		144.1
Зүүн бүс	1 386	2 242	3 906	6 125		156.8
Дорнод	550	911	1 621	2 560		157.9
Сүхбаатар	331	512	893	1 230		137.7
Хэнтий	505	819	1 392	2 335		167.7
Улаанбаатар	20 327	45 453	85 295	129 971		152.4


Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь зэрэг аймагт аж ахуйн нэгж, байгууллага ихтэй байгаа нь дараах зургаас харагдаж байна.

ЗУРАГ 3.3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТАРХАЛТ, аймаг, нийслэлээр, 2021 он



ААНБ ихээр төвлөрсөн нийслэл Улаанбаатар хотод 130.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага тоологдсон нь 2016 оны тооллогын дүнгээс 44.7 мянга (52.4%)-аар өсжээ. Улаанбаатар хотын ААНБ-ын 26.3 мянга (20.2%) нь Баянзүрх дүүрэгт, 25.4 мянга (19.5%) нь Баянгол дүүрэгт, 24.2 мянга (18.6%) нь Сүхбаатар дүүрэгт, 19.7 мянга (15.2%) нь Хан-Уул дүүрэгт, 16.6 мянга (12.8%) нь Чингэлтэй дүүрэгт, 15.3 мянга (11.8%) нь Сонгинохайрхан дүүрэгт, 1.5 мянга (1.1%) нь Налайх дүүрэгт, 859 (0.7%) нь Багануур дүүрэгт, 153 (0.1%) нь Багахангай дүүрэгт тус тус байршиж байна.

ЗУРАГ 3.4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, дүүргээр, 2016, 2021 он



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭРЭЭ

ААНБ-ын хариуцлагын хэлбэрийг хувьцаат компани (ХК), хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ББН), зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ЗБН), хоршоо, төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ), орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (ОНӨҮГ), төсвийн байгууллага (ТБ), төрийн бус байгууллага (ТББ) гэж ангилдаг. Хэвлэл мэдээллийн байгууллага, боловсрол сургалтын байгууллага, төлөөлөгчийн газар зэрэг аль ч ангилалд хамаарахгүй нэгжүүдийг бусад гэж ангилан хамруулав.

Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын 140.7 мянга (78.2%) нь ХХК, 23.8 мянга (13.2%) нь ТББ, 4.7 мянга (2.6%) нь нөхөрлөл, 4.6 мянга (2.5%) нь төсвийн байгууллага, 4.1 мянга (2.3%) нь хоршоо, 0.4 мянга (0.2%) нь ТӨҮГ болон ОНӨҮГ, 0.3 мянга (0.2%) нь ХК, үлдэх 1.4 мянга (0.8%) нь бусад хэлбэрийн байгууллага байна.

ХҮСНЭГТ 3.4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
хариуцлагын хэлбэр, тооллого явагдсан оноор

Хариуцлагын хэлбэр	2006	2011	2016	2021	2021	%	2021	%
					2011		2016	
Бүгд	32 410	65 204	118 686	180 006		276.1		151.7
ХК	300	276	282	296		107.2		105.0
ХХК	21 528	50 743	93 670	140 700		277.3		150.2
Нөхөрлөл	2 378	2 051	3 045	4 718		230.0		154.9
Хоршоо	2 202	1 677	4 016	4 101		244.5		102.1
ТӨҮГ/ОНӨҮГ	252	256	360	429		167.6		119.2
Төсвийн байгууллага	3 398	3 959	4 372	4 597		116.1		105.1
ТББ	2 171	5 879	12 410	23 764		404.2		191.5
Бусад	181	363	531	1 401		386.0		263.8

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дийлэнх нь Улаанбаатар хотод ногдож, 11.6 мянга (8.3%) нь Төвийн бүсэд, 9.4 мянга (6.7%) нь Хангайн бүсэд, 6.5 мянга (4.6%) нь Баруун бүсэд, 3.8 мянга (2.7%) нь Зүүн бүсэд байрлажээ. Хоршооны 1.3 мянга (31.9%) нь Баруун бүсэд байгаа бол ТӨҮГ, ОНӨҮГ-ын 30.1 хувь нь Төвийн бүсэд байна.

ХҮСНЭГТ 3.5. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
бүс, аймаг, нийслэл, хариуцлагын хэлбэрээр, 2021 он


Бүс, аймаг, нийслэл	Бүгд	Хариуцлагын хэлбэр							
		ХК	ХХК	Нөхөрлөл	Хоршоо	ТӨҮГ, ОНӨҮГ	Төсвийн байгууллага	ТББ	Бусад
Бүгд	180 006	296	140 700	4 718	4 101	429	4 597	23 764	1 401
Баруун бүс	11 407	32	6 499	862	1 309	55	963	1 658	29
Баян-Өлгий	2 316	8	1 322	55	322	3	199	395	12
Говь-Алтай	1 265	4	704	65	116	14	184	175	3
Завхан	2 328	3	1 251	70	394	8	214	381	7
Увс	2 287	13	1 502	66	226	12	180	285	3
Ховд	3 211	4	1 720	606	251	18	186	422	4
Хангайн бүс	14 958	48	9 395	787	1 138	57	1 070	2 409	54
Архангай	1 607	7	796	90	204	10	189	307	4
Баянхонгор	2 153	9	1 059	240	266	9	194	374	2
Булган	1 652	5	1 014	148	126	8	157	189	5
Орхон	5 051	10	3 922	138	72	6	104	772	27
Өвөрхангай	2 105	6	1 148	109	209	10	205	405	13
Хөвсгөл	2 390	11	1 456	62	261	14	221	362	3
Төвийн бүс	17 545	63	11 638	1 338	770	129	1 101	2 471	35
Говьсүмбэр	581	1	345	14	32	6	60	123	-
Дархан-Уул	4 053	24	2 922	253	111	8	111	606	18
Дорноговь	1 951	2	1 242	86	66	15	171	365	4
Дундговь	1 180	4	663	68	93	20	142	189	1
Өмнөговь	3 531	6	2 648	120	100	41	167	446	3
Сэлэнгэ	3 739	14	2 281	632	177	28	228	375	4
Төв	2 510	12	1 537	165	191	11	222	367	5
Зүүн бүс	6 125	17	3 771	433	300	65	481	1 031	27
Дорнод	2 560	9	1 772	87	82	16	162	421	11
Сүхбаатар	1 230	2	702	70	79	21	129	225	2
Хэнтий	2 335	6	1 297	276	139	28	190	385	14
Улаанбаатар	129 971	136	109 397	1 298	584	123	982	16 195	1 256

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ӨМЧИЙН ХЭЛБЭРЭЭР

ААНБ-ыг өмчийн хэлбэрээр нь төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой, төрийн өмчийн гадаадтай хамтарсан; орон нутгийн өмчийн, орон нутгийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн, гадаадтай хамтарсан, Монгол Улсын иргэний өмчийн, гадаад улсын иргэнтэй хамтарсан, гадаад улсын иргэний өмчийн, шашны өмчийн, шашны өмчийн оролцоотой, шашны гадаадтай хамтарсан, олон нийтийн

өмчийн, олон нийтийн оролцоотой, олон нийтийн, гадаадтай хамтарсан гэж ангилдаг. Тооллогод хамрагдсан ААНБ-ын 169.5 мянга (94.1%) нь Монгол Улсын иргэний өмчийн, 5.2 мянга (2.9%) нь төрийн болон орон нутгийн өмчийн, 3.5 мянга (2.0%) нь гадаад улсын иргэний өмчийн, 1.0 мянга (0.6%) нь гадаад улсын иргэнтэй хамтарсан өмчийн, 0.8 мянга (0.5%) нь өмчийн бусад хэлбэрийн байгууллага байна.

ЗУРАГ 3.5. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, өмчийн хэлбэрээр, 2016, 2021 он



Монгол Улсын иргэний өмчийн 169.5 мянган ААНБ-ын 124.0 мянга (73.1%) нь Улаанбаатар хотод, 16.0 мянга (9.5%) нь Төвийн бүсэд, 13.6 мянга (8.1%) нь Хангайн бүсэд, 10.3 мянга (6.0%) нь Баруун бүсэд, 5.5 мянга (3.2%) нь Зүүн бүсэд байршиж байна.

Улаанбаатар хотод байрлах 130.0 мянган ААНБ-ын 124.0 мянга (95.4%) нь Монгол Улсын иргэний өмчийн, 3.4 мянга (2.6%) нь гадаад улсын иргэний өмчийн, 1.2 мянга (0.9%) нь төрийн болон орон нутгийн өмчийн, 0.9 мянга (0.7%) нь гадаад улсын иргэнтэй хамтарсан, 492 (0.4%) нь бусад хэлбэрийн өмчийн хуулийн этгээд байна.

ХҮСНЭГТ 3.6. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, бүс, өмчийн хэлбэрээр, 2021 он

Бүс	Бүгд	Өмчийн хэлбэр				Бусад
		Төрийн болон орон нутгийн өмчийн	Монгол Улсын иргэний өмч	Гадаад улсын иргэний өмч	Гадаад улсын иргэнтэй хамтарсан	
Бүгд	180 006	5 159	169 468	3 555	1 012	812
Баруун	11 407	1 036	10 252	18	25	76
Хангайн	14 958	1 151	13 686	19	10	92
Төвийн	17 545	1 253	16 076	94	26	96
Зүүн	6 125	551	5 490	19	9	56
Улаанбаатар	129 971	1 168	123 964	3 405	942	492

Хоршоо бүхэлдээ, нөхөрлөлийн 99.8 хувь, ТББ-ын 96.4 хувь, ХХК-ийн 96.9 хувь, ХК-ийн 78.0 хувь нь Монгол Улсын иргэний өмчийнх байна.

ХҮСНЭГТ 3.7. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэрээр, 2021 он

Хариуцлагын хэлбэр	Бүгд	Өмчийн хэлбэр				
		Төрийн болон орон нутгийн өмчийн	Монгол Улсын иргэний өмч	Гадаад улсын иргэний өмч	Гадаад улсын иргэнтэй хамтарсан	Бусад
Бүгд	180 006	5 159	169 468	3 555	1 012	812
ХК	296	64	231	-	1	-
ХХК	140 700	69	136 325	3 307	999	-
Нөхөрлөл	4 718	-	4 711	3	4	-
Хоршоо	4 101	-	4 101	-	-	-
ТӨҮГ/ОНӨҮГ	429	429	-	-	-	-
Төсвийн байгууллага	4 597	4 597	-	-	-	-
ТББ	23 764	-	22 903	49	-	812
Бусад	1 401	-	1 197	196	8	-

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР

Ажиллагчдын тоо нь ААНБ-ын үйл ажиллагааны цар хүрээ, чадамжийг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг юм. Иймд, ААН-ийн 2021 оны тооллогоор 2020 онд үйл ажиллагаа явуулсан ААНБ-аас ажиллагчдын тооны мэдээллийг цуглуулж, ажиллагчдын тооны үзүүлэлтийг 2020 онд үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын түвшинд бүлгээр ангилан авч үзлээ.


Үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын тоо 2020 онд 52.4 мянга болж, 2015 оны дүнгээс 3.3 мянга (5.9%-аар буурсан байна. 1-9 ажиллагчтай ААНБ-ын тоо 2020 онд 40.6 мянга байгаа нь 2015 оны дүнгээс 8.4 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 3.8. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
ажиллагчдын тооны бүлгээр, 2005, 2010, 2015, 2020 он

Ажиллагчдын тооны бүлэг	2005	2010	2015	2020	$\frac{2020}{2015}$ %
Бүгд	26 297	47 471	55 638	52 368	94.1
1-9	20 583	38 203	44 383	40 646	91.6
10-19	2 652	4 348	5 042	4 959	98.4
20-49	1 938	3 250	4 033	4 282	106.2
50, түүнээс дээш	1 124	1 670	2 180	2 481	113.8

2020 онд үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын 77.6 хувь нь 1-9 ажиллагчидтай байгаа бол 9.5 хувь нь 10-19 ажиллагчидтай, 8.2 хувь нь 20-49 ажиллагчидтай, 4.7 хувь нь 50, түүнээс дээш ажиллагчидтай байна.

ЗУРАГ 3.6. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ, 2005, 2010, 2015, 2020 он



2020 онд үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын 91.0 хувь нь, санхүүгийн болон даатгалын салбарын 89.6 хувь нь, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын 88.4 хувь нь 1-9 ажиллагчидтай байна.

ХҮСНЭГТ 3.9. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН АНГИЛАЛ, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР, 2020 он

Салбар	Бүгд	Ажиллагчдын тооны бүлэг			
		1-9	10-19	20-49	50, түүнээс дээш
Бүгд	52 368	40 646	4 959	4 282	2 481
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 972	1 743	156	62	11
Уул уурхай, олборлолт	682	404	94	76	108
Боловсруулах үйлдвэрлэл	4 130	3 143	477	311	199
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	272	75	97	47	53
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	129	66	15	15	33

Салбар	Бүгд	Ажиллагчдын тооны бүлэг			
		1-9	10-19	20-49	50, түүнээс дээш
Барилга	3 990	2 738	674	434	144
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	16 648	15 149	857	414	228
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	1 426	986	132	150	158
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1 341	1 004	171	102	64
Мэдээлэл, холбоо	1 199	986	114	60	39
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1 393	1 248	62	40	43
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	933	770	97	40	26
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3 419	2 936	264	127	92
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1 685	1 285	172	147	81
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1 618	496	232	594	296
Боловсрол	2 932	912	407	962	651
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2 136	1 159	433	436	108
Урлаг, үзвэр, тоглоом наадам	730	526	96	66	42
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5 723	5 015	408	195	105
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	10	5	1	4	-

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Энэхүү хэсэгт ААНБ-ын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тогтоож, салбарын болон орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад хэрэгцээтэй мэдээллийг гаргалаа. ААНБ-ын 75.4 мянга (41.9%) нь үйлчилгээний салбарт, 65.8 мянга (36.6%) нь худалдааны салбарт, 16.3 мянга (9.0%) нь аж үйлдвэрийн салбарт, 13.9 мянга (7.7%) нь барилгын салбарт, 8.5 мянга (4.7%) нь хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын тоо 2021 онд өмнөх тооллогын дүнгээс 61.3 хувиар, аж үйлдвэрийн салбарынх 60.6 хувиар, худалдааны чиглэлийнх 46.7 хувиар, хөдөө аж ахуйн чиглэлийнх 36.4 хувиар, барилгын чиглэлийнх 30.4 хувиар тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 3.10. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
үйл ажиллагааны чиглэлээр, 2016, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	2016		2021		2021
	Тоо	%	Тоо	%	2016
Бүгд	118 686	100.0	180 006	100.0	151.7
Хөдөө аж ахуй	6 263	5.3	8 544	4.7	136.4
Аж үйлдвэр	10 139	8.5	16 285	9.0	160.6
Барилга	10 649	9.0	13 885	7.7	130.4
Худалдаа	44 871	37.8	65 847	36.6	146.7
Үйлчилгээ	46 764	39.4	75 445	41.9	161.3

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 63.4 мянга (45.0%) нь худалдааны салбарт, 43.2 мянга (30.7%) нь үйлчилгээний салбарт, 14.5 мянга (10.3%) нь аж үйлдвэрийн салбарт, 5.9 мянга (4.2%) нь хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 3.11. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
хариуцлагын хэлбэр, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он

Хариуцлагын хэлбэр	Бүгд	Үйл ажиллагааны чиглэл				
		ХАА	Аж үйлдвэр	Барилга	Худалдаа	Үйлчилгээ
Бүгд	180 006	8 544	16 285	13 885	65 847	75 445
ХК	296	36	105	44	27	84
ХХК	140 700	5 885	14 483	13 743	63 367	43 222
Нөхөрлөл	4 718	991	928	54	1 082	1 663
Хоршоо	4 101	1 279	601	28	1 297	896
ТӨҮГ/ОНӨҮГ	429	37	141	14	55	182
Төсвийн байгууллага	4 597	30	-	-	-	4 567
ТББ	23 764	284	21	-	-	23 459
Бусад	1 401	2	6	2	19	1 372

Монгол Улсын иргэний өмчийн ААНБ-ын 68.6 мянга (40.5%) нь үйлчилгээний салбарт, 63.4 мянга (37.4%) нь худалдааны салбарт, 15.5 мянга (9.1%) нь аж үйлдвэрийн салбарт, 13.6 мянга (8.0%) нь барилгын салбарт, 8.4 мянга (5.0%) нь хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Гадаад улсын иргэнтэй хамтарсан өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын 491 (48.5%) нь худалдааны салбарт, 270 (26.7%) нь үйлчилгээний салбарт, 172 (17.0%) нь аж үйлдвэрийн салбарт, 62 (6.1%) нь барилгын салбарт, 17 (1.7%) нь хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Аж үйлдвэрийн салбарын ААНБ-ын 15.5 мянга (95.0%) нь Монгол Улсын иргэний өмчийн, 444 (2.7%) нь гадаад улсын иргэний өмчийн, 199 (1.2%) нь төрийн болон орон нутгийн өмчийн, 172 (1.1%) нь гадаад улсын иргэнтэй хамтарсан байгууллага байна.

ХҮСНЭГТ 3.12. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, өмчийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он

Өмчийн хэлбэр	Бүгд	Үйл ажиллагааны чиглэл				
		ХАА	Аж үйлдвэр	Барилга	Худалдаа	Үйлчилгээ
Бүгд	180 006	8 544	16 285	13 885	65 846	75 446
Төрийн болон орон нутгийн өмчийн	5 159	68	199	37	64	4 791
Монгол Улсын иргэний өмч	9 468	401	469	85	3 447	566
Гадаад улсын иргэний өмч	3 555	50	444	201	1 845	1 015
Гадаад улсын иргэнтэй хамтарсан	1 012	17	172	62	491	270
Бусад	812	8	1	-	-	803

Аж ахуйн нэгжийн тоо 2021 онд 2016 оны тооллогын дүнгээс 50.1 мянга (49.4%-аар нэмэгдэж, 151.6 мянга болжээ. Харин боловсруулах салбарын нэгжийн тоо 2016 оны тооллогын дүнгээс 61.6 хувиар, уул уурхайн салбарын нэгж 58.3 хувиар, худалдааны салбарын нэгж 46.8 хувиар, үйлчилгээний бусад салбарын нэгж 43.1 хувиар тус тус нэмэгджээ.

Аж ахуйн нэгжийн 43.4 хувь нь худалдааны салбарт байгаа бол 9.2 хувь нь барилгын салбарт, 8.6 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 6.4 хувь нь мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт, 6.3 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг байна.

ХҮСНЭГТ 3.13. АЖ АХУЙН НЭГЖ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, тооллого явагдсан оноор

Салбар	2016		2021		2021 / 2016 %
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Бүгд	101 463	100.0	151 557	100.0	149.4
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6 051	6.0	8 230	5.4	136.0
Уул уурхай, олборлолт	1 631	1.6	2 582	1.7	158.3
Боловсруулах үйлдвэрлэл	8 044	7.9	12 996	8.6	161.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	244	0.2	381	0.3	156.1

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Салбар	2016		2021		$\frac{2021}{2016}$ %
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	203	0.2	304	0.2	149.8
Барилга	10 648	10.5	13 885	9.2	130.4
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	44 870	44.2	65 847	43.4	146.8
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	2 273	2.2	5 071	3.3	223.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3 365	3.3	4 791	3.2	142.4
Мэдээлэл, холбоо	2 425	2.4	4 609	3.0	190.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3 247	3.2	4 167	2.7	128.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1 380	1.4	2 022	1.3	146.5
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	6 303	6.2	9 706	6.4	154.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	6 009	5.9	9 613	6.3	160.0
Боловсрол	1 343	1.3	2 517	1.7	187.4
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1 919	1.9	2 547	1.7	132.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	379	0.4	673	0.4	177.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1 129	1.1	1 616	1.1	143.1

4

БҮЛЭГ

ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ



БҮЛЭГ 4. | ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ХЭЛБЭР

Аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагдсан хэлбэрийг шинээр байгуулагдсан, нийлүүлсэн, нэгдсэн, хуваасан, тусгаарлагдсан, өөрчлөн зохион байгуулсан гэж ангилан авч үздэг. Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 96.7 хувь нь шинээр үүсгэн байгуулагдаж, үлдсэн 3.3 хувь нь бусад хэлбэр (нийлүүлсэн, нэгдсэн, хуваагдсан, тусгаарлагдсан, өөрчлөгдсөн)-ээр үүсгэн байгуулагдсан байна. Аж ахуйн нэгжийн тооны үүсгэн байгуулагдсан хэлбэрт эзлэх хувийг өмнөх тооллогын дүнтэй харьцуулбал, шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж нэг нэгж хувиар нэмэгдэж, нийлүүлсэн болон өөрчлөгдсөн аж ахуйн нэгж тус бүр 0.4 нэгж хувиар, нэгдсэн аж ахуйн нэгж 0.1 нэгж хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 4.1. АЖ АХУЙН НЭГЖ, үүсгэн байгуулагдсан хэлбэр, тооллого явагдсан оноор

Үүсгэн байгуулагдсан хэлбэр	2011		2016		2021		2021 / 2016 %
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	
Бүгд	55 366	100.0	101 463	100.0	151 557	100.0	149.4
Шинээр байгуулагдсан	53 321	96.3	98 501	97.1	148 574	98.0	150.8
Нийлүүлсэн	814	1.5	1 164	1.1	1 164	0.8	100.0
Нэгдсэн	87	0.2	308	0.3	257	0.2	83.4
Хуваасан	95	0.2	101	0.1	124	0.1	122.8
Тусгаарлагдсан	227	0.4	195	0.2	249	0.2	127.7
Өөрчлөгдсөн	584	1.1	1 125	1.1	1 022	0.7	90.8
Бусад	238	0.4	69	0.1	167	0.1	242.0

Сүүлийн 2 тооллогын дүнг харьцуулахад нэгдсэн аж ахуйн нэгжийн тоо 2021 онд 16.6 хувиар, өөрчлөгдсөн нэгжийн тоо 9.2 хувиар буурчээ. Харин шинээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж 50.8 хувь, тусгаарласан аж ахуйн нэгж 27.7 хувь, хуваасан аж ахуйн нэгж 22.8 хувиар тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 4.2. АЖ АХУЙН НЭГЖ, үүсгэн байгуулагдсан хэлбэр, бүсээр, 2021 он

Үүсгэн байгуулагдсан хэлбэр	Бүгд	Бүс				
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар
Бүгд	151 557	8 784	11 473	13 968	4 613	112 719
Шинээр байгуулагдсан	148 574	8 532	11 144	13 557	4 473	110 868
Нийлүүлсэн	1 164	85	122	102	38	817
Нэгдсэн	257	24	26	44	18	145
Хуваасан	124	9	20	21	5	69
Тусгаарлагдсан	249	27	27	51	6	138
Өөрчлөгдсөн	1 022	101	125	185	64	547
Бусад	167	6	9	8	9	135

Шинээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж давамгайлж, тэдгээрийн 74.4 хувь нь Улаанбаатар хотод, 9.1 хувь нь Төвийн бүсэд, 7.5 хувь нь Хангайн бүсэд, 5.7 хувь нь Баруун бүсэд, 3.0 хувь нь Зүүн бүсэд ногдож байна. Тусгаарлагдсан аж ахуйн нэгжийн 55.4 хувь нь Улаанбаатар хотод, 20.5 хувь нь Төвийн бүсэд, Хангай, Баруун бүсэд тус бүр 10.8 хувь нь, 2.4 хувь нь Зүүн бүсэд байна. Өөрчлөгдсөн аж ахуйн нэгжийн 53.5 хувь нь Улаанбаатар хотод, 18.1 хувь нь Төвийн бүсэд, 12.2 хувь нь Хангайн бүсэд, 9.9 хувь нь Баруун бүсэд, 6.3 хувь нь Зүүн бүсэд тус тус байрлаж байна.

ХҮСНЭГТ 4.3. АЖ АХУЙН НЭГЖ, үүсгэн байгуулагдсан хэлбэр, хариуцлагын хэлбэрээр, 2021 он

Үүсгэн байгуулагдсан хэлбэр	Бүгд	Хариуцлагын хэлбэр				
		Компани	Хоршоо	Нөхөрлөл	ТӨҮГ,ОНӨҮГ	Бусад
Бүгд	151 557	140 996	4 101	4 718	429	1 313
Шинээр байгуулагдсан	148 574	138 507	3 884	4 550	348	1 285
Нийлүүлсэн	1 164	952	123	76	7	6
Нэгдсэн	257	192	30	24	8	3
Хуваасан	124	102	7	5	10	-
Тусгаарлагдсан	249	212	6	7	22	2
Өөрчлөгдсөн	1 022	883	47	51	32	9
Бусад	167	148	4	5	2	8

Аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагдсан хэлбэр бүрд хязгаарлагдмал хариуцлагатай компани голлох байр суурьтай байна. Тухайлбал, тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагдсан болон хариуцлагын хэлбэрээр авч үзвэл, нийт 151.6 мянган аж ахуйн нэгжээс 148.6 мянга (98.0%) нь шинээр үүсгэн байгуулагдсан ба тэдгээрийн 138.3 мянга буюу 93.1 хувь нь ХХК байна.

ХҮСНЭГТ 4.4. АЖ АХУЙН НЭГЖ, үүсгэн байгуулагдсан хэлбэр, өмчийн хэлбэрээр, 2021 он

Үүсгэн байгуулагдсан хэлбэр	Бүгд	Өмчийн хэлбэр			
		Төрийн болон орон нутгийн өмчит	Монгол Улсын иргэний хувийн	Гадаад улсын	Гадаад улсын иргэнтэй хамтарсан
Бүгд	151 557	562	146 477	3 506	1 012
Шинээр байгуулагдсан	148 574	449	143 805	3 373	947
Нийлүүлсэн	1 164	13	1 069	36	46
Нэгдсэн	257	9	232	10	6
Хуваасан	124	15	105	4	-
Тусгаарлагдсан	249	27	212	7	3
Өөрчлөгдсөн	1 022	47	904	61	10
Бусад	167	2	50	15	-

Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулагдсан болон өмчийн хэлбэрээр авч үзвэл, шинээр үүсгэн байгуулагдсан 148.6 мянган нэгжийн 143.8 мянга (96.8%) нь Монгол Улсын иргэний хувийн аж ахуйн нэгж байна.

ХҮСНЭГТ 4.5. АЖ АХУЙН НЭГЖ, үүсгэн байгуулагдсан хэлбэр, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он


Үүсгэн байгуулагдсан хэлбэр	Бүгд	Үйл ажиллагааны чиглэл				
		ХАА	Аж үйлдвэр	Барилга	Худалдаа	Үйлчилгээ
Бүгд	151 557	8 230	16 263	13 885	65 847	47 332
Шинээр байгуулагдсан	148 574	7 994	15 868	13 656	64 741	46 315
Нийлүүлсэн	1 164	76	139	80	485	384
Нэгдсэн	257	26	20	22	85	104
Хуваасан	124	14	18	24	30	38
Тусгаарлагдсан	249	39	40	17	84	69
Өөрчлөгдсөн	1 022	73	160	79	359	351
Бусад	167	8	18	7	63	71

Аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагдсан хэлбэр тус бүрд худалдаа, үйлчилгээний чиглэлийн нэгж 31.2-43.6 хувийг эзэлж, давамгайлах хандлагатай байна. Шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжийн 43.6 хувь нь худалдаа, 31.2 хувь нь үйлчилгээ, 10.7 хувь нь аж үйлдвэр, 9.2 хувь нь барилга, 5.4 хувь нь хөдөө аж ахуйн чиглэлээр байгуулагдсан байна. Харин аж ахуйн нэгжийн тусгаарлагдсан аж ахуйн нэгжийн 33.7 хувь нь худалдаа, 27.7 хувь нь үйлчилгээ, 16.1 хувь нь аж үйлдвэр, 15.7 хувь нь ХАА, 6.8 хувь нь барилгын чиглэлээр байгуулагдсан байна.


ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн 56.8 мянга буюу 37.5 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа, харин 94.7 мянга нь үйл ажиллагаагаа тодорхой шалтгааны улмаас явуулаагүй байна.

ЗУРАГ 4.1. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ



ЗУРАГ 4.2. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, тооллого явагдсан оноор



Идэвхгүй буюу үйл ажиллагаагаа явуулаагүй аж ахуйн нэгжийн тоо 2011 онд 2006 оныхоос 2.9 дахин, 2016 онд 2011 оныхоос 3.1 дахин нэмэгдэж байсан бол 2021 онд 2016 оныхоос 70.9 хувиар нэмэгдэж, 94.7 мянгад хүрсэн байна. Үйл ажиллагаагаа явуулаагүй аж ахуйн нэгж 2006 болон 2011 онд 22.9-31.4 хувь, 2016 онд 53.8 хувь, 2021 онд 62.5 хувь буюу 8.7 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 4.6. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ,
бүс, тооллого явагдсан оноор

Бүс	2011		2016		2021		2016	2021
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	2011 %	2016 %
Бүгд	37 633	100.0	46 029	100.0	56 832	100.0	122.3	123.5
Баруун	2 773	7.4	4 094	8.9	4 522	8.0	147.6	110.5
Хангайн	3 573	9.5	4 779	10.4	5 106	9.0	133.8	106.8
Төвийн	4 227	11.2	5 286	11.5	5 665	10.0	125.1	107.2
Зүүн	1 294	3.4	1 843	4.0	2 109	3.7	142.4	114.4
Улаанбаатар	25 766	68.5	30 027	65.2	39 430	69.4	116.5	131.3

Үйл ажиллагаа явуулж байгаа нийт 56.8 мянган аж ахуйн нэгжийг бүсээр авч үзвэл, 39.4 мянга буюу 69.4 хувь нь Улаанбаатар хотод, 5.7 мянга буюу 10.0 хувь нь Төвийн бүсэд, 5.1 мянга буюу 9.0 хувь нь Хангайн бүсэд, 4.5 мянга буюу 8.0 хувь нь Баруун бүсэд, үлдсэн 2.1 мянга буюу 3.7 хувь нь Зүүн бүсэд ногдож байна. Түүнчлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо 2016 оны тооллогын дүнгээс Улаанбаатар хотод 31.3 хувь, Зүүн бүсэд 14.4 хувь, Баруун бүсэд 10.5 хувь, Төвийн бүсэд 7.2 хувь, Хангайн бүсэд 6.8 хувиар өсжээ.


ХҮСНЭГТ 4.7. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ,
хариуцлага, өмчийн хэлбэрээр, 2021 он

Хариуцлагын хэлбэр	Бүгд	Өмчийн хэлбэр			
		Төрийн болон орон нутгийн өмчийн	Монгол Улсын иргэний хувийн	Гадаад улсын	Гадаад улсын иргэнтэй хамтарсан
Бүгд	56 832	447	54 393	1 607	385
Компани	53 006	119	51 008	1 503	376
Хоршоо	1 474	-	1 474	-	-
Нөхөрлөл	1 403	-	1 397	2	4
ТӨҮГ, ОНӨҮГ	328	328	-	-	-
Бусад	621	-	514	102	5

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж хариуцлагын хэлбэрээрээ 93.3 хувь нь компани, 2.6 хувь нь хоршоо байна. Өмчийн хэлбэрээрээ Монгол Улсын иргэний хувийн аж ахуйн нэгж 95.7 хувийг бүрдүүлж, давамгайлсан байна. Монгол

Улсын иргэний хувийн, гадаад улсын хувийн, гадаадтай хамтарсан хувийн өмчийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид компани дийлэнх хувийг эзэлж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа 53.0 мянган компанийн 51.0 мянга буюу 96.2 хувь нь Монгол Улсын иргэний хувийн компани байна.

ЗУРАГ 4.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, үйл ажиллагааны чиглэл, дүнд эзлэх хувиар, 2016, 2021 он




Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 23.0 мянга буюу 40.5 хувь нь худалдааны, 19.1 мянга буюу 33.6 хувь нь үйлчилгээний, 6.8 мянга буюу 11.9 хувь нь аж үйлдвэрийн, 5.4 мянга буюу 9.5 хувь нь барилгын, 2.6 мянга буюу 4.5 хувь нь хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна. 2016 оны тооллогын дүнтэй харьцуулахад, хөдөө аж ахуйн салбар 2.0 нэгж хувиар, барилгын салбар 1.6 нэгж хувиар тус тус буурсан бол худалдааны салбар 2.2 нэгж хувиар, аж үйлдвэрийн 1.4 нэгж хувиар тус тус өссөн байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 16.1 мянга (28.3%) нь үүсгэн байгуулагдсанаас хойш 6-10 жил, 14.4 мянга (25.4%) нь 2-5 жил, 10.4 мянга (18.4%) нь 11-15 жил үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 4.8. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, ажиллаж буй хугацаа, ажиллагчдын тооны бүлгээр, 2021 он


Ажиллаж буй хугацаа	Бүгд	Ажиллагчдын тооны бүлэг					100, түүнээс дээш
		1-4	5-9	10-19	20-49	50-99	
Бүгд	56 832	39 729	8 430	4 493	2 634	817	729
0-1 жил	6 763	5 652	690	266	117	22	16
2-5 жил	14 431	10 846	1 951	887	484	145	118
6-10 жил	16 071	11 221	2 570	1 305	647	199	129
11-15 жил	10 437	6 870	1 630	999	617	176	145
16, түүнээс дээш	9 130	5 140	1 589	1 036	769	275	321

ЗУРАГ 4.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖ, үйл ажиллагааг явуулаагүй шалтгаанаар, 2021 он



Үйл ажиллагаа явуулаагүй 94.7 мянган аж ахуйн нэгжийн 45.9 мянга (48.5%) нь түр зогссон, 29.5 мянга (31.1%) нь эхлээгүй, 18.8 мянга (19.8%) нь бүрэн зогссон, 0.6 мянга (0.6%) нь бусад шалтгаантай байна.

ЗУРАГ 4.5. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖ, хариуцлагын хэлбэрээр




Үйл ажиллагаа явуулаагүй нийт 94.7 мянган аж ахуйн нэгжээс дийлэнх нь буюу 88.0 мянга нь компани, 3.3 мянга нь нөхөрлөл, 2.6 мянга нь хоршоо байна. 2016 оны тооллогын дүнтэй харьцуулахад компани 35.6 мянга буюу 68.0 хувиар, хоршоо 1.0 мянга буюу 61.8 хувиар, нөхөрлөл 1.9 мянга буюу 2.4 дахин, ТӨҮГ болон ОНӨҮГ 57 нэгжээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 4.9. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖ,
үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан, хариуцлагын хэлбэрээр, 2021 он

Шалтгаан	Бүгд	Хариуцлагын хэлбэр				
		Компани	Хоршоо	Нөхөрлөл	ТӨҮГ, ОНӨҮГ	Бусад
Бүгд	94 725	87 990	2 627	3 315	101	692
Эхлээгүй	29 454	27 827	364	1 101	18	144
Түр зогссон	45 919	43 031	1 232	1 302	32	322
Бүрэн зогссон	18 764	16 575	1 015	899	49	226
Бусад	588	557	16	13	2	-

Үйл ажиллагаа эхлээгүй аж ахуйн нэгжийн 94.5 хувь нь түр зогссон нэгжийн 93.7 хувь нь, бүрэн зогссон нэгжийн 93.7 хувь нь, бусад шалтгаантай нэгжийн 94.7 хувь нь компани байна.

ЗУРАГ 4.6. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭЗЛЭХ ХУВЬ,
үйл ажиллагааны чиглэлээр, 2016, 2021 он



Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжид үйл ажиллагаа явуулаагүйн эзлэх хувийг үйл ажиллагааны чиглэлээр харахад өмнөх тооллогын дүнгээс хөдөө аж ахуйн салбарынх 18.7 нэгж хувиар, үйлчилгээний салбарынх 13.1 нэгж хувиар, барилгын салбарынх 9.3 нэгж хувиар, аж үйлдвэрийн салбарынх 7.0 нэгж хувиар, худалдааны салбарынх 4.9 нэгж хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 4.10. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖ,
үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он

Шалтгаан	Бүгд	Үйл ажиллагааны чиглэл				
		ХАА	Аж үйлдвэр	Барилга	Худалдаа	Үйлчилгээ
Бүгд	94 725	5 671	9 508	8 470	42 839	28 237
Эхлээгүй	29 454	1 755	2 804	2 538	12 998	9 359
Түр зогссон	45 919	2 651	4 551	4 305	21 159	13 253
Бүрэн зогссон	18 764	1 244	2 098	1 563	8 412	5 447
Бусад	588	21	55	64	270	178

Үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл, 45.2 хувь нь худалдааны салбарт, 29.8 хувь нь үйлчилгээний салбарт, 10.0 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 8.9 хувь нь барилгын салбарт, 6.0 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулаагүй 8.5 мянган нэгж байгаагаас, үйл ажиллагаа эхлээгүй 2.5 мянга, түр зогссон 4.3 мянга, бүрэн зогссон 1.6 мянга, бусад шалтгаантай 64 нэгж байна. хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжийн 46.7 хувь нь үйл ажиллагаа түр зогссон, 30.9 хувь нь эхлээгүй, 21.9 хувь нь бүрэн зогссон, 0.4 хувь нь бусад шалтгаантай байна.


Үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжийн 30.8 мянга (32.5%) нь үүсгэн байгуулагдаад 6-10 жил, 25.9 мянга (27.3%) нь 2-5 жил, 16.4 мянга (17.3%) нь 11-15 жил болсон байна. Харин үүсгэн байгуулагдаад 16, түүнээс жил болсон 8.2 мянган нэгжийн 4.9 мянга (59.3%) нь түр зогссон, 2.6 мянга (32.1%) нь бүрэн зогссон байна.

ХҮСНЭГТ 4.11. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖ, ажиллаж буй хугацаа, үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар, 2021 он


Ажиллаж буй хугацаа	Бүгд	Шалтгаан			
		Эхлээгүй	Түр зогссон	Бүрэн зогссон	Санхүүгийн эх үүсвэр хангалтгүй
Бүгд	94 725	29 454	45 919	18 764	588
0-1 жил	13 464	9 108	3 744	560	52
2-5 жил	25 854	10 228	12 021	3 495	110
6-10 жил	30 803	7 339	15 897	7 350	217
11-15 жил	16 409	2 137	9 401	4 726	145
16, түүнээс дээш	8 195	642	4 856	2 633	64

Сүүлийн 2 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан 46.0 мянган аж ахуйн нэгжийн 36.3 мянга буюу 79.0 хувь нь 2019 он болон 2020 онд татварт идэвхтэй тайлан өгсөн байна.

ЗУРАГ 4.7. СҮҮЛИЙН 2 ЖИЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АХУЙН НЭГЖ, татварын тайланд хамрагдсан байдал, 2021 он



ЗУРАГ 4.8. ТАТАН БУУГДАХ ХҮСЭЛТЭЙ, СҮҮЛИЙН ХОЁР ЖИЛ ДАРААЛАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖ, 2021 он




Сүүлийн хоёр жил үйл ажиллагаа явуулаагүй нэгжийн 14.9 мянга (14.1%) нь татан буугдах хүсэлтэй байна.

Татан буугдах хүсэлтэй 14.9 мянган нэгжийн 6.5 мянга буюу 43.5 хувь нь татварт 2019 он болон 2020 онд тайлан өгөөгүй бол 4.4 мянга буюу 29.5 хувь нь х тайлан өгсөн байна.

Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 4.4 мянга буюу 2.9 хувь нь аж ахуйн нэгжийн нэрээсээ өөр нэрээр үйл ажиллагаа явуулдаг оноосон нэртэй байна.

ЗУРАГ 4.9. ТАТАН БУУГДАХ ХҮСЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ,
татварын тайланд хамрагдсан байдал, 2021 он



ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ БАЙР, ГАЗРЫН ЭЗЭМШИЛ

Тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулдаг газрын эзэмшлийн талаарх мэдээллийг энэ хэсэгт авч үзлээ. Эдгээрийн 60.0 мянга буюу 39.6 хувь нь гэртээ, 30.3 мянга буюу 20.0 хувь нь түрээсийн, 29.8 мянга буюу 19.7 хувь нь үүсгэн байгуулагчийн, 16.1 мянга буюу 10.6 хувь нь аж ахуйн нэгжийн, 9.6 мянга буюу 6.3 хувь нь тогтсон байргүй, 5.1 мянга буюу 3.4 хувь нь дундын оффистой, 0.7 мянга буюу 0.4 хувь нь бусад хэлбэрийн эзэмшлийн байранд үйл ажиллагаа явуулж байна.

Нийт 151.6 мянган аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж буй байрны эзэмшлийн хэлбэрийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл, барилга, дэд бүтцийн салбарын 44.7 хувь буюу 6.5 мянга нь, хөдөө аж ахуйн салбарын 42.8 хувь буюу 3.5 мянга нь, худалдааны салбарын 40.7 хувь буюу 26.8 мянга нь гэртээ үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 4.10. АЖ АХУЙН НЭГЖ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛДАГ БАЙРНЫ ЭЗЭМШИЙН
хэлбэрээр, 2021 он



ХҮСНЭГТ 4.12. АЖ АХУЙН НЭГЖ, үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрны эзэмшлийн хэлбэр, хувиар, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	Бүгд	Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрныхаа эзэмшлийн хэлбэр				
		Аж ахуйн нэгжийн	Үүсгэн байгуулагчийн	Түрээсийн	Гэртээ	Бусад
Бүгд	100.0%	10.6%	19.7%	20.0%	39.6%	10.1%
Хөдөө аж ахуй	100.0%	14.4%	25.6%	7.4%	42.8%	9.8%
Уул уурхай	100.0%	13.5%	15.5%	21.3%	36.8%	12.8%
Боловсруулах	100.0%	13.8%	22.1%	21.3%	33.8%	9.0%
Барилга, дэд бүтэц	100.0%	9.9%	16.8%	17.2%	44.7%	11.4%
Худалдаа	100.0%	9.7%	20.9%	18.4%	40.7%	10.3%
Үйлчилгээ	100.0%	10.4%	17.4%	24.8%	37.6%	9.8%
Боловсрол	100.0%	11.1%	23.8%	29.0%	27.5%	8.6%
Зочид буудал, зоогийн газар	100.0%	16.1%	22.5%	24.7%	27.9%	8.8%
Санхүү, даатгал	100.0%	7.4%	12.8%	35.1%	35.5%	9.2%
Тээвэр, агуулах	100.0%	8.5%	17.3%	18.6%	45.6%	10.0%
Удирдлага	100.0%	8.1%	16.7%	18.3%	45.9%	11.0%
Урлаг, үзвэр	100.0%	7.4%	15.0%	24.8%	42.9%	9.8%
Үл хөдлөх хөрөнгө	100.0%	27.5%	19.8%	18.0%	25.3%	9.5%
Шинжлэх ухаан	100.0%	8.9%	16.6%	25.1%	39.6%	9.9%
Эрүүл мэнд	100.0%	18.2%	21.6%	38.5%	13.9%	7.9%
Бусад	100.0%	6.8%	14.2%	27.7%	41.3%	9.9%

Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 112.7 мянга буюу 74.4 хувь нь Улаанбаатар хотод байгаагийн 8.9 мянга нь үйлдвэрлэл, үйлчилгээгээ аж ахуйн нэгжийн эзэмшлийн байранд явуулж байгаа бол 18.5 мянга нь үүсгэн байгуулагчийн эзэмшлийн, 25.8 мянга нь түрээсийн эзэмшлийн, 47.6 мянга нь гэртээ үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 4.13. АЖ АХУЙН НЭГЖ, бүс, үйл ажиллагаагаа явуулдаг байрны эзэмшлийн хэлбэрээр, 2021 он

Бүс	Бүгд	Аж ахуйн нэгжийн	Үүсгэн байгуулагчийн	Түрээсийн	Гэртээ	Дундын оффис	Бусад	Байргүй
Бүгд	151 557	16 070	29 817	30 312	59 984	5 084	678	9 612
Баруун	8 784	1 986	3 024	842	2 400	106	36	390
Хангайн	11 473	1 972	2 900	1 333	3 643	160	45	1 420
Төвийн	13 968	2 241	4 013	1 819	4 836	245	69	745
Зүүн	4 613	938	1 337	536	1 512	85	13	192
Улаанбаатар	112 719	8 933	18 543	25 782	47 593	4 488	515	6 865

Гэртээ үйл ажиллагаа явуулж байгаа 60.0 мянган нэгжийн 79.3 хувь нь Улаанбаатар хотод, 8.1 хувь нь Төвийн бүсэд, 6.1 хувь нь Хангайн бүсэд, 4.0 хувь нь Баруун бүсэд, 2.5 хувь нь Зүүн бүсэд байна. Аж ахуйн нэгжийн эзэмшлийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн 55.6 хувь нь Улаанбаатар хотод, 13.9 хувь нь Төвийн бүсэд, 12.4 хувь нь Баруун бүсэд, 12.3 хувь нь Хангайн бүсэд, 5.8 хувь нь Зүүн бүсэд байршиж байна. Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 85.1 хувь нь Улаанбаатар хотод байна.

ХҮСНЭГТ 4.14. АЖ АХУЙН НЭГЖ, үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа явуулдаг байрны эзэмшлийн хэлбэрээр, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	Бүгд	Байрны эзэмшлийн хэлбэр						
		Өөрийн эзэмшлийн	Үүсгэн байгуулагчийн	Түрээсийн	Гэртээ	Дундын оффис	Бусад	Байргүй
Бүгд	151 557	16 070	29 817	30 312	59 984	5 084	678	9 612
ХАА	8 230	1 186	2 111	607	3 520	159	32	615
Аж үйлдвэр	16 263	2 411	3 390	3 417	5 494	464	64	1 023
Барилга	13 885	1 170	2 341	2 405	6 359	483	153	974
Худалдаа	65 847	6 379	13 733	12 127	26 819	2 366	212	4 211
Үйлчилгээ	47 332	4 924	8 242	11 756	17 792	1 612	217	2 789

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулдаг байрны эзэмшлийг эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл, дундын оффистой үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн 46.5 хувь нь худалдааны салбарт, 31.7 хувь нь үйлчилгээний салбарт байгаа бол түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 40.0 хувь нь худалдааны салбарт, 38.8 хувь нь үйлчилгээний салбарт, 11.3 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 7.9 хувь нь барилгын салбарт, 2.0 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.

Үйл ажиллагаа явуулдаг байр нь үүсгэн байгуулагчийн эзэмшлийнх байдаг ААН-ийн 46.1 хувь нь худалдааны салбарт, 27.6 хувь нь үйлчилгээний салбарт, 11.4 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 7.9 хувь нь барилгын салбарт, 7.1 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.

Тогтсон байргүй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 43.8 хувь нь худалдааны салбарт байгаа бол 29.0 хувь нь үйлчилгээний салбарт, 10.6 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 10.1 хувь нь барилгын салбарт, 6.4 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрны эзэмшлийн хэлбэр нь аж ахуйн нэгжийн өөрийн болон үүсгэн байгуулагчийн гэж хариулсан 45.9 мянган нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг газрын эзэмшлийн хэлбэрийг судалсан бөгөөд эдгээрийн 12.3 хувь буюу 5.6 мянга нь газаргүй гэж хариулсан байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний газрын эзэмшлийн хэлбэрийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл, боловсруулах салбарын 35.4 хувь буюу 1.7 мянга нь аж ахуйн нэгжийн, 56.1 хувь буюу 2.6 мянга нь үүсгэн байгуулагчийн эзэмшлийн газартай байна.


ХҮСНЭГТ 4.15. АЖ АХУЙН НЭГЖ, үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг үйлдвэрлэл, үйлчилгээний газрын эзэмшлийн хэлбэр, дүнд эзлэх хувиар, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	Бүгд	Газрын эзэмшлийн хэлбэр				
		Аж ахуйн нэгжийн	Үүсгэн байгуулагчийн	Түрээсийн	Бусад	Газаргүй
Бүгд	100.0	31.4	55.0	1.2	0.3	12.3
Хөдөө аж ахуй	100.0	35.8	55.7	0.6	0.2	7.7
Уул уурхай	100.0	43.7	41.8	1.2	0.8	12.6
Боловсруулах	100.0	35.4	56.1	1.4	0.4	6.7
Барилга	100.0	32.9	50.2	1.0	0.4	15.5
Худалдаа	100.0	27.8	58.9	1.2	0.2	11.8
Үйлчилгээ	100.0	33.0	50.5	1.2	0.2	15.1

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод компьютер, ухаалаг төхөөрөмж, сүлжээний төрөл, интернэт ашигладаг ажиллагчид, өгөгдлийн сан, дата сервертэй эсэх, гэрээсээ цахимаар ажиллах боломжтой ажиллагчдын хувь зэрэг мэдээллийн технологийн үндсэн үзүүлэлтүүдийг шинээр тусгасан.

ЗУРАГ 4.11. АЖ АХУЙН НЭГЖ, компьютерын хэрэглээ, дүнд эзлэх хувиар, 2021 он



Сүүлийн 2 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй 46.0 мянган аж ахуйн нэгжийн 37.0 мянга буюу 80.5 хувь нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа 236.5 мянган компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж байна.

Компьютер, ухаалаг төхөөрөмжийн 134.2 мянга буюу 56.7 хувь нь суурин компьютер, 64.1 мянга буюу 27.1 хувь нь зөөврийн компьютер, 9.2 мянга буюу 3.9 хувь нь таблет, 29.0 мянга буюу 12.3 хувь нь ухаалаг бусад төхөөрөмж эзэлж байна.

ЗУРАГ 4.12. АЖ АХУЙН НЭГЖИЙН АШИГЛАДАГ КОМПЬЮТЕР, УХААЛАГ БУСАД ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, төрөл, мянган нэгжээр, 2021 он



Нийт суурин компьютертой аж ахуйн нэгжийн 85.8 хувь нь Улаанбаатар хотод, 5.8 хувь нь Хангайн бүсэд, 4.9 хувь нь Төвийн бүсэд, 2.1 хувь нь Баруун бүсэд, 1.5 хувь нь Зүүн бүсэд байна.

ХҮСНЭГТ 4.16. АЖ АХУЙН НЭГЖ, бүс, аймаг, нийслэл, компьютер эзэмшилтээр, 2021 он

Бүс, аймаг, нийслэл	Компьютертой аж ахуйн нэгжийн тоо	Компьютерын тоо	Суурин компьютер	Зөөврийн компьютер	Таблет	Ухаалаг бусад төхөөрөмж
Бүгд	37 048	236 524	134 195	64 124	9 211	28 992
Баруун бүс	2 445	5 962	2 803	1 952	231	976
Баян-Өлгий	461	1 285	662	371	60	192
Говь-Алтай	344	930	363	283	39	245
Завхан	526	1 060	494	347	32	187
Увс	579	1 272	596	445	52	179
Ховд	535	1 415	688	506	48	173
Хангайн бүс	3 353	14 362	7 766	3 042	394	3 160
Архангай	389	954	447	316	38	153
Баянхонгор	390	1 006	459	388	39	120
Булган	378	790	394	233	40	123
Орхон	1 117	8 601	5 005	1 128	150	2 318
Өвөрхангай	479	1 311	635	430	62	184
Хөвсгөл	600	1 700	826	547	65	262
Төвийн бүс	3 827	12 192	6 585	3 782	345	1 480
Говьсүмбэр	126	437	299	103	9	26
Дархан-Уул	971	3 769	2 424	828	114	403
Дорноговь	426	1 393	681	424	19	269
Дундговь	277	639	308	195	13	123


Бүс, аймаг, нийслэл	Компьютертой аж ахуйн нэгжийн тоо	Компьютерын тоо	Суурин компьютер	Зөөврийн компьютер	Таблет	Ухаалаг бусад төхөөрөмж
Өмнөговь	826	2 890	1 268	1 209	82	331
Сэлэнгэ	727	2 033	1 071	674	83	205
Төв	474	1 031	534	349	25	123
Зүүн бүс	1 404	3 443	1 961	1 037	97	348
Дорнод	587	1 680	987	492	43	158
Сүхбаатар	324	731	430	193	27	81
Хэнтий	493	1 032	544	352	27	109
Улаанбаатар	26 019	200 565	115 080	54 311	8 144	23 028

Харин зөөврийн компьютерын хувьд 84.7 хувь нь Улаанбаатар хотод, 5.9 хувь нь Төвийн бүсэд, 4.7 хувь нь Хангайн бүсэд, 3.0 хувь нь Баруун бүсэд, 1.6 хувь нь Зүүн бүсэд байна.

Бусад ухаалаг төхөөрөмжийн 79.4 хувь нь Улаанбаатар хотод, 10.9 хувь нь Хангайн бүсэд, 5.1 хувь нь Төвийн бүсэд, 3.4 хувь нь Баруун бүсэд, 1.2 хувь нь Зүүн бүсэд байна. Таблетын 88.4 хувь нь Улаанбаатар хотод, 4.3 хувь нь Хангайн бүсэд, 3.7 хувь нь Төвийн бүсэд, 2.5 хувь нь Баруун бүсэд, 1.1 хувь нь Зүүн бүсэд байна.

Сүүлийн 2 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан 46.0 мянган аж ахуйн нэгжид 509.3 мянган ажиллагчид ажиллаж байна. Тэдгээрийн 181.2 мянга буюу 35.6 хувь нь үйл ажиллагаандаа компьютер тогтмол ашигладаг бол 120.5 мянга буюу 23.7 хувь нь интернэт тогтмол ашигладаг байна.


ЗУРАГ 4.13. АЖ АХУЙН НЭГЖИЙН АЖИЛЛАГЧДЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АШИГЛАЛТ, дүнд эзлэх хувиар, 2021 он



Аж ахуйн нэгжийн 28.5 хувь нь мэдээ, мэдээлэл авах, илгээхдээ, 24.8 хувь нь интернэт банкны үйлчилгээ болон санхүүгийн үйлчилгээнд хамрагдахдаа, 16.4 хувь нь харилцагч/хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэхдээ, 13.7 хувь нь имэйл авах, илгээхдээ, 9.0 хувь нь төрийн болон олон нийтийн байгууллагуудтай харилцахдаа, 3.8 хувь нь эд юмс, тоног төхөөрөмж удирдахдаа интернэтийг ашигладаг байна.

Аж ахуйн нэгжийн компьютерын тоог аймаг, нийслэлээр авч үзэхэд, Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүд 200.6 мянган компьютертой, Орхон аймгийнх 8.6 мянган компьютертой, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Дорнод аймгийнх 1.7-3.8 мянган компьютертой, Ховд, Дорноговь, Өвөрхангай, Баян-Өлгий, Увс аймгийнх 1.3-1.4 мянган компьютертой, Завхан, Хэнтий, Төв, Баянхонгор аймгийнх 1.0-1.1 мянган компьютертой, Архангай, Говь-Алтай, Булган, Сүхбаатар, Дундговь, Говьсүмбэр аймгууд 0.4-1.0 мянган компьютертой байна.

ЗУРАГ 4.14. АЖ АХУЙН НЭГЖИЙН АШИГЛАДАГ КОМПЬЮТЕРЫН ТОО, аймаг, нийслэлээр, 2021 он



Аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын 181.2 мянга (35.6%) нь компьютер тогтмол ашиглаж байгаа бол 120.5 мянга (23.7%) нь интернэт тогтмол ашиглаж байна.

ЗУРАГ 4.15. КОМПЬЮТЕР, ИНТЕРНЭТ АШИГЛАДАГ АЖИЛЛАГЧДЫН ТОО, 2021 ОН



Компьютертой аж ахуйн нэгжийн 14.8 мянга (40.1%) нь худалдааны салбарт, 13.0 мянга (35.0%) нь үйлчилгээний салбарт, 4.4 мянга (11.8%) нь аж үйлдвэрийн салбарт, 3.6 мянга (9.8%) нь барилгын салбарт, 1.3 мянга (3.4%) нь хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг байна.

Компьютер тогтмол ашигладаг аж ахуйн нэгжийн ажиллагчдын 85.3 мянга (47.1%) нь үйлчилгээ, 42.6 мянга (23.5%) нь худалдааны салбарт, 36.1 мянга (19.9%) нь аж үйлдвэрийн салбарт, 15.0 мянга (8.3%) нь барилгын салбарт, 2.1 мянга (1.2%) нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна.

ХҮСНЭГТ 4.17. АЖ АХУЙН НЭГЖИЙН АЖИЛЛАГЧДЫН КОМПЬЮТЕР, ИНТЕРНЭТ АШИГЛАЛТ, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он


Үйл ажиллагааны чиглэл	Ахуйн нэгжийн тоо	Компьютер, ухаалаг төхөөрөмжийн тоо				Компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоо	Интернэт тогтмол ашигладаг ажиллагчдын тоо
		Суурин компьютер	Зөөврийн компьютер	Таблет	Ухаалаг бусад төхөөрөмж		
Бүгд	37 048	134 195	64 124	9 211	28 992	181 184	120 461
Хөдөө аж ахуй	1 259	1 250	1 061	110	347	2 177	1 777
Уул уурхай	644	8 977	5 572	674	2 358	13 062	7 648
Боловсруулах	3 334	11 532	5 590	758	2 690	16 167	10 251
Барилга, дэд бүтэц	4 019	14 282	8 732	702	3 115	21 822	14 670
Худалдаа	14 840	28 226	15 077	2 316	9 805	42 630	29 559
Үйлчилгээ	12 952	69 928	28 092	4 651	10 677	85 326	56 551
Боловсрол	849	9 567	3 253	1 399	1 870	9 689	7 043
Зочид буудал, зоогийн газар	1 171	2 903	1 154	307	459	3 940	2 924
Санхүү, даатгал	1 276	18 358	4 529	374	1 732	18 255	10 446
Тээвэр, агуулах	1 204	7 090	2 220	264	846	8 859	6 970
Удирдлага	1 549	4 032	2 207	231	708	6 282	3 698
Урлаг, үзвэр	82	209	114	9	34	331	209
Үл хөдлөх хөрөнгө	828	2 296	947	110	331	2 966	2 004
Шинжлэх ухаан	2 984	9 201	5 992	1 039	2 204	13 676	9 097
Эрүүл мэнд	1 531	6 469	2 134	335	535	9 243	6 061
Бусад	1 478	9 803	5 542	583	1 958	12 085	8 099

Улсын дунджаар нэг нэгжид ногдох компьютер, ухаалаг төхөөрөмжийн тоо 6 байгаа бол нэг нэгжид ногдох компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоо болон интернэт тогтмол ашигладаг ажиллагчдын тоо тус бүр 5 байна.

ХҮСНЭГТ 4.18. НЭГ НЭГЖИД НОГДОХ КОМПЬЮТЕР УХААЛАГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	1 нэгжид ногдох компьютер, ухаалаг төхөөрөмжийн тоо	1 нэгжид ногдох			1 нэгжид ногдох компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоо	1 нэгжид ногдох интернэт тогтмол ашигладаг ажиллагчдын тоо
		Суурин компьютерын тоо	Зөөврийн компьютерын тоо	Ухаалаг бусад төхөөрөмжийн тоо		
Бүгд	6	4	2	1	5	5
ХАА	2	1	1	-	2	2
Аж үйлдвэр	11	6	3	1	8	8
Барилга	5	2	2	-	4	4
Худалдаа	4	2	1	1	3	3
Үйлчилгээ	9	5	2	1	7	6

ЗУРАГ 4.16. АЖ АХУЙН НЭГЖИЙН СҮЛЖЭЭ АШИГЛАЛТ, давхардсан тоогоор, сүлжээний төрөл, дүнд эзлэх хувиар, 2021 он



Аж ахуйн нэгжийн 31.6 мянга буюу 68.6 хувь нь үйл ажиллагаандаа сүлжээ ашиглаж байна. Тэдгээрийн 25.8 мянга (56.1%) нь интернэт, 5.8 мянга (12.5%) нь интранэт/ дотоод сүлжээ ашигладаг байна.


Нийт интернэт ашигладаг 25.8 мянган аж ахуйн нэгжийн 17.4 мянга (67.2%) нь харилцагч/хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэх, 14.5 мянга (56.3%) нь имэйл авах/ явуулах, 13.7 мянга (53.2%) нь интернэт банкны үйлчилгээнд хамрагдах, 12.6 мянга (48.8%) нь санхүүгийн бусад үйлчилгээнд хамрагдах, 10.9 мянга (42.4%) нь бараа бүтээгдэхүүний мэдээ, мэдээлэл авах, илгээх, 9.5 мянга (37.0%) нь төрийн болон олон нийтийн байгууллагуудтай харилцах зорилгоор ашиглаж байна.

ЗУРАГ 4.17. АЖ АХУЙН НЭГЖИЙН ИНТЕРНЭТ АШИГЛАЛТЫН ЗОРИЛГО, давхардсан тоогоор, хувиар, 2021 он




Аж ахуйн нэгжийн 5.0 мянга буюу 10.8 хувь нь өгөгдлийн сантай, 5.4 мянга буюу 11.6 хувь нь дата сервертэй байна.

ЗУРАГ 4.18. АЖ АХУЙН НЭГЖИЙН ӨГӨГДЛИЙН САН, СЕРВЕРТЭЙ БАЙДАЛ, 2021 ОН



Аж ахуйн нэгжийн 37.8 хувь нь ажиллагчид гэрээсээ цахимаар ажиллах боломжгүй гэсэн байна. Харин аж ахуйн нэгжийн 28.1 хувь нь ажиллагчдын 1-20 хувь нь гэрээсээ цахимаар ажиллах боломжтой гэсэн бол 16.4 хувь нь ажиллагчдын 81-100 хувь гэрээсээ ажиллах боломжтой, 8.6 хувь нь ажиллагчдын 41-60 хувь нь гэрээсээ ажиллах боломжтой, 5.0 хувь нь ажиллагчдын 21-40 хувь нь гэрээсээ ажиллах боломжтой, 4.1 хувь нь ажиллагчдын 61-80 хувь нь гэрээсээ ажиллах боломжтой гэжээ.

ЗУРАГ 4.19. АЖ АХУЙН НЭГЖИЙН АЖИЛЛАГЧДЫН ЦАХИМААР ГЭРЭЭС АЖИЛЛАХ БОЛОМЖ, дүнд эзлэх хувиар, 2021 он




ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ

Энэ хэсэгт гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг авч үзлээ.


Тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн 3.4 хувь буюу 5.2 мянган аж ахуйн нэгж гадаадын хөрөнгө оруулалттай байна.

ЗУРАГ 4.20. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ, хөрөнгө оруулалт хийсэн улс, дүнд эзлэх хувиар, 2021 он



Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн 2.5 мянга буюу 48.9 хувь нь БНХАУ-ын хөрөнгө оруулалттай бол 793 нэгж буюу 15.3 хувь нь БНСУ, 326 нэгж буюу 6.3 хувь нь Япон Улсын, 293 нэгж буюу 5.6 хувь нь ОХУ-ын, 153 нэгж буюу 2.9 хувь нь Сингапур Улсын, 118 нэгж буюу 2.3 хувь нь АНУ-ын, 108 нэгж буюу 2.1 хувь нь ИБУИНВУ-ын, 102 нэгж буюу 2.0 хувь нь ХБНГУ-ын, 756 нэгж буюу 14.6 хувь нь бусад улсын хөрөнгө оруулалттай байна.

ЗУРАГ 4.21. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ,
үйл ажиллагааны чиглэл, хувиар




Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн 50.6 хувь нь худалдааны салбарт, 28.4 хувь нь үйлчилгээний салбарт, 13.6 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 5.7 хувь нь барилгын салбарт, 1.7 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.

Харин гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн 94.1 хувь нь Улаанбаатар хотод, 3.3 хувь нь Төвийн бүсэд, 1.1 хувь нь Баруун бүсэд байгаа бол 0.8 хувь нь Хангайн болон Зүүн бүсэд тус тус ногдож байна.

ЗЭЭЛИЙН ХАМРАГДАЛТ

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн 21.2 мянга буюу 14.0 хувь нь зээлтэй бол 130.4 мянга буюу 86.0 хувь нь зээлгүй байна.


ЗУРАГ 4.22. АЖ АХУЙН НЭГЖ, зээлд хамрагдсан байдал, үйл ажиллагааны чиглэл, дүнд эзлэх хувиар, 2021 он



Зээлтэй аж ахуйн нэгжийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл, 43.2 хувь нь худалдааны салбарт, 26.2 хувь нь үйлчилгээний салбарт, 15.2 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 10.0 хувь нь барилгын салбарт, 5.4 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.


Зээлтэй 21.2 мянган нэгжийн 15.0 мянга буюу 70.8 хувь нь банкнаас, 4.5 мянга буюу 21.3 хувь нь хувь хүнээс, 1.9 мянга буюу 9.1 хувь нь ББСБ-аас, 1.8 мянга буюу 8.5 хувь нь ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас зээл авсан бол үлдсэн 3.6 хувь нь бусад эх үүсвэрээс зээл авсан байна.

ЗУРАГ 4.23. ЗЭЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, зээлийн эх үүсвэр, дүнд эзлэх хувь, давхардсан тоогоор, 2021 он



Зээлгүй 130.4 мянган аж ахуйн нэгжийн 64.2 хувь нь зээл авах шаардлагагүй, 26.8 хувь нь барьцаа хөрөнгө хангалтгүй, зээлийн бусад шалгуур хангадаггүй, 8.5 хувь нь зээл олгодог байгууллагын зээлийн хүртээмж муу, 6.2 хувь нь зээл олгодог байгууллагын хүнд суртал, 4.5 хувь нь НӨАТ төлөгч биш, 0.1 хувь нь бусад шалтгааны улмаас зээлд хамрагдаагүй гэжээ.


ЗУРАГ 4.24. ЗЭЭЛ АВААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ШАЛТГААН, дүнд эзлэх хувь, давхардсан тоогоор, 2021 он



АЖ АХУЙН НЭГЖИЙН ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМД ХОЛБОГДСОН БАЙДАЛ


Сүүлийн 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 82.3 хувь буюу 37.9 мянга нь Цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байна. Уг системд холбогдсон аж ахуйн нэгжийн 42.6 хувь нь худалдааны салбарт, 31.7 хувь нь үйлчилгээний салбарт, 12.2 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 10.2 хувь нь барилгын салбарт, 3.3 хувь нь хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 4.25. СҮҮЛИЙН 2 ЖИЛ ДАРААЛАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖ, цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байдал, дүнд эзлэх хувиар, 2021 он



Энэхүү системд холбогдсон 37.9 мянган нэгжийн 65.2 хувь буюу 24.7 мянга нь борлуулалтынхаа 100 хувьд нь и-баримт өгдөг байна. Харин 7.5 хувь буюу 2.8 мянга нь борлуулалтдаа и-баримт өгдөггүй бол 9.0 хувь буюу 3.4 мянга нь борлуулалтынхаа 10 хүртэлх хувьд нь и-баримт өгдөг байна.


ЗУРАГ 4.26. ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМД ХОЛБОГДСОН АЖ АХУЙН НЭГЖ, борлуулалтдаа и-баримт өгдөг байдал, дүнд эзлэх хувиар, 2021 он



Хөдөө аж ахуйн салбарын 11.1 хувь буюу 138 нь, үйлчилгээний салбарын 10.0 хувь буюу 1.2 мянга нь борлуулалтдаа и-баримт өгдөггүй байна.

Барилгын салбарын 70.8 хувь нь, аж үйлдвэрийн салбарын 65.1 хувь нь, худалдаа, үйлчилгээний салбар тус бүрийн 64.9 хувь нь, хөдөө аж ахуйн салбарын 53.1 хувь нь 100 хувь и-баримт өгдөг байна.

ЗУРАГ 4.27. ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМД ХОЛБОГДСОН АЖ АХУЙН НЭГЖ, хэрэглэгчдэд и-баримт өгдөг байдал, үйл ажиллагааны чиглэл, борлуулалтын дүнд эзлэх хувиар, 2021 он




ХҮСНЭГТ 4.19. ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМД ХОЛБОГДСОН АЖ АХУЙН НЭГЖ, хэрэглэгчдэд и-баримт өгдөг байдал, бүс, борлуулалтын дүнд эзлэх хувиар, 2021 он

Бүс	Бүгд	Борлуулалтын дүнд эзлэх хувиар							
		И-баримт өгдөггүй	10 хүртэлх	11-30 хувь	31-50 хувь	51-70 хувь	71-90 хувь	91-99 хувь	100 хувь
Бүгд	37 885	2 843	3 395	626	789	3 520	1 784	1 660	24 683
Баруун	2 333	168	354	132	178	575	254	122	860
Хангайн	3 247	301	367	108	135	512	286	185	1 596
Төвийн	3 887	280	328	71	96	455	257	172	2 395
Зүүн	1 365	80	149	22	38	158	117	57	804
Улаанбаатар	27 053	2 014	2 197	293	342	1 820	870	1 124	19 028

Цахим төлбөрийн баримтын системд холбогдсон 37.9 мянган аж нэгжийн 27.1 мянга буюу 71.4 хувь нь Улаанбаатар хотод, 3.9 мянга буюу 10.3 хувь нь Төвийн бүсэд, 3.2 мянга буюу 8.6 хувь нь Хангайн бүсэд, 2.3 мянга буюу 6.2 хувь нь Баруун бүсэд, 1.4 мянга буюу 3.6 хувь нь Зүүн бүсэд байна.

Хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд, компаниудын 66.2 хувь, ТӨҮГ/ОНӨҮГ-уудын 49.8 хувь, нөхөрлөлийн 47.6 хувь, хоршооны 34.1 хувь нь 100 хувь и-баримт өгдөг байна. Харин и-баримт өгдөггүй аж ахуйн нэгжүүдийг авч үзэхэд, нөхөрлөлийн 14.3 хувь, ТӨҮГ/ОНӨҮГ-ын 14.2 хувь, хоршооны 11.6 хувь, компаниудын 7.1 хувь, бусад хэлбэрийн ААН-ийн 21.3 хувь нь и-баримт өгдөггүй гэжээ.


ЗУРАГ 4.28. ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМД ХОЛБОГДСОН АЖ АХУЙН НЭГЖ, хэрэглэгчдэд и-баримт өгдөг байдал, хариуцлагын хэлбэр, борлуулалтын дүнд эзлэх хувиар, 2021 он




АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТ

Тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн 11.7 хувь буюу 17.7 мянга нь тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг байна. Тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулсан нэгжийн 37.1 хувь нь худалдааны салбарт, 35.8 хувь нь үйлчилгээний салбарт, 13.2 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 9.1 хувь нь барилгын салбарт, 4.9 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.

ЗУРАГ 4.29. АЖ АХУЙН НЭГЖ, тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг байдал, дүнд эзлэх хувиар, 2021 он




ЗУРАГ 4.30. АЖ АХУЙН НЭГЖ, тогтвортой хөгжлийн зорилгын үйл ажиллагааны тайлан бичдэг байдал, хувиар, 2021 он




Тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн 20.1 хувь нь тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны тайлан бичдэг байна.

ЗУРАГ 4.31. АЖ АХУЙН НЭГЖ, тогтвортой хөгжлийн зорилгын үйл ажиллагааны тайлан бичдэг байдал, үйл ажиллагааны чиглэл, дүнд эзлэх хувиар, 2021 он



Тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагааны тайлан бичдэг аж ахуйн нэгжийн 38.5 хувь нь үйлчилгээний салбарт, 33.6 хувь нь худалдааны салбарт, 15.0 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 7.6 хувь нь барилгын салбарт, 5.3 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.


ЗУРАГ 4.32. АЖ АХУЙН НЭГЖ, тогтвортой хөгжлийн зорилгын үйл ажиллагааны тайлан бичдэг байдал, хариуцлагын хэлбэр, дүнд эзлэх хувиар, 2021 он



Тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны тайлан бичдэг аж ахуйн нэгжийн 86.6 хувь нь компани, 4.5 хувь нь хоршоо, 3.8 хувь нь нөхөрлөл, 3.1 хувь нь бусад бол 2.1 хувь нь ТӨҮГ болон ОНӨҮГ байна.


АЖ АХУЙН НЭГЖИЙН СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭЛТ

ЗУРАГ 4.33. АЖ АХУЙН НЭГЖИЙН СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭЛТ, дүнд эзлэх хувиар, 2021 он




151.6 мянган аж ахуйн нэгжийн 0.5 хувь нь стандарт нэвтрүүлжээ. Стандарт нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл, 43.4 хувь нь үйлчилгээний салбарт, 28.2 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 20.1 хувь нь худалдааны салбарт, 6.7 хувь нь барилгын салбарт, 1.6 хувь нь хөдөө аж ахуйн салбарт нэвтрүүлсэн байна.

ЗУРАГ 4.34. СТАНДАРТ НЭВТРҮҮЛСЭН АЖ АХУЙН НЭГЖ, дүнд эзлэх хувь, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он




Стандарт нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн 77.1 хувь нь Улаанбаатар хотод байгаа бол 8.8 хувь нь Хангайн бүсэд, 8.5 хувь нь Төвийн бүсэд, 3.6 хувь нь Баруун бүсэд, 2.0 хувь нь Зүүн бүсэд байна.

ЗУРАГ 4.35. СТАНДАРТ НЭВТРҮҮЛСЭН АЖ АХУЙН НЭГЖ, бүсээр, 2021 он



Стандарт нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг хариуцлагын хэлбэрээр авч үзвэл, 94.3 хувь нь компани, 2.7 хувь нь нөхөрлөл, 1.6 хувь нь ТӨҮГ болон ОНӨҮГ, 1.4 хувь нь бусад нэгжүүд байна.

ЗУРАГ 4.36. СТАНДАРТ НЭВТРҮҮЛСЭН АЖ АХУЙН НЭГЖ, хариуцлагын хэлбэрээр, 2021 он



АЖ АХУЙН НЭГЖИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХЭРЭГЦЭЭ


ЗУРАГ 4.37. АЖ АХУЙН НЭГЖ, ажиллах хүчний дутагдалтай эсэх, 2021 он



Сүүлийн 2 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хүний нөөцийн дутагдлыг судлахад 9.0 мянга буюу 19.5 хувь нь ажиллах хүчний дутагдалтай байна гэж хариулсан байна.


Ажиллах хүчний дутагдалтай аж ахуйн нэгжийн 34.1 хувь нь үйлчилгээний салбарт, 28.9 хувь нь худалдааны салбарт, 17.6 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 14.1 хувь нь барилгын салбарт, 5.2 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.

ЗУРАГ 4.38. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДУТАГДАЛТАЙ АЖ АХУЙН НЭГЖ, үйл ажиллагааны чиглэл, дүнд эзлэх хувиар, 2021 он



Ажиллах хүчний дутагдалтай 9.0 мянган аж ахуйн нэгжийн 70.2 хувь нь Улаанбаатар хотод, 11.0 хувь нь Төвийн бүсэд, 8.6 хувь нь Хангайн бүсэд, 5.8 хувь нь Баруун бүсэд, 4.3 хувь нь Зүүн бүсэд байна.

ЗУРАГ 4.39. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДУТАГДАЛТАЙ АЖ АХУЙН НЭГЖ, бүс, дүнд эзлэх хувиар, 2021 он



Ажиллах хүчний дутагдалтай аж ахуйн нэгжийн 41.9 хувь нь мэргэжилтэн, 13.9 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 11.3 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтан, 10.0 хувь нь техникч болон туслах/дэд мэргэжилтэн, 8.3 хувь нь энгийн ажилтан, 5.8 хувь нь менежер, 5.6 хувь нь машин


механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, 2.1 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 1.1 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан шаардлагатай гэжээ.

ЗУРАГ 4.40. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДУТАГДАЛТАЙ АЖ АХУЙН НЭГЖ, шаардлагатай ажил мэргэжлийн төрлөөр, 2021 он



Ажиллах хүчний дутагдалтай аж ахуйн нэгжийн 61.3 хувь нь ажиллагчид тогтвортой ажиллах хүсэлгүй гэдэг шалтгааны улмаас шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байгаа бол 40.9 хувь нь ажлын ачаалал даах чадваргүй, 27.7 хувь нь цалин бага, 25.8 хувь нь ажлын туршлагагүй шалтгааны улмаас шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байна.

ЗУРАГ 4.41. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДУТАГДАЛТАЙ АЖ АХУЙН НЭГЖ, шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байгаа шалтгаан, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар, 2021 он



ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ БАРИМТ БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ


Сүүлийн 2 жил дараалан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад төрийн байгууллагаас баримт бичиг, тодорхойлолт шаарддаг эсэх асуултад 19.8 мянга буюу 43.1 хувь нь тийм, 18.0 мянга буюу 39.2 хувь нь үгүй, 8.2 мянга буюу 17.7 хувь нь мэдэхгүй гэжээ.

ХҮСНЭГТ 4.20. СҮҮЛИЙН 2 ЖИЛ ДАРААЛАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖ, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад төрийн байгууллагаас баримт бичиг, тодорхойлолт шаарддаг байдал, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	Бүгд	Тийм	%	Үгүй	%	Мэдэхгүй	%
Бүгд	46 026	19 822	43.1	18 036	39.2	8 168	17.7
Хөдөө аж ахуй	2 135	651	30.5	1 126	52.7	358	16.8
Уул уурхай	761	434	57.0	214	28.1	113	14.8
Боловсруулах	4 506	1 665	37.0	2 005	44.5	836	18.6
Барилга	4 824	2 517	52.2	1 448	30.0	859	17.8
Худалдаа	18 522	7 784	42.2	7 308	39.5	3 430	18.5
Үйлчилгээ	15 278	6 771	44.3	5 935	38.8	2 572	16.8
Боловсрол	913	476	52.1	287	31.4	150	16.4
ЗБ, зоогийн газар	1 463	884	60.4	395	27.0	184	12.6
Санхүү, даатгал	1 494	792	53.0	503	33.7	199	13.3
Тээвэр ба агуулах	1 548	567	36.6	670	43.3	311	20.1
Удирдлага	1 881	755	40.1	764	40.6	362	19.2
Урлаг, үзвэр	100	36	36.0	49	49.0	15	15.0
Үл хөдлөх хөрөнгө	993	318	32.0	474	47.7	201	20.2
Шинжлэх ухаан	3 490	1 403	40.2	1 516	43.4	571	16.4
Эрүүл мэнд	1 678	1 112	66.3	372	22.2	194	11.6
Бусад	1 718	428	24.9	905	52.6	385	22.5

Төрийн байгууллагад баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлж өгсөн аж ахуйн нэгжийн 17.3 мянга нь тусгай зөвшөөрөл, 9.3 мянга нь гэрээ, 7.6 мянга нь дүгнэлт, 5.8 мянга нь батламж, 2.8 мянга нь бусад материал бүрдүүлж өгснөөр үйл ажиллагаа явуулдаг байна.

ЗУРАГ 4.42. СҮҮЛИЙН 2 ЖИЛИЙН ХУГАЦААНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД БАРИМТ БИЧИГ БҮРДҮҮЛЖ ӨГСӨН АЖ АХУЙН НЭГЖ, баримт бичгийн төрлөөр, 2021 он



Нэг аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахдаа дунджаар 11 баримт бичиг, тодорхойлолт; гэрээ хийх, дүгнэлт, үнэлгээ гаргуулахад тус бүр гурван баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлж, төрийн байгууллагад өгдөг байна.

ХҮСНЭГТ 4.21. ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХАД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД БҮРДҮҮЛЖ ӨГСӨН БАРИМТ БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТЫН ТОО, баримт бичгийн төрлөөр 2021 он

Баримт бичиг, тодорхойлолт	Тоо, мянга	%	Нэг нэгжид ногдох
Тусгай зөвшөөрөл	184.0	71.5	11
Гэрээ	24.5	9.5	3
Батламж	8.9	3.5	2
Дүгнэлт	19.1	7.4	3
Үнэлгээ	15.3	6.0	3
Бусад	5.3	2.1	2

Тусгай зөвшөөрөл авсан 17.3 мянган аж ахуйн нэгж төрийн байгууллагад 184.0 мянган баримт бичиг, тодорхойлолт өгсөн байна. Эдгээр тусгай зөвшөөрлийн 66.9 мянга нь үйлчилгээний салбарт, 62.1 мянга нь худалдааны салбарт, 30.2 мянга нь аж үйлдвэрийн салбарт, 22.0 мянга нь барилгын салбарт, 2.8 мянга нь хөдөө аж ахуйн салбарт байна.

ХҮСНЭГТ 4.22. ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХАД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД БҮРДҮҮЛЖ ӨГСӨН БАРИМТ БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТЫН ТОО, үйл ажиллагааны чиглэлээр, мянган баримт бичиг, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрөл	Гэрээ	Батламж	Дүгнэлт	Үнэлгээ	Бусад
Бүгд	184.0	24.5	8.9	19.1	15.3	5.3
Хөдөө аж ахуй	2.8	0.5	0.2	0.3	0.3	0.2
Аж үйлдвэр	30.2	4.7	1.1	6.0	5.0	0.9
Барилга	22.0	2.0	0.8	2.3	3.8	0.6
Худалдаа	62.1	10.4	3.8	6.2	3.8	2.1
Үйлчилгээ	66.9	6.8	3.0	4.4	2.4	1.6

Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй нэг аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авахдаа дунджаар 16, үйлчилгээний салбарынх 12 баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлж төрийн байгууллагад өгсөн бол хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгжүүд хамгийн бага буюу дунджаар 5 баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлдэг байна.


ХҮСНЭГТ 4.23. НЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД БҮРДҮҮЛЖ ӨГСӨН БАРИМТ БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТЫН ДУНДАЖ ТОО, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрөл	Гэрээ	Батламж	Дүгнэлт	Үнэлгээ	Бусад
Бүгд	11	3	2	3	3	2
Хөдөө аж ахуй	5	1	1	1	2	1
Аж үйлдвэр	16	4	2	5	6	2
Барилга	10	2	1	3	5	2
Худалдаа	9	3	1	2	2	2
Үйлчилгээ	12	2	2	2	2	2

5

БҮЛЭГ

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



БҮЛЭГ 5.

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Энэхүү бүлэгт аж ахуйн нэгж, байгууллагын эдийн засгийн үзүүлэлтийн үр дүнг танилцуулж байна. Энэ удаагийн тооллогоор аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, орлого, зардал, хөрөнгө оруулалт, хөрөнгө, байгаль орчныг хамгаалахад зарцуулсан зардал зэрэг эдийн засгийн үзүүлэлтийг 2020 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагаас цуглууллаа.

Тооллогод нийт 180.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсаны 52.4 мянга (29.1%) нь 2020 онд үйл ажиллагаа явуулсан байна. Аж ахуйн нэгж, байгууллагад нийт 705.0 мянган хүн ажиллаж, тэдгээрт 12.6 их наяд төгрөгийн цалин олгогдсон байна.


ЗУРАГ 5.1. ТООЛЛОГОД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, 2021 он



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД


Үйл ажиллагаа 2020 онд явуулсан 52.4 мянган аж ахуйн нэгж, байгууллагад нийт 705.0 мянган хүн ажиллаж байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад ажиллагчид 65.8 мянга (10.3%)-аар, 2010 оныхоос 201.3 мянга (40.0%)-аар, 2005 оныхоос 349.6 мянга (98.3%)-аар тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 5.2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, 2005, 2010, 2015, 2020 он



Улсын дунджаар нэг ААНБ-д 13 ажиллагчид ногдож байгаа бол 10000 хүн амд 162 аж ахуйн нэгж, байгууллага ногдож байна.

ЗУРАГ 5.3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, бүсээр, 2020 он



Улсын хэмжээнд 705.0 мянган ажиллагчид ажиллаж байгаагийн 66.2 хувь нь аж ахуйн нэгжид, 27.6 хувь нь төсвийн байгууллагад, 6.2 хувь нь төрийн бус байгууллагад ажиллаж байна. Харин ААН-ийн 2021 оны тооллогын дүнгээр 2020 онд төсвийн байгууллагад 194.4 мянган ажиллагчид ажиллаж байгаа бол Төрийн албаны зөвлөлийн мэдээллийн санд 205.0 мянган төрийн албан хаагч бүртгэлтэй байна.

ЗУРАГ 5.4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, байгууллагын төрлөөр, 2020 он



Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын 396.5 мянга (56.2%) нь 50, түүнээс дээш ажиллагчидтай байгууллагад, 126.7 мянга (18.0%) нь 20-49 ажиллагчидтай байгууллагад ажиллаж байна.

ХҮСНЭГТ 5.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, ажиллагчдын тооны бүлэг, байгууллагын төрлөөр, 2020 он

Ажиллагчдын тооны бүлэг	Бүгд	Байгууллагын төрөл		
		Аж ахуйн нэгж	Төсвийн байгууллага	Төрийн бус байгууллага
Бүгд	705 026	466 714	194 390	43 922
1-9	115 851	93 960	5 009	16 882
10-19	66 007	49 491	10 734	5 782
20-49	126 654	65 254	54 738	6 662
50, түүнээс дээш	396 514	258 009	123 909	14 596

Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын 476.2 мянга (67.5%) нь Улаанбаатар хотод, 78.3 мянга (11.1%) нь Төвийн бүсэд, 72.2 мянга (10.2%) нь Хангайн бүсэд, 50.8 мянга (7.2%) нь Баруун бүсэд, 27.6 мянга (3.9%) нь Зүүн бүсэд ногдож байна.

ХҮСНЭГТ 5.2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГЧИД, бүс, аймаг, нийслэл, хүйсээр


Бүс, аймаг, нийслэл	2015		2020	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Бүгд	639 235	288 867	705 026	337 038
Баруун бүс	49 386	25 008	50 844	26 161
Баян-Өлгий	12 055	5 684	11 967	5 350
Говь-Алтай	6 861	3 702	7 398	4 143
Завхан	9 874	5 056	9 215	5 171
Увс	9 698	4 882	9 982	5 382

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Бүс, аймаг, нийслэл	2015		2020	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ховд	10 898	5 684	12 282	6 115
Хангайн бүс	70 506	36 631	72 157	39 695
Архангай	8 657	4 773	8 539	5 071
Баянхонгор	9 016	5 008	9 143	5 252
Булган	6 725	3 650	6 969	4 195
Орхон	23 294	11 068	21 893	10 846
Өвөрхангай	10 102	5 398	10 898	6 289
Хөвсгөл	12 712	6 734	14 715	8 042
Төвийн бүс	69 057	35 202	78 253	38 727
Говьсүмбэр	2 981	1 536	2 937	1 543
Дархан-Уул	16 726	8 582	16 760	8 613
Дорноговь	8 825	4 727	9 967	5 574
Дундговь	5 615	3 132	4 724	2 946
Өмнөговь	10 358	4 827	17 852	6 307
Сэлэнгэ	14 638	7 121	16 022	8 014
Төв	9 914	5 277	9 991	5 730
Зүүн бүс	27 875	14 624	27 567	15 331
Дорнод	12 862	6 869	11 936	6 281
Сүхбаатар	7 003	3 363	6 521	3 714
Хэнтий	8 010	4 392	9 110	5 336
Улаанбаатар	422 411	177 402	476 205	217 124

Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын тоогоор Орхон, Өмнөговь аймгууд Улаанбаатар хотын дараа орж байна. Харин Булган, Сүхбаатар, Дундговь, Говьсүмбэр аймгууд хамгийн бага буюу 7.0 мянга хүртэлх ажиллагчидтай байна.

ЗУРАГ 5.5. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГЧИД, хүйс, аймаг, нийслэлээр, 2020 он




Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын 376.3 мянга (53.4%) нь ХХК-д, 194.4 мянга (27.6%) нь төсвийн байгууллагад, 43.0 мянга (6.1%) нь төрийн бус байгууллагад, 42.5 мянга (6.0%) нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт, 29.5 мянга (4.2%) нь ХК-д, 6.6 мянга (0.9%) нь нөхөрлөлд, 5.2 мянга (0.7%) нь хоршоонд, үлдсэн 7.4 мянга (1.1%) нь бусад хэлбэрийн нэгжид ажиллаж байна.

ХҮСНЭГТ 5.3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГЧИД, хариуцлагын хэлбэрээр, 2010, 2015, 2020 он

Хариуцлагын хэлбэр	2010		2015		2020	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	503 678	100.0	639 235	100.0	705 026	100.0
ХК	25 317	5.0	27 969	4.4	29 520	4.2
ХХК	256 581	50.9	358 868	56.1	376 257	53.4
Нөхөрлөл	6 674	1.3	7 002	1.1	6 610	0.9
Хоршоо	6 459	1.3	12 437	1.9	5 249	0.7
ТӨҮГ/ОНӨҮГ	27 662	5.5	15 712	2.5	42 536	6.0
Төсвийн байгууллага	150 541	29.9	182 974	28.6	194 390	27.6
ТББ	25 358	5.0	26 792	4.2	43 037	6.1
Бусад	5 086	1.0	7 481	1.2	7 427	1.1

Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын 368.0 мянга (52.2%) нь эрэгтэй, 337.0 мянга (47.8%) нь эмэгтэй ажиллагчид байна. Улаанбаатар хот болон Төвийн бүсийн ААНБ-д ажиллагчдын 50 гаруй хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бол бусад бүсэд эмэгтэйчүүд давамгайлж байна.

ЗУРАГ 5.6. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГЧИД, хүйс, бүс, хувиар, 2020 он




Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын 10.1 мянга (1.4%) нь хөдөө аж ахуйн салбарт, 125.8 мянга (17.8%) нь аж үйлдвэрийн салбарт, 49.0 мянга (7.0%) нь барилгын салбарт, 94.4 мянга (13.4%) нь худалдааны салбарт, 425.7 мянга (60.4%) нь үйлчилгээний салбарт ажиллаж байна.

ХҮСНЭГТ 5.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, үйл ажиллагааны чиглэлээр, 2010, 2015, 2020 он

Үйл ажиллагааны чиглэл	2010		2015		2020	
	ААНБ	Ажиллагчид	ААНБ	Ажиллагчид	ААНБ	Ажиллагчид
Бүгд	47 471	503 678	55 638	639 235	52 368	705 026
Хөдөө аж ахуй	2 450	14 441	2 992	13 090	1 972	10 068
Аж үйлдвэр	4 634	89 518	4 948	104 075	5 213	125 765
Барилга	2 795	41 544	5 489	77 129	3 990	49 021
Худалдаа	15 496	65 834	17 428	91 251	16 648	94 439
Үйлчилгээ	22 096	292 341	24 781	353 690	24 545	425 733

Улсын дунджаар 100 эмэгтэй ажиллагчид тутамд 109 эрэгтэй ажиллагчид ногдож байна.

ЗУРАГ 5.7. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА¹, үйл ажиллагааны чиглэлээр, 2020 он




АЖИЛЛАГЧДАД ОЛГОСОН ЦАЛИН

2020 онд үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаар 1347.6 мянган төгрөг байна. Харин ажиллагчдын дундаж цалинг 2020 оны НДШ төлөгчдийн сарын дундаж цалинтай харьцуулахад 127.0 мянгаар өндөр байна.

¹ Тайлбар: ҮСХ-ны даргын 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/149 тоот тушаалаар батлагдсан "Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал"-ын "1.9 Хүн амын хүйсийн харьцаа"-г тооцох аргачлалын дагуу тооцооло.

ЗУРАГ 5.8. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ажиллагчдын тооны бүлгээр, 2020 он




2020 онд үйл ажиллагаа явуулсан 50, түүнээс дээш ажиллагчидтай 2.5 мянган ААНБ-ын 396.5 мянган ажиллагчдад 6.8 их наяд төгрөгийн цалин олгосон байна.

ХҮСНЭГТ 5.5. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, ОЛГОСОН ЦАЛИН, ажиллагчдын тооны бүлгээр, 2020 он

Ажиллагчдын тооны бүлэг	Аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Ажиллагчдын тоо	Цалин, тэрбум төгрөг
Бүгд	52 368	705 026	12 628.9
1-9	40 646	115 851	2 314.8
10-19	4 959	66 007	1 209.3
20-49	4 282	126 654	2 273.0
50, түүнээс дээш	2 481	396 514	6 831.8

Дараах зурагт аж ахуйн нэгж, байгууллагын тооны тархалтын гистограммыг ажиллагчдын тооны бүлгээр харууллаа.


ЗУРАГ 5.9. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООНЫ ТАРХАЛТЫН ГИСТОГРАММ, ажиллагчдын тооны бүлгээр, 2020 он



ААНБ-ын ажиллагчдад 2020 онд 12.6 их наяд төгрөгийн цалин олгосны 10.0 их наяд төгрөг (79.3%) нь аж ахуйн нэгжид, 2.4 их наяд төгрөг (19.0%) нь төсвийн байгууллагад, 205.3 тэрбум төгрөг (1.6%) нь төрийн бус байгууллагад ногдож байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдад 2020 онд олгосон цалингийн хэмжээг өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 7.3 их наяд төгрөг (2.4 дахин)-өөр, 2010 оныхоос 10.7 их наяд төгрөг (6.7 дахин)-өөр нэмэгдсэн байна.


ЗУРАГ 5.10. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДАД ОЛГОСОН ЦАЛИН, байгууллагын төрөл, хувиар, 2010, 2015, 2020 он



Улаанбаатар хотын аж ахуйн нэгж, байгууллага ажиллагчдадаа 10.1 их наяд төгрөгийн цалин олгосон бол Орхон аймгийнх 0.5 их наяд төгрөг, Өмнөговь аймгийнх 0.2 их наяд төгрөг олгосон нь улсын хэмжээнд тэргүүлж байна.

Говь-Алтай, Сүхбаатар, Булган, Дундговь, Говьсүмбэр аймгуудын ААНБ-ын ажиллагчдадаа олгосон цалингийн зардал хамгийн доогуур буюу 38.5-68.0 тэрбум төгрөг байна. Бусад аймгийн цалингийн хэмжээ 75.4-184.7 тэрбум төгрөг байна.

ЗУРАГ 5.11. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДАД ОЛГОСОН ЦАЛИН, аймаг, нийслэл, цалингийн бүлэг, тэрбум төгрөгөөр, 2020 он



ААНБ-ын ажиллагчдад олгосон цалингийн 7.3 их наяд төгрөг (57.9%) нь үйлчилгээний салбарт, 2.7 их наяд төгрөг (21.2%) нь аж үйлдвэрийн салбарт, 1.5 их наяд төгрөг (12.3%) нь барилгын салбарт, 1.0 их наяд төгрөг (8.2%) нь худалдааны салбарт, 51.5 тэрбум төгрөг (0.4%) нь хөдөө аж ахуйн салбарт ногдож байна.


ХҮСНЭГТ 5.6. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДАД ОЛГОСОН ЦАЛИН, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛАЛ, ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР, 2015, 2020 ОН

Салбар	2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	5 298.6	100.0	12 628.9	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	63.0	1.2	51.5	0.4
Уул уурхай, олборлолт	652.4	12.3	1 382.1	10.9
Боловсруулах үйлдвэрлэл	335.7	6.3	867.1	6.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	207.4	3.9	353.7	2.8
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	51.4	1.0	74.4	0.6
Барилга	510.9	9.6	1 547.9	12.3
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	622.1	11.7	1 037.4	8.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	203.6	3.8	779.2	6.2
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	113.2	2.1	157.8	1.2
Мэдээлэл, холбоо	137.1	2.6	331.9	2.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	254.2	4.8	449.2	3.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	65.1	1.2	79.5	0.6
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	215.4	4.1	1 180.5	9.3
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	135.1	2.5	888.1	7.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	590.9	11.2	791.9	6.3
Боловсрол	636.4	12.0	1 753.0	13.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	349.3	6.6	585.5	4.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	81.1	1.5	88.9	0.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	74.2	1.4	227.9	1.8
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	-	-	1.5	0.0

Үйл ажиллагаа 2020 онд явуулсан 41.6 мянган аж ахуйн нэгжид 466.7 мянган ажиллагчид ажиллаж байна. Харин улсын дунджаар нэг нэгжид 11 ажиллагчид


ногдож байгаа бол аж үйлдвэрийн салбарын нэг нэгжид 24 ажиллагчид, үйлчилгээний салбарын нэг нэгжид 14 ажиллагчид, барилгын салбарын нэг нэгжид 12 ажиллагчид, худалдааны салбарын нэг нэгжид 6 ажиллагчид, хөдөө аж ахуйн салбарын нэг нэгжид 5 ажиллагчид тус тус ногдож байна.


ЗУРАГ 5.12. АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, АЖИЛЛАГЧИД, үйл ажиллагааны чиглэлээр, 2020 он



Дараах зурагт аж ахуйн нэгж, байгууллагын тооны тархалтын гистограммыг үйл ажиллагааны чиглэлээр харууллаа.

ЗУРАГ 5.13. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООНЫ ТАРХАЛТЫН ГИСТОГРАММ, үйл ажиллагааны чиглэлээр, 2020 он





Улсын хэмжээнд нийт 1499 аж ахуйн нэгжид 4767 гадаадын ажиллагчид ажиллаж, 448.5 тэрбум төгрөгийн цалин олгосон байна. Гадаад ажиллагчдын ихэнх нь 1-9 болон 50, түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдэд ажиллаж байна.

ХҮСНЭГТ 5.7. ГАДААД АЖИЛЛАГЧИДТАЙ АЖ АХУЙН НЭГЖ, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, ЦАЛИН, ажиллагчдын тооны бүлгээр, 2015, 2020 он

Ажиллагчдын тооны бүлэг	2015			2020		
	Аж ахуйн нэгж	Ажиллагчдын тоо	Цалин, тэрбум төгрөг	Аж ахуйн нэгж	Ажиллагчдын тоо	Цалин, тэрбум төгрөг
Бүгд	1 295	8 163	250.1	1 499	4 767	448.5
1-9	1 181	2 085	80.5	1 425	2 429	113.5
10-19	53	711	36.3	38	519	29.1
20-49	36	1 077	15.1	23	609	65.1
50, түүнээс дээш	25	4 290	73.1	13	1 210	240.9

ОРЛОГО

Энэ хэсэгт аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэг болох аж ахуйн нэгжийн орлогын хэмжээг авч үзлээ.

Үйл ажиллагаа 2020 онд явуулсан 41.6 мянган аж ахуйн нэгж нь 75.7 их наяд төгрөгийн орлого хийжээ.


Нийт орлогын 64.6 их наяд төгрөг (85.5%) нь Улаанбаатар хотод, 5.1 их наяд төгрөг (6.7%) нь Төвийн бүсэд, 3.9 их наяд төгрөг (5.2%) нь Хангайн бүсэд, 1.0 их наяд төгрөг (1.4%) нь Зүүн бүсэд, 982.7 тэрбум төгрөг (1.3%) нь Баруун бүсэд ногдож байна.

ХҮСНЭГТ 5.8. АЖ АХУЙН НЭГЖ, ТЭДГЭЭРИЙН ОРЛОГО,
бүс, аймаг, нийслэлээр, 2015, 2020 он

Бүс, аймаг, нийслэл	2015		2020	
	ААН	Орлого, тэрбум төгрөг	ААН	Орлого, тэрбум төгрөг
Бүгд	55 638	38 920.7	41 576	75 652.3
Баруун бүс	5 353	363.6	3 501	982.7
Баян-Өлгий	1 139	110.6	682	195.9
Говь-Алтай	678	34.3	419	98.3
Завхан	1 060	35.0	715	109.0
Увс	1 203	96.2	838	257.0
Ховд	1 273	87.4	847	322.5
Хангайн бүс	6 421	1 980.5	4 178	3 896.2
Архангай	880	39.9	472	104.1
Баянхонгор	786	62.7	457	161.4
Булган	807	49.8	498	103.6
Орхон	1 752	1 572.7	1 407	3 045.1
Өвөрхангай	941	100.6	583	224.7
Хөвсгөл	1 255	154.7	761	257.2
Төвийн бүс	6 900	1 579.4	4 524	5 080.9
Говьсүмбэр	252	61.1	137	114.4
Дархан-Уул	1 586	455.0	1 162	1 108.4
Дорноговь	810	109.8	496	231.0
Дундговь	565	52.6	332	82.1
Өмнөговь	1 001	381.3	886	2 435.8
Сэлэнгэ	1 641	355.3	937	954.4
Төв	1 045	164.3	574	154.8
Зүүн бүс	2 598	525.5	1 703	1 030.9
Дорнод	1 072	339.4	718	569.4
Сүхбаатар	646	142.1	391	285.3
Хэнтий	880	44.0	594	176.2
Улаанбаатар	34 366	34 471.7	27 670	64 661.6


Орлогоороо Улаанбаатар хот (64.7 их наяд төгрөг), Орхон (3.0 их наяд төгрөг), Өмнөговь (2.4 их наяд төгрөг), Дархан-Уул (1.1 их наяд төгрөг) аймгуудын аж ахуйн нэгж хамгийн өндөр бол Дундговь (82.1 тэрбум төгрөг), Говь-Алтай (98.3 тэрбум төгрөг), Булган (103.6 тэрбум төгрөг) Архангай (104.1 тэрбум), Завхан (109.0 тэрбум төгрөг), Говьсүмбэр (114.4 тэрбум төгрөг) аймгуудын аж ахуйн нэгж хамгийн бага орлоготой байна.

ЗУРАГ 5.14. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО, орлогын бүлэг, аймаг, нийслэл, тэрбум төгрөгөөр, 2020 он




1.5 мянган аж ахуйн нэгж нь нийт орлогын 81.4 хувийг бүрдүүлж байна.

ЗУРАГ 5.15. АЖ АХУЙН НЭГЖ, ТЭДГЭЭРИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг, орлогын бүлгээр, 2020 он




Дараах зургуудад аж ахуйн нэгжийн тархалтын гистограммыг орлогын бүлэг болон үйл ажиллагааны чиглэлээр харууллаа.


ЗУРАГ 5.16. АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАРХАЛТЫН ГИСТОГРАММ, орлогын бүлгээр, 2020 он



ЗУРАГ 5.17. АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАРХАЛТЫН ГИСТОГРАММ, үйл ажиллагааны чиглэл, орлогын бүлгээр, 2020 он



ЗУРАГ 5.18. НЭГ НЭГЖИД НОГДОХ ОРЛОГО, бүсээр, сая төгрөгөөр, 2020 он



Улсын дундажаар 2020 онд үйл ажиллагаа явуулсан нэг нэгжид 1.8 тэрбум төгрөгийн орлого ногдож байгаа бол Улаанбаатар хотын нэг нэгжид 2.3 тэрбум төгрөг ногдож байгаа нь хамгийн өндөр байна.

Аж ахуйн нэгжийн 2020 оны нийт орлогын 64.0 хувийг хувийн Монгол Улсын иргэний өмчийн аж ахуйн нэгжүүд эзэлж байгаа нь 2015 оны дүнгээс 5.4 нэгж хувиар нэмэгдсэн байна. Харин гадаад улсын иргэнтэй хамтарсан аж ахуйн нэгжийн орлогын эзлэх хувь 6.1 хувь байгаа нь 2015 оны дүнгээс 9.5 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 5.9. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО, өмчийн хэлбэр, тэрбум төгрөгөөр, 2010, 2015, 2020 он

Өмчийн хэлбэр	2010		2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	17 683.1	100.0	36 363.0	100.0	75 652.3	100.0
Төрийн болон орон нутгийн	4 650.9	26.3	4 611.9	12.7	14 815.5	19.6
Монгол Улсын иргэний өмч	10 815.2	61.2	21 284.6	58.5	48 401.3	64.0
Гадаад улсын иргэний өмч	984.6	5.6	4 781.4	13.1	7 826.9	10.3
Гадаад улсын иргэнтэй хамтарсан	1 232.4	7.0	5 685.2	15.6	4 608.6	6.1

Аж ахуйн нэгжийн орлогын 26.7 их наяд төгрөг (35.2%) нь аж үйлдвэрийн салбарт, 23.3 их наяд төгрөг (30.8%) нь худалдааны салбарт, 18.2 их наяд төгрөг (24.1%) нь үйлчилгээний салбарт, 7.0 их наяд төгрөг (9.3%) нь барилгын салбарт, 467.5 тэрбум төгрөг (0.6%) нь хөдөө аж ахуйн салбарт ногдож байна. Аж үйлдвэрийн салбарын орлогыг 2015 оны дүнтэй харьцуулахад 2.5 дахин, худалдааны салбарынх 97.5 хувиар, үйлчилгээний салбарынх 86.6 хувь, барилгын салбарынх 79.4 хувь, хөдөө аж ахуйн салбарынх 59.1 хувиар тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5.10. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО,
эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, тэрбум төгрөгөөр,
2015, 2020 он

Салбар	2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	36 363.0	100.0	75 652.3	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	293.8	0.8	467.5	0.6
Уул уурхай, олборлолт	6 543.2	18.0	14 447.3	19.1
Боловсруулах үйлдвэрлэл	2 744.3	7.5	8 193.2	10.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1 198.5	3.3	3 590.7	4.7
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	118.2	0.3	430.6	0.6
Барилга	3 909.4	10.8	7 014.6	9.3
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	11 793.7	32.4	23 290.4	30.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1 395.1	3.8	4 317.0	5.7
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	448.6	1.2	751.0	1.0
Мэдээлэл, холбоо	1 021.6	2.8	1 757.3	2.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3 830.9	10.5	6 155.8	8.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	379.0	1.0	728.3	1.0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1 189.4	3.3	1 974.6	2.6
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1 017.0	2.8	1 259.3	1.7
Боловсрол	96.2	0.3	413.8	0.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	267.8	0.7	571.5	0.8
Урлаг, үзвэр, тоглоом наадам	44.6	0.1	63.3	0.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	71.6	0.2	226.2	0.3


ХӨРӨНГӨ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ХӨРӨНГӨ

Хөрөнгө, хөрөнгө оруулалт нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэг юм. Иймд, энэ удаагийн тооллогод аж ахуйн нэгжийн 2020 оны эцсийн байдлаарх үндсэн хөрөнгө, материаллаг эргэлтийн хөрөнгө, үнэт зүйлс, үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийг элэгдэл орсон дүнгээр, хөрөнгийн ангиллын дагуу авч судаллаа.


Аж ахуйн нэгжийн хөрөнгийн хэмжээ 2020 оны эцэст 139.2 их наяд төгрөгт хүрч, 2016 оны тооллогын дүнгээс 3.4 дахин өссөн байна. Эдгээрийн 127.8 их наяд нь үндсэн хөрөнгө, 9.7 их наяд төгрөг нь материаллаг эргэлтийн хөрөнгө, 1.7 их наяд төгрөг нь үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө 90.0 тэрбум төгрөг нь үнэт зүйлс байна.

ЗУРАГ 5.19. АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, тэрбум төгрөгөөр, 2020 он



Аж ахуйн нэгжийн 2020 оны эцсийн хөрөнгийн 85.0 хувийг Монгол Улсын иргэний өмч, 7.7 хувийг төрийн болон орон нутгийн өмч бүрдүүлж байна.

ЗУРАГ 5.20. АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, өмчийн хэлбэр, дүнд эзлэх хувиар, 2020 он



Аж ахуйн нэгжийн 2020 оны эцсийн хөрөнгийн 63.6 хувийг худалдааны салбар, 14.9 хувийг үйлчилгээний салбар эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.11. АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, үйл ажиллагааны чиглэл, тэрбум төгрөгөөр, 2015, 2020 он

Үйл ажиллагааны чиглэл	2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	41 077.7	100.0	139 247.2	100.0
Хөдөө аж ахуй	544.2	1.3	1 839.9	1.3
Аж үйлдвэр	25 282.5	61.5	21 725.5	15.6
Барилга	3 268.3	8.0	6 290.9	4.5
Худалдаа	5 599.7	13.6	88 597.2	63.6
Үйлчилгээ	6 383.0	15.5	20 793.7	14.9


Аж ахуйн нэгжийн хөрөнгийн хэмжээ 2020 оны эцэст 139.2 их наяд төгрөгт хүрснээс 127.7 их наяд төгрөг буюу 91.7 хувь нь Улаанбаатарт, 6.3 их наяд төгрөг буюу 4.6 хувь нь Төвийн бүсэд ногдож байна.

ХҮСНЭГТ 5.12. АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, бүс, тэрбум төгрөгөөр, 2010, 2015, 2020 он

Бүс	2010		2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	15 553.2	100.0	41 077.7	100.0	139 247.2	100.0
Баруун	234.2	1.5	449.0	1.1	1 240.1	0.9
Хангайн	1 595.2	10.3	2 990.9	7.3	2 887.6	2.1
Төвийн	910.9	5.9	2 659.3	6.5	6 341.4	4.6
Зүүн	219.5	1.4	425.1	1.0	1 080.8	0.8
Улаанбаатар	12 593.1	81.0	34 553.3	84.1	127 697.3	91.7

Аж ахуйн нэгж 2020 оны эцсийн нийт хөрөнгийн 139.2 их наяд төгрөг буюу 96.7 хувь нь компанийнх, 1.3 их наяд төгрөг буюу 2.9 хувь нь ТӨҮГ/ОНӨҮГ-ынх, 79.5 тэрбум буюу 0.2 хувь нь нөхөрлөл, хоршооны хөрөнгө байна.

ЗУРАГ 5.21. АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, хариуцлагын хэлбэр, дүнд эзлэх хувиар, 2015, 2020 он



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Энэ хэсэгт 2021 оны тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 2020 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээг хөрөнгийн ангилал, санхүүжилтийн эх үүсвэрээр танилцуулж байна.

Хөрөнгө оруулалт гэж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хуримтлалыг шинээр бий болгох, түүний техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант жилд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардлыг ойлгодог ба хөрөнгө оруулалт нь гадаад, дотоод санхүүжилтийн эх үүсвэрээс бүрддэг.

2020 онд аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт 4.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын 2.9 их наяд төгрөг (59.5%)-ийг өөрийн хөрөнгөөр, 1.2 их наяд төгрөг (23.7%)-ийг банкны зээлээр хийсэн байна.

ХҮСНЭГТ 5.13. АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, эх үүсвэрээр, тэрбум төгрөг, 2021 он

Эх үүсвэр	Хөрөнгө оруулалт	%
Бүгд	4 884.3	100.0
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	84.1	1.7
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	31.8	0.7
Өөрийн хөрөнгө оруулалт	2 908.5	59.5
Банкны зээл	1 159.6	23.7
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	246.7	5.1
Гадаадын зээл, тусламж	127.5	2.6
Хувьцаа, өрийн бичиг, үнэт цаас борлуулсан	8.1	0.2
Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн гэрээ	9.9	0.2
Бусад	308.1	6.3

Улсын хэмжээнд нийт 2.9 мянган аж ахуйн нэгж хөрөнгө оруулалт хийж, нийт дүнгээрээ хөрөнгө оруулалтын хэмжээ 4.9 их наяд төгрөгт хүрч, хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжийн тоо 67.3 хувиар, хөрөнгө оруулалтын хэмжээ 11.5 хувиар тус, тус буурсан байна.

ХҮСНЭГТ 5.14. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙСЭН АЖ АХУЙН НЭГЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, бүсээр, тэрбум төгрөг, 2010, 2015, 2020 он

Бүс	2010		2015		2020	
	ААН	Хөрөнгө оруулалт	ААН	Хөрөнгө оруулалт	ААН	Хөрөнгө оруулалт
Бүгд	6 411	3 859.5	8 787	5 521.4	2 877	4 884.3
Баруун	604	44.6	545	39.1	223	58.4
Хангайн	873	260.9	754	505.1	303	116.8
Төвийн	853	124.5	922	273.3	387	381.4
Зүүн	230	36.7	253	77.6	77	34.7
Улаанбаатар	3 851	3 392.8	6 313	4 626.3	1 887	4 293.0

2020 онд хийгдсэн 4884.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын 3205.6 тэрбум төгрөг буюу 65.6 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид ногдож байна.

ХҮСНЭГТ 5.15. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙСЭН АЖ АХУЙН НЭГЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, хариуцлагын хэлбэрээр, тэрбум төгрөг, 2010, 2015, 2020 он

Хариуцлагын хэлбэр	2010		2015		2020	
	ААН	Хөрөнгө оруулалт	ААН	Хөрөнгө оруулалт	ААН	Хөрөнгө оруулалт
Бүгд	6 411	3 859.5	8 787	5 521.4	2 877	4 884.3
ХК	102	184.1	103	1 109.6	83	1 404.0
ХХК	5 667	3 592.9	7 893	4 202.4	2 545	3 205.6
Нөхөрлөл	291	3.5	289	6.1	102	6.5
Хоршоо	227	3.1	322	4.8	40	1.2
ТӨҮГ, ОНӨҮГ	87	72.4	172	197.2	84	251.5
Бусад	37	3.5	8	1.4	23	15.4

Аж үйлдвэрийн салбарт хийсэн 2.8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын 1.7 их наяд төгрөг (59.4%)-ийг өөрийн хөрөнгө оруулалтаар хийсэн байна.

ХҮСНЭГТ 5.16. АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
үйл ажиллагааны чиглэл, эх үүсвэрээр, тэрбум төгрөг, 2020 он

Үйл ажиллагааны чиглэл	Бүгд	Эх үүсвэр						
		Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	Өөрийн хөрөнгө оруулалт	Банкны зээл	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	Гадаадын зээл, тусламж	Бусад
Бүгд	4 884.3	84.1	31.8	2 908.5	1 159.6	246.7	127.5	326.1
Хөдөө аж ахуй	126.4	2.2	0.1	48.0	51.7	0.3	0.0	24.1
Аж үйлдвэр	2 813.3	46.3	12.2	1 670.3	787.4	94.3	99.0	103.7
Барилга	323.3	11.2	3.3	199.1	77.0	1.3	3.5	27.9
Худалдаа	811.8	3.6	2.2	465.3	134.1	115.8	3.0	87.7
Үйлчилгээ	809.5	20.9	14.0	525.8	109.2	35.0	22.0	82.7

Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 2020 оны нийт хөрөнгө оруулалтын дүнд худалдааны салбар 16.6 хувийг, боловсруулах салбар 20.4 хувийг, барилгын салбар 6.6 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.17. АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, тэрбум төгрөг, 2015, 2020 он


Салбар	2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	5 521.4	100.0	4 884.3	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	87.2	1.6	126.4	2.6
Уул уурхай, олборлолт	2 160.2	39.1	1 188.9	24.3
Боловсруулах үйлдвэрлэл	223.3	4.0	998.7	20.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	607.1	11.0	585.0	12.0
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	58.0	1.1	40.7	0.8
Барилга	578.8	10.5	323.3	6.6
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	484.8	8.8	811.8	16.6
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	126.9	2.3	299.7	6.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	41.6	0.8	41.1	0.8
Мэдээлэл, холбоо	194.9	3.5	183.9	3.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	610.3	11.1	49.0	1.0

Салбар	2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	108.3	2.0	25.7	0.5
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	77.1	1.4	67.0	1.4
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	80.6	1.5	79.4	1.6
Боловсрол	11.3	0.2	35.2	0.7
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	32.3	0.6	23.5	0.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	30.4	0.6	2.8	0.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	8.2	0.1	2.2	0.0

ШИЙДВЭР ГАРГАЛТАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО


Сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 13.9 мянга буюу 30.3 хувь нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо огт байхгүй гэж хариулсан байна.

ЗУРАГ 5.22. АЖ АХУЙН НЭГЖИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО, 2021 он



Барилгын салбарын аж ахуйн нэгжийн 1.8 мянга (41.0%) нь, хөдөө аж ахуйн салбарын 768 (36.0%) нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо огт байхгүй гэсэн бол худалдааны салбарын 9.0 мянга (48.8%) нь, үйлчилгээний салбарын 7.4 мянга (48.2%) нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо 50, түүнээс дээш хувь гэж хариулсан байна.

Зураг 5.23. АЖ АХУЙН НЭГЖИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО, үйл ажиллагааны чиглэл, хувиар 2021 он



Зүүн бүсийн аж ахуйн нэгжийн 980 (53.0%) нь, Төвийн бүсийн 2.4 мянга (48.7%), Хангайн бүсийн 2.2 мянга (48.3%) нь, Улаанбаатар хотын 12.8 мянга (41.5%) нь, Баруун бүсийн 1.6 мянга (40.5%) нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо 50, түүнээс дээш хувь гэж хариулсан байна.


ХҮСНЭГТ 5.18. АЖ АХУЙН НЭГЖИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО, бүсээр, 2021 он

Оролцооны хувь	Бүс						
		Бүгд	Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар
Бүгд	Тоо	46 026	3 859	4 570	4 894	1 848	30 855
	%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
50, түүнээс дээш хувь	Тоо	19 946	1 562	2 206	2 383	980	12 815
	%	43.3%	40.5%	48.3%	48.7%	53.0%	41.5%
30-49 хувь	Тоо	4 689	506	458	465	152	3 108
	%	10.2%	13.1%	10.0%	9.5%	8.2%	10.1%
10-29 хувь	Тоо	3 224	292	269	268	87	2 308
	%	7.0%	7.6%	5.9%	5.5%	4.7%	7.5%
5-9 хувь	Тоо	1 062	96	90	103	25	748
	%	2.3%	2.5%	2.0%	2.1%	1.4%	2.4%
5 хүртэлх хувь	Тоо	3 160	317	298	333	87	2 125
	%	6.9%	8.2%	6.5%	6.8%	4.7%	6.9%
Байхгүй	Тоо	13 945	1 086	1 249	1 342	517	9 751
	%	30.3%	28.1%	27.3%	27.4%	28.0%	31.6%

ОЛОН УЛСЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНД НЭГДСЭН БАЙДАЛ


Сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 0.2 хувь буюу 115 нь олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн байна. Олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн аж ахуйн нэгжийн 51.3 хувь нь үйлчилгээний салбарт, 33.0 хувь нь худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 5.24. ОЛОН УЛСЫН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНД НЭГДСЭН АЖ АХУЙН НЭГЖ, үйл ажиллагааны чиглэл, дүнд эзлэх хувиар, 2021 он



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭКСПОРТ


ЗУРАГ 5.25. АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭКСПОРТОД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ГАРГАДАГ БАЙДАЛ, дүнд эзлэх хувиар, 2021 он



Сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 1.9 мянга (4.2%) нь экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргасан байна. Экспортод бүтээгдэхүүн үйлчилгээ гаргасан аж ахуйн нэгжийн 1.2 мянга (2.6%) нь экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ заримдаа гаргадаг бол 704 (1.5%) нь тогтмол гаргадаг байна.

Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг 1.9 мянган аж ахуйн нэгжийн 1.5 мянга (77.1%) нь Улаанбаатар хотод байршилтай байна.

ЗУРАГ 5.26. ЭКСПОРТОД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ГАРГАСАН АЖ АХУЙН НЭГЖ, бүс, хувиар, 2021 он



Харин аж үйлдвэрийн салбарын 0.5 мянга (9.1%) нь, хөдөө аж ахуйн салбарын 0.1 мянга (4.2%) нь экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргасан байна.

ХҮСНЭГТ 5.19. АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭКСПОРТОД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ГАРГАДАГ БАЙДАЛ, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	Бүгд	Тийм	%	Үгүй	%
Бүгд	46 026	1 923	4.2	44 103	95.8
Хөдөө аж ахуй	2 135	88	4.1	2 047	95.9
Аж үйлдвэр	5 687	517	9.1	5 170	90.9
Барилга	4 404	78	1.8	4 326	98.2
Худалдаа	18 522	588	3.2	17 934	96.8
Үйлчилгээ	15 278	652	4.3	14 626	95.7

Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг 1.9 мянган аж ахуйн нэгжийн 1.7 мянга (89.9%) нь өөрийн хөрөнгөөр экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргадаг байна.

ЗУРАГ 5.27. ЭКСПОРТОД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ГАРГАСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, дүнд эзлэх хувь, давхардсан тоогоор, 2021 он



Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг хөдөө аж ахуйн салбарын нэгжийн 88 нь, аж үйлдвэрийн салбарын нэгжийн 458 нь өөрийн хөрөнгөөр экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргадаг байна.

ХҮСНЭГТ 5.20. ЭКСПОРТОД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ГАРГАСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ, үйл ажиллагааны чиглэл, санхүүжилтийн эх үүсвэр, давхардсан тоогоор, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	Бүгд	Өөрийн хөрөнгөөр	ЗГын хөнгөлөлттэй зээлээр	ОУ-ын байгууллагын төсөл хөтөлбөрөөр	Дотоодын банк, санхүүгийн байгууллагын зээлээр	Бусад
Бүгд	1 923	81.1%	2.3%	2.0%	11.7%	2.9%
Хөдөө аж ахуй	88	79.2%	5.3%	1.0%	10.9%	3.0%
Аж үйлдвэр	517	76.6%	3.5%	2.2%	15.9%	1.8%
Барилга	78	82.4%	2.4%	2.4%	10.6%	2.4%
Худалдаа	588	82.5%	1.4%	1.6%	11.2%	3.3%
Үйлчилгээ	652	83.7%	1.6%	2.4%	8.8%	3.5%

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДАЛ

Сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулсан аж үйлдвэр, барилгын салбарын аж ахуйн нэгжээс үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжтэй эсэхийг тооллогоор судалсан. Нийт 10.1 мянган аж ахуйн нэгжийн 2.9 мянга (29.2%-н аж ахуйн нэгж нь үйлдвэрлэлийн зориулалттай машин, тоног төхөөрөмжтэй байна. Үүнээс боловсруулах үйлдвэрлэлийн 4.5 мянган аж ахуйн нэгжийн 2.1 мянга (46.7%) нь үйлдвэрлэлийн зориулалттай машин, тоног төхөөрөмжтэй байна.

ХҮСНЭГТ 5.21. АЖ АХУЙН НЭГЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖТЭЙ ЭСЭХ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2021 он

Салбар	Бүгд	Тийм		Үгүй	
		Тоо	%	Тоо	%
Бүгд	10 091	2 947	29.2%	7 144	70.8%
Уул уурхай, олборлолт	761	165	21.7%	596	78.3%
Боловсруулах үйлдвэрлэл	4 506	2 105	46.7%	2 401	53.3%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	283	140	49.5%	143	50.5%
Ус хангамж, хог хаягдал зайлуулах	137	42	30.7%	95	69.3%
Барилга	4 404	495	11.2%	3 909	88.8%


Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын аж ахуйн нэгжийн 60 гаруй хувь нь 300 хүртэлх м² талбайд үйлдвэрлэл явуулж байна.

ХҮСНЭГТ 5.22. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2021 он

Талбайн хэмжээ	Бүгд		Боловсруулах үйлдвэрлэл		Цахилгаан, хий, уур, агааржуулалт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	2 245	100.0%	2 105	100.0%	140	100.0%
100 хүртэл м ²	814	36.3%	789	37.5%	25	17.9%
101-200 м ²	382	17.0%	353	16.8%	29	20.7%
201-300 м ²	163	7.3%	151	7.2%	12	8.6%
301-500 м ²	188	8.4%	179	8.5%	9	6.4%
501-1000 м ²	241	10.7%	224	10.6%	17	12.1%
1001-2000 м ²	177	7.9%	163	7.7%	14	10.0%
2001 м ² , түүнээс дээш	280	12.5%	246	11.7%	34	24.3%


Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын аж ахуйн нэгжийн 54.3 хувь нь суурилагдсан хүчин чадлынхаа 91-100 хувийг 2020 онд ашигласан байна. Бусад салбарын аж ахуйн нэгжийн 17.2-28.6 хувь нь машин, тоног төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадлынхаа 91-100 хувь ашигласан байна.

ЗУРАГ 5.28. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДЛЫН АШИГЛАЛТ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2020 он




Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын аж ахуйн нэгжийн 40.0 хувь нь суурилагдсан хүчин чадлынхаа 91-100 хувийг 2021 оны эхний 9 сард ашигласан байна.

ЗУРАГ 5.29. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДЛЫН АШИГЛАЛТ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2021 оны эхний 9 сард



Боловсруулах үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжийн 44.5 хувь нь үндсэн түүхий эд материалаа дотоодоос авдаг байна.

ЗУРАГ 5.30. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛДВЭРЛЭЛД АШИГЛАЖ БУЙ ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛЫН ДОТООДЫН ЭХ ҮҮСВЭР, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2021 он



Боловсруулах үйлдвэрлэлийн 47.4 хувь нь үндсэн түүхий эд материалаа гадаадаас авдаг байна.

ЗУРАГ 5.31. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛДВЭРЛЭЛД АШИГЛАЖ БУЙ ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛЫН ГАДААДЫН ЭХ ҮҮСВЭР, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2021 он




ХОРШООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хоршоодын эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг харуулах зорилгоор аж ахуйн нэгжийн тооллогоор цуглуулсан хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, гишүүдийн тоо, хоршооны төрлийн талаарх мэдээллийг танилцуулж байна.

ЗУРАГ 7.11. ИННОВАЦЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН АЖ АХУЙН НЭГЖ, ажиллагчдын тооны бүлэг, дүнд эзлэх хувиар, 2020 он



Инновацийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулсан 97 аж ахуйн нэгжид нийт 636 ажиллагчид байгаагийн 240 нь эмэгтэй ажиллагчид байна. Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд оролцсон ажиллагчдад 2020 онд нийт 3.8 тэрбум төгрөгийн цалин, түүнтэй адилтгах цалин олгосон байна.

ХҮСНЭГТ 7.4. ИННОВАЦЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН АЖ АХУЙН НЭГЖИЙН АЖИЛЛАГЧИД, НЭГ АЖИЛТАНД НОГДОХ ЦАЛИН, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ, үйл ажиллагааны төрлөөр, 2020 он

Инновацийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа	Нийт ажиллагчдын тоо	Эмэгтэй	Нэг ажилтанд ногдох жилийн цалин, түүнтэй адилтгах зардал, мян. төгрөг	Эмэгтэй
Бүгд	636	240	5 969.3	5 460.7
Мэдээллийн технологийн үйл ажиллагаа	281	87	5 347.8	3 376.1
Шинэ материалын технологийн үйл ажиллагаа	26	7	2 464.1	2 302.9
Биотехнологи/ үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа	148	77	9 345.2	9 647.0
Сэргээгдэх эх үүсвэртэй эрчим хүчний технологийн үйл ажиллагаа	43	13	9 090.5	11 482.1
Үндэсний онцлог бүхий соёлын инновац, бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	138	56	3 301.9	1 939.8

Инновацийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуйн нэгжийн 46 нь үйлчилгээний салбарт байгаа бол нэг нэгжид дунджаар 6 ажиллагчид ногдож байна.

ЗУРАГ 7.12. ИННОВАЦЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН АЖ АХУЙН НЭГЖ, НЭГ НЭГЖИД НОГДОХ ДУНДАЖ АЖИЛЛАГЧИД, үйл ажиллагааны чиглэлээр, 2020 он



Инновацийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд 2020 онд нийт 5.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.


Харин инновацийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлснээс 5.6 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Нийт орлогын 3.7 тэрбум төгрөг (65.9%)-ийг мэдээллийн технологийн үйл ажиллагаа, 1.2 тэрбум төгрөг (21.5%)-ийг биотехнологи/ үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаанаас бүрдүүлсэн байна.

ХҮСНЭГТ 7.5. ИННОВАЦЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, үйл ажиллагааны төрлөөр, 2020 он

Инновацийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа	Орлого		Хөрөнгө оруулалтын хэмжээ	
	Дүн, сая төгрөг	%	Дүн, сая төгрөг	%
Бүгд	5 591.7	100.0	5 668.0	100.0
Мэдээллийн технологийн үйл ажиллагаа	3 683.0	65.9	327.4	5.8
Шинэ материалын технологийн үйл ажиллагаа	-	-	248.8	4.4
Биотехнологи/ үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа	1 200.4	21.5	2 645.0	46.7
Сэргээгдэх эх үүсвэртэй эрчим хүчний технологийн үйл ажиллагаа	302.0	5.4	163.0	2.9
Үндэсний онцлог бүхий соёлын инновац, бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	406.3	7.3	2 283.7	40.3

Инновацийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлсэн ААН-ийн ажиллагчдын 326 (51.3%) нь инженерчлэл болон технологийн шинжлэх ухааны салбарт, 95 (14.9%) нь анагаах ухаан болон эрүүл мэндийн шинжлэх ухааны салбарт тус тус ажилласан байна.

ЗУРАГ 7.13. ИННОВАЦЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЭЛСЭН АЖИЛЛАГЧДЫН ТОО, шинжлэх ухааны салбараар, 2020 он



Инновацийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг эрхэлсэн 636 ажиллагчдын 240 (37.7%) нь эмэгтэй ажиллагчид байна. Нийт ажиллагчдын 545 (85.7%) нь дээд боловсролтой байна.

ХҮСНЭГТ 7.6. ИННОВАЦЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН АЖИЛЛАГЧДЫН ТОО, шинжлэх ухааны салбар, боловсролын түвшнээр, 2020 он

Шинжлэх ухааны салбар	Нийт ажиллагчдын тоо	Эмэгтэй	Боловсролын түвшин					
			Дээд		Техникийн болон мэргэжлийн боловсрол		Бусад	
			Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
БҮГД	636	240	545	212	31	7	60	21
Байгалийн шинжлэх ухаан	60	21	59	20	1	1	-	-
Инженерчлэл болон технологийн шинжлэх ухаан	326	107	300	96	10	2	16	9
Анагаах ухаан болон эрүүл мэндийн шинжлэх ухаан	95	50	54	35	9	4	32	11
Хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн шинжлэх ухаан	76	26	56	25	8	-	12	1
Нийгмийн шинжлэх ухаан	1	-	1	-	-	-	-	-
Хүмүүнлэг болон урлагийн шинжлэх ухаан	3	-	1	-	2	-	-	-
Бусад	75	36	74	36	1	-	-	-

Нийт ажиллагчдын 59 (9.3%) нь эрдмийн зэрэгтэй ажиллагчид байна.

ЗУРАГ 7.14. ИННОВАЦЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЭЛСЭН
ЭРДМИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАГЧДЫН ТОО, 2020 он



СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод “Судалгаа хөгжүүлэлтийн ажил” бүлгийг шинээр тусгаж, мэдээллийг цуглуулсан.

Засгийн газрын 2014 оны 301-р тогтоолын хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын ШУТ-ийн төсөлд хамаарах шинэ мэдлэг, мэдээллийг бий болгоход чиглэсэн суурь судалгааны төсөл, захиалгат төсөл, гадаадтай хамтарсан төслүүдийг **суурь судалгааны** ажилд, хэрэглээний судалгаанд чиглэсэн хөтөлбөрийн зорилтот төсөл, захиалгат төсөл, гадаадтай хамтарсан төслүүдийг **хэрэглээний судалгааны** ажилд, цөм технологийн төсөл, технологийн, туршилт зүгшрүүлэлтийн төслүүдийг **туршилт, хөгжүүлэлтийн** ажилд тус тус оруулна гэж заасан.

Судалгаа хөгжүүлэлтийн ажил гэж хүн, соёл, нийгмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хийгдэж байгаа системтэй, бүтээлч үйл ажиллагаа болон уг ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг хэрэглээнд нэвтрүүлж ашиглахад чиглэсэн цогц ажил юм.

Суурь судалгааны ажил гэж аливаа үзэгдэл, ажиглаж болохуйц баримт, нотолгоонд түшиглэн, шинэ мэдлэгийг бий болгоход чиглэсэн, тодорхой хэрэглээнд анхнаасаа ашиглахыг зориогүй, туршилтын буюу онолын судалгааны ажил юм.

Хэрэглээний судалгаа (хавсарга судалгаа)-ны ажил гэж тодорхой үр дүн гаргахад чиглэсэн, шинэ мэдлэг бий болгох зорилготой судалгааны ажил бөгөөд суурь судалгааны ололт, үр дүнг тодорхой хэрэглээнд ашиглаж болох эсэхийг тодорхойлох, тодорхой зорилгод хүрэх арга замыг тогтооход чиглэгдэнэ.

Туршилт, хөгжүүлэлтийн ажил гэж шинэ бараа, материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн шинэ үйл явц, тогтолцоо, үйлчилгээг нэвтрүүлэх, эдгээрийг сайжруулахад чиглэсэн системтэй судалгаа, туршилтын ажлыг ойлгоно.

Энэ бүлэгт аж ахуйн нэгжүүдийн хэрэгжүүлсэн судалгаа хөгжүүлэлтийн ажлын шинжлэх ухааны салбар, түүнд оролцсон хүний нөөцийг авч үзсэн.

СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ


Судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа нь мэдлэгийн нөөцийг нэмэгдүүлэх, байгаа мэдлэгийн хэрэглээг бий болгох зорилгоор хийсэн бүтээлч, системтэй ажил юм. Судалгаа хөгжүүлэлтийн ажил нь 5 шалгуурыг хангасан байх ёстой.

1. Шинэлэг
2. Бүтээлч
3. Тодорхойгүй үр дүнг шийдвэрлэх
4. Системчилсэн
5. Шилжүүлж, хуулбарлах боломжтой

Энэ удаагийн тооллогоор 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан 57.6 мянган аж ахуйн нэгжийн 1.2 мянга (2.0%) нь үйл ажиллагаандаа судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн байна. Аж ахуйн нэгжийн тооллогод 2018-2021 онд давхардсан тоогоор 2154 аж ахуйн нэгж 9.7 мянган судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн байна.

2018-2021 онд 690 аж ахуйн нэгж 3097 суурь судалгааны ажил, 705 аж ахуйн нэгж 2506 хэрэглээний судалгааны ажил, 759 аж ахуйн нэгж 4094 туршилт судалгааны ажил байна. Дунджаар нэг аж ахуйн нэгж 4-5 судалгааны ажил хийсэн байна.

ЗУРАГ 7.15. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ ХИЙСЭН АЖ АХУЙН НЭГЖ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОО, СУДАЛГААНЫ АЖЛЫН ТӨРЛӨӨР, 2018-2021 он



Боловсруулах салбарт 334 аж ахуйн нэгж 2262 судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн нь хамгийн их буюу 23.3 хувийг эзэлж байна. Худалдааны салбарт 556 аж ахуйн нэгж 2049 буюу 21.1 хувь, барилга дэд бүтцийн салбарт 176 аж ахуйн нэгж 445 буюу 4.6 хувь, хөдөө аж ахуйн салбарт 127 аж ахуйн нэгж 376 буюу 3.9 хувь, уул

уурхайн салбарт 39 аж ахуйн нэгж 132 судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн байна. Үйлчилгээний салбаруудыг авч үзвэл, шинжлэх ухааны салбарт 1244 (12.8%), санхүү болон даатгалын салбарт 101 аж ахуйн нэгж 389 (4.0%), боловсролын салбарт 90 аж ахуйн нэгж 366 (3.8%), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 123 аж ахуйн нэгж 293 (3.0%), бусад салбарт 391 аж ахуйн нэгж 2141 (22.1%) судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн байна.

ХҮСНЭГТ 7.7.СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ ХИЙСЭН АЖ АХУЙН НЭГЖ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОО, үйл ажиллагааны чиглэл, судалгаа хөгжүүлэлтийн ажлын төрлөөр, 2018-2021 он

Үйл ажиллагааны чиглэл	Төрөл							
	Бүгд		Суурь судалгаа		Хэрэглээний судалгаа		Туршилт, хөгжүүлэлтийн ажил	
	ААН	Ажлын тоо	ААН	Ажлын тоо	ААН	Ажлын тоо	ААН	Ажлын тоо
Бүгд	2 154	9 697	690	3 097	705	2 506	759	4 094
Хөдөө аж ахуй	124	376	38	65	38	71	45	240
Уул уурхай	39	132	14	38	9	27	16	67
Боловсруулах	334	2 262	89	782	108	427	137	1 053
Барилга, дэд бүтэц	176	445	49	98	61	163	66	184
Худалдаа	556	2 049	183	577	188	850	185	624
Үйлчилгээ	925	4 433	317	1 539	301	968	307	1 926
Боловсрол	90	366	29	128	35	169	26	69
Зочид буудал, зоогийн газар	50	83	13	19	22	36	15	28
Санхүү, даатгал	101	389	37	130	36	106	28	153
Тээвэр, агуулах	41	78	15	32	11	16	15	30
Удирдлага	123	293	46	115	37	105	40	73
Урлаг, үзвэр	9	20	3	6	3	8	3	6
Үл хөдлөх хөрөнгө	19	30	8	16	8	11	3	3
Шинжлэх ухаан	220	1 244	85	754	69	228	66	262
Эрүүл мэнд	66	235	26	96	26	75	14	64
Бусад	206	1 695	55	243	54	214	97	1 238


Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрөөр нь авч үзвэл, суурь судалгааны төсөл 590 (37.6%), технологи, туршилт зүгшрүүлэлтийн төсөл 344 (21.9%), дотоодтой хамтарсан төсөл 220 (14.0%), захиалгат төсөл 214 (13.6%), хөтөлбөрийн зорилтот төсөл 105 (6.7%), гадаадтай хамтарсан төсөл 72 (4.6%), тэтгэлэгт судалгаа 14 (0.9%), цөм технологийн төсөл 8 (0.5%), бусад 4 (0.3%) төсөл хийгдсэн байна.

ЗУРАГ 7.16. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ,
хэрэгжүүлсэн төслийн төрөл, дүнд эзлэх хувиар, 2018-2021 он



Судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжүүлсэн шинжлэх ухааны салбараар авч үзвэл, инженерчлэл болон технологийн салбарт 492 (36.3%), нийгмийн салбарт 287 (21.2%), байгалийн салбарт 201 (14.8%), хөдөө аж ахуй болон мал эмнэлгийн салбарт 179 (13.2%), анагаах ухаан болон эрүүл мэндийн салбарт 101 (7.5%), хүмүүнлэг болон урлагийн салбарт 55 (4.1%) судалгаа хөгжүүлэлтийн ажил хийгдсэн байна.

ЗУРАГ 7.17. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ ХИЙСЭН АЖ АХУЙН НЭГЖ,
шинжлэх ухааны салбар, дүнд эзлэх хувиар, 2018-2021 он




СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛД ОРОЛЦСОН АЖИЛЛАГЧДЫН ТОО, ХҮЙС, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, АЛБАН ТУШААЛЫН АНГИЛЛААР

2018-2021 онд үйл ажиллагаа явуулж, судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн 1.2 мянган аж ахуйн нэгжийн 4.7 мянган ажиллагчид судалгаа хөгжүүлэлтийн ажилд оролцсон байна.


Судалгаа хөгжүүлэлтийн ажилд оролцсон ажиллагчдыг албан тушаалын ангиллаар нь авч үзвэл, удирдах албан тушаалтан 1395 (29.9%), бусад туслах ажилтан 1272 (27.3%), техникч, түүнтэй дүйцэх ажилтан 1070 (23.0%), судлаач 923 (19.8%) ажилласан байна.

ЗУРАГ 7.18. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛД ОРОЛЦСОН АЖИЛЛАГЧДЫН ТОО, АЛБАН ТУШААЛЫН АНГИЛЛААР, 2018-2021 он




Судалгаа хөгжүүлэлтийн ажилд оролцсон ажиллагчдын бакалавр зэрэгтэй ажиллагчид 2308 (49.5), магистр зэрэгтэй ажиллагчид 919 (19.7%), бусад (суурь болон бүрэн дунд боловсрол) ажиллагчид 554 (11.9%), техникийн болон мэргэжлийн боловсролын ажиллагчид 533 (11.4%), докторын зэрэгтэй ажиллагчид 219 (4.7%), дипломын дээд боловсролтой ажиллагчид 127 (2.7%) тус тус ажилласан байна.

ЗУРАГ 7.19. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛД ОРОЛЦСОН АЖИЛЛАГЧДЫН ТОО, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2018-2021 он



Насны бүлэг, хүйсээр авч үзвэл, 25 хүртэлх насны 517 ажиллагчдын 242 (46.8%), 25-34 насны 1783 ажиллагчдын 726 (40.7%), 35-44 насны 1435 ажиллагчдын 617 (43.0%), 45-54 насны 568 ажиллагчдын 250 (44.0%), 55-64 насны 292 ажиллагчдын 149 (51.0%), 65, түүнээс дээш насны 65 ажиллагчдын 16 (24.6%) нь эмэгтэй ажиллагчид судалгаа хөгжүүлэлтийн ажилд оролцсон байна.

ЗУРАГ 7.20. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛД ОРОЛЦСОН АЖИЛЛАГЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР



Судалгаанд оролцсон нийт ажиллагчдын 42.9 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 25-34 насны залуучуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2.2 нэгж хувиар бага байна.

СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ЗАРДАЛ

Аж ахуйн нэгжүүд 10.4 тэрбум төгрөгийг 2020 онд судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулсан байна. Нийт судалгаа хөгжүүлэлтийн ажлын 8.4 (80.5%) тэрбум төгрөг нь дотоод зардал, 2.0 (19.5%) тэрбум төгрөг нь хөрөнгийн зардал байна.

ЗУРАГ 7.21. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ЗАРДАЛ, зардлын төрөл, дүнд эзлэх хувиар, 2020 он




Судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлыг эх үүсвэрээр авч үзвэл, нийт зардлын хамгийн их буюу 70.7 хувийг ААН-үүд өөрийн үйл ажиллагааны орлогоос, хамгийн бага буюу 0.01 хувийг төрийн бус байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлсэн байна. Харин аж ахуйн нэгжээс 0.7 тэрбум (6.6%), улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр 755.6 (7.3%), бусад санхүүжилтээр 758.6 сая (7.3%), банк, санхүүгийн байгууллагаас 726.4 (7.0%), гадаад улс болон олон улсын байгууллагын зээл, тусламжаар 116.4 сая төгрөгөөр судалгаа хөгжүүлэлтийн ажлыг санхүүжүүлсэн байна.

ХҮСНЭГТ 7.8. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ЗАРДАЛ,
санхүүжилтийн эх үүсвэр, сая төгрөгөөр, 2020 он

Эх үүсвэр	Зардал	Дүнд эзлэх хувь
Бүгд	10 387.5	100.0%
Өөрийн үйл ажиллагааны орлогоос	7 345.8	70.7%
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаас	683.3	6.6%
Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт	755.6	7.3%
Бусад	758.6	7.3%
Банк, санхүүгийн байгууллагаас	726.4	7.0%
Гадаад улс болон олон улсын байгууллагын зээл, тусламжаар	116.4	1.1%
Төрийн бус байгууллага	1.5	0.0%

Албан тушаалын төрлөөр нь ажиллагчдын тоо болон цалинг авч үзвэл, 2020 онд 4660 ажиллагчдад 4.3 тэрбум төгрөгийн цалин олгосон байна. Судалгаа хөгжүүлэлтийн ажиллагчдын 1395 удирдах албан тушаалтанд 1.6 тэрбум төгрөг, 923 судлаачдад 1.4 тэрбум төгрөг, 1070 техникч, түүнтэй дүйцэх ажилтанд 691.3 сая төгрөг, 1272 бусад туслах ажилтанд 581.4 сая төгрөгийн цалинг тус тус олгосон байна.

ЗУРАГ 7.22. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛД ОРОЛЦСОН
АЖИЛЛАГЧИД, ЦАЛИН, албан тушаалын ангиллаар, 2020 он



ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ҮР ДҮН

Инновац нь цоо шинэ зүйл байх албагүй бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээнд мэдэгдэхүйц өөрчлөлт хийж, технологи нэвтрүүлсний үр өгөөж юм. Инновацын хамгийн гол шинж чанар нь эдийн засгийн үр өгөөжийг авчирч, нийгмийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхэд оршдог. Тиймээс ч инновац хийхийн тулд улс орнууд багагүй хөрөнгө, хүч зарцуулах болсон ба үүнийг зардал гэхээсээ илүү хөрөнгө оруулалт гэж харах нь зохистой юм.

“Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”-н салбарын хөгжлийн зорилтыг хангах зарчимд: “өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрд нэвтрүүлэх, инновац шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах”, Эдийн засгийн олон тулгуурт бүтэц хэсгийн 3.2.1.7-д: судалгаа, инновацыг стратегийн ач холбогдолтой салбаруудад төвлөрүүлж, эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ”, Зорилт 5-ийн II үе шат: (2021-2025) “Технологи инновацыг хөгжүүлж, шинжлэх ухаан технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2.5 хувь хүртэлх түвшинд хүргэх” зорилтыг дэвшүүлсэн байна.

Монгол Улсын хувьд зах зээлийн харилцаанд шилжсэн үеэс шинжлэх ухаан, технологийн хөгжил, инновацын асуудал хүчтэй хөндөгдөж, 2006 оноос инновацын талаарх хууль, эрхзүйн орчин бүрдүүлэх, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлууд эрчимтэй хийгдэж эхэлсэн. Гэсэн хэдий ч аж ахуйн нэгж, байгууллагууд инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг нэвтрүүлж, үр ашгийг нь хүртэж байгаа нь тодорхойгүй хэвээр байна.

Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын төрлүүд:

Патент гэж тодорхой зүйлийг хийх шинэ арга замыг гаргасан эсвэл аливаа техникийн шинэ шийдлийг санал болгож буй бүтээгдэхүүн болон арга ажиллагаанд (шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар) өгч буй онцгой эрх юм.

Шинэ бүтээл гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийг агуулсан шинэ шийдлийг ойлгоно.

Бүтээгдэхүүний загвар гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг ойлгоно.

Ашигтай загвар гэж үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг ойлгоно.


Барааны тэмдэг гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг ойлгоно.

Зохиогчийн эрхийн бүтээлд ном, хөгжим, уран зураг, уран баримал, кино, компьютерын программ, мэдээллийн сан, зар сурталчилгаа, газрын зураг, техникийн зураг зэрэг бүтээл багтдаг.


Инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг 2018-2021 онд 17.1 мянган аж ахуйн нэгж хийсэн байна.

Инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэснээр хүрсэн үр дүнг төрлөөр авч үзвэл, 94.2 хувь нь аргачлал заавар зөвлөмж, 54.0 хувь нь зураг, каталог, 56.9 хувь нь үйлдвэрлэлд нэвтэрсэн үр ашиг, 54.9 хувь нь жор, үнэлгээ, 54.0 хувь нь стандарт, 48.3 хувь нь шинэ технологи, 43.1 хувь нь шинэ биет бүтээгдэхүүн, 35.2 хувь нь тоног төхөөрөмжийн туршилтын загвар байна.

ЗУРАГ 7.23. ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭСНЭЭР ХҮРСЭН ҮР ДҮН, төрлөөр, 2018-2021 он



ЗУРАГ 7.24. ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТОО, 2018-2021 он



Инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэснээр оюуны өмч эрхийн хамгаалалт хийлгэхээр Оюуны өмчийн газарт мэдүүлэг гаргасан 742 аж ахуйн нэгжээс 423 (57.0%), 1913 судалгааны ажлаас 934 (48.8%) нь патент болон гэрчилгээ авсан байна.

Оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэхээр 188 аж ахуйн нэгж 624 барааны тэмдэг авахаар мэдүүлэг гаргасан нь хамгийн их үр дүнд хүрсэн төрөл байна. Хамгийн бага нь 102 аж ахуйн нэгж ашигтай загварын патент авахаар мэдүүлэг гаргасан байна.

ЗУРАГ 7.25. ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ ХИЙЛГЭХЭЭР МЭДҮҮЛЭГ ГАРГАСАН АЖ АХУЙН НЭГЖ, АЖЛЫН ТОО



ЗУРАГ 7.26. ОЮУНЫ ӨМЧИЙН ПАТЕНТ, ГЭРЧИЛГЭЭ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, АЖЛЫН ТОО, 2018-2021 он



Оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэхээр барааны тэмдэг 119 аж ахуйн нэгж 302-н, зохиогчийн эрх 95 аж ахуйн нэгж 206-н, шинэ бүтээл 89 аж ахуйн нэгж 205-н, бүтээгдэхүүний загвар 70 аж ахуйн нэгж 153-н, ашигтай загвар 50 аж ахуйн нэгж 68-н патент, гэрчилгээг тус тус авсан байна.

Дээрх үр дүнгээс харахад оюуны өмчийн төрлөөр аж ахуйн нэгжүүд барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар, шинэ бүтээлдээ оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэхээр хамгийн их мэдүүлэг гаргасан байна.

Зохиогчийн эрхийн хувьд 346 ажлын мэдүүлэг гаргаснаас 206 (59.5%), шинэ бүтээл 348 ажлаас 205 (58.9%), барааны тэмдэг 624 ажлаас 302 (48.4%), ашигтай загвар 181 ажлаас 68 (37.6%), бүтээгдэхүүний загвар 414 ажлаас 153 (37.0%) нь патент, гэрчилгээ авсан байна.




ЗУРАГ 7.27. ПАТЕНТ, ГЭРЧИЛГЭЭ АВСАН ОЮУНЫ ӨМЧИЙН БҮТЭЭЛИЙН МЭДҮҮЛЭГ ГАРГАСАН БҮТЭЭЛИЙН ТООНД ЭЗЛЭХ ХУВЬ, патентын төрлөөр, 2018-2021 он



8

БҮЛЭГ

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА



БҮЛЭГ 8. | ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА

Энэ бүлэгт төсвийн байгууллагын тухай тусгайлан авч үзнэ. Үүнд “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” Монгол Улсын хуулиар тодорхойлогдсон улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг бүх шатны байгууллагыг хамруулна. Энэ тооллогоор төсвийн байгууллагуудаас мэдээллийн өгөгдлийн сангийн талаарх мэдээллийг шинээр цуглуулсан болно.

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОО

ХҮСНЭГТ 8.1. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, тооллого явагдсан оноор

Он	Хуулийн этгээд	Төсвийн байгууллага	Дүнд эзлэх хувь
1998	18 950	3 835	20.2
2006	32 410	3 398	10.5
2011	65 204	3 959	6.1
2016	118 686	4 372	3.7
2021	180 006	4 597	2.6

ААН-ийн 2021 оны тооллогоор нийт 180.0 мянган хуулийн этгээд тооллогод хамрагдсаны 4.6 мянга буюу 2.6 хувь нь төсвийн байгууллага бөгөөд 2011 оны тооллогын дүнд эзлэх хувиас 3.5 нэгж хувиар, 2016 оны тооллогын дүнд эзлэх хувиас 1.1 нэгж хувиар бага байна.


ХҮСНЭГТ 8.2. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, бүс, аймаг, нийслэлээр, тооллого явагдсан оноор

Бүс, аймаг, нийслэл	2016	2021
Бүгд	4 372	4 597
Баруун бүс	930	963
Баян-Өлгий	179	199
Говь-Алтай	177	184
Завхан	220	214
Увс	181	180
Ховд	173	186

Бүс, аймаг, нийслэл	2016	2021
Хангайн бүс	1 037	1 070
Архангай	188	189
Баянхонгор	187	194
Булган	160	157
Орхон	98	104
Өвөрхангай	192	205
Хөвсгөл	212	221
Төвийн бүс	1 039	1 101
Говьсүмбэр	57	60
Дархан-Уул	108	111
Дорноговь	169	171
Дундговь	144	142
Өмнөговь	157	167
Сэлэнгэ	203	228
Төв	201	222
Зүүн бүс	473	481
Дорнод	148	162
Сүхбаатар	135	129
Хэнтий	190	190
Улаанбаатар	893	982


Төсвийн байгууллагын 1101 буюу 24.0 хувь нь Төвийн бүсэд, 1070 буюу 23.3 хувь нь Хангайн бүсэд, 982 буюу 21.4 хувь нь Улаанбаатар хотод, 963 буюу 20.9 хувь нь Баруун бүсэд, 481 буюу 10.5 хувь нь Зүүн бүсэд ногдож байна. Хэдийгээр Улаанбаатар хотод Монгол Улсын хүн амын 47.6 хувь нь амьдарч байгаа ч төсвийн байгууллагын 21.4 хувь нь байрлаж байна. Төвийн болон Хангайн бүсийн төсвийн байгууллага Улаанбаатар хотын төсвийн байгууллагын тооноос 1.9-2.6 нэгж хувиар их байна.

ЗУРАГ 8.1. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, аймаг нийслэлээр, 2021 он




Улсын хэмжээнд нийт 4.6 мянган төсвийн байгууллага тоологдсоныг аймаг, нийслэлээр авч үзвэл, Улаанбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Завхан, Өвөрхангай аймгууд 200-гаас дээш байгаа нь хамгийн олон төсвийн байгууллагатай аймгуудад орж байна. Харин хамгийн бага буюу 100 хүрэхгүй төсвийн байгууллагатай нь Говьсүмбэр аймаг байна. Бусад аймгуудын хувьд ерөнхийдөө жигдхэн 100-200 төсвийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 8.2. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, дүүргээр, 2021 он



Улаанбаатар хотын төсвийн байгууллагын тоо Чингэлтэй дүүрэгт хамгийн их буюу 189 (19.2%) байгаа бол Багахангай дүүрэгт хамгийн бага буюу 20 (2.0%) байна. 2016 оны тооллогод Сүхбаатар дүүрэг хамгийн их төсвийн байгууллагатай байсан бол энэ удаагийн тооллогод Чингэлтэй дүүрэгт төсвийн байгууллага олонтой байна. Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт төсвийн байгууллага илүү их төвлөрсөн байна.

ЗУРАГ 8.3. ТӨСВИЙН НЭГ БАЙГУУЛЛАГАД НОГДОХ ХҮН АМ, бүсээр, 2021 он



Бүсүүдийн төсвийн байгууллагын тоо нь хүн амын тооноос төдийлөн хамааралгүй байна. Баруун бүсэд нэг төсвийн байгууллагад 433 хүн, Төвийн бүсэд 470 хүн, Зүүн бүсэд 470 хүн, Хангайн бүсэд 566 хүн, Улаанбаатар хотод 1648 хүн ногдож байгаа бол улсын дунджаар төсвийн нэг байгууллагад 736 хүн ам ногдож байна.

ХҮСНЭГТ 8.3. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, бүс, аймаг, нийслэл, өмчийн хэлбэрээр,
2021 он

Бүс, аймаг, нийслэл	Төрийн өмчийн	Орон нутгийн өмчийн
Бүгд	3 991	606
Баруун бүс	832	131
Баян-Өлгий	162	37
Говь-Алтай	150	34
Завхан	195	19
Увс	157	23
Ховд	168	18
Хангайн бүс	894	176
Архангай	172	17
Баянхонгор	148	46
Булган	122	35
Орхон	89	15
Өвөрхангай	169	36
Хөвсгөл	194	27
Төвийн бүс	948	153
Говьсүмбэр	49	11
Дархан-Уул	93	18
Дорноговь	147	24
Дундговь	121	21
Өмнөговь	146	21
Сэлэнгэ	197	31
Төв	195	27
Зүүн бүс	417	64
Дорнод	136	26
Сүхбаатар	124	5
Хэнтий	157	33
Улаанбаатар	900	82


Нийт төсвийн байгууллагын 4.0 мянга буюу 86.8 хувь нь төрийн өмчийнх, 0.6 мянга буюу 13.2 хувь нь орон нутгийн өмчийн байгууллага байна. Улаанбаатар хотод 91.6 хувийг төрийн өмчийн төсвийн байгууллага эзэлж байгаа бол бусад бүсүүдэд 83.6-86.7 хувийг төрийн өмчийн байгууллага эзэлж байна.

ХҮСНЭГТ 8.4. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, тооллого явагдсан оноор

Салбар	2011		2016		2021	
	Бүгд	%	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	3 959	100.0	4 372	100.0	4 597	100.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1 401	35.4	1 552	35.5	1 615	35.1
Боловсрол	1 402	35.4	1 526	34.9	1 721	37.4
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	447	11.3	429	9.8	468	10.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	472	11.9	543	12.4	523	11.4
Бусад	237	6.0	322	7.4	270	5.9


Төсвийн байгууллагын тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 37.4 хувь нь боловсролын чиглэлээр, 35.1 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын чиглэлээр, 11.4 хувь нь урлаг, үзвэр, тоглоом наадмын чиглэлээр, 10.2 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагааны чиглэлээр, 5.9 хувь нь бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Төсвийн байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаарх бүтцийг 2016 оны тооллогын дүнтэй харьцуулж авч үзэхэд, боловсролын салбар 2.5 нэгж хувиар, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа 0.4 нэгж хувиар нэмэгдсэн бол бусад үйл ажиллагаа 1.5 нэгж хувиар, урлаг, үзвэр, тоглоом наадмын үйл ажиллагаа 1.0 хувиар, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын үйл ажиллагаа 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 8.4. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, хүний нөөцийн чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулдаг эсэх, 2021 он




Тооллогод хамрагдсан 4.6 мянган төсвийн байгууллагын 69.7 хувь буюу 3.2 мянга нь хүний нөөцийн чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулдаг гэжээ. Хүний нөөцийн чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулдаг байгууллагын 53.1% нь мэргэшүүлэх сургалт, 47.9 хувь нь чиглүүлэх сургалт, 36.8 хувь нь хүний хөгжлийн сургалт, 31.3 хувь нь мэргэжил дээшлүүлэх сургалт, 7.4 хувь нь гадаад хэлний сургалт, үлдсэн 4.2 хувь нь бусад төрлийн сургалт зохион байгуулдаг байна.

ЗУРАГ 8.5. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛДАГ ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, сургалтын төрөл, дүнд эзлэх хувиар, 2021 он



Төсвийн байгууллагын 73.3 хувь буюу 3.4 мянга нь үйл ажиллагаа явуулахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгарч байна гэж хариулсан байна. Эдгээр байгууллагын 72.1% нь төсөв санхүү хангалтгүй, 32.1 хувь батлагдсан орон тоо хүрэлцээгүй, 22.8 хувь нь ажлын байрны нөхцөл хангалтгүй, 10.6 хувь нь хүний нөөцийн чадавх сул, 7.3 хувь нь тогтсон ажлын байргүй, 3.8 хувь нь бие дааж үйл ажиллагаа явуулах эрх зүйн чадамжгүй, 2.2 хувь нь бусад шалтгаантай байна гэж хариулсан байна.

ЗУРАГ 8.6. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн төрлөөр, хувиар, 2021 он




ЗУРАГ 8.7. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, ажиллах хүчний дутагдал, 2021 он



Төсвийн байгууллагын 49.3 хувьд нь ажиллах хүчний дутагдалтай байна. Ажиллах хүчний дутагдалтай 2265 байгууллагад давхардсан тоогоор 9.9 мянган мэргэжлийн ажилтан шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, нэг төсвийн байгууллагад дунджаар 4 ажилтан шаардлагатай байна. Нийт шаардлагатай ажилтныг мэргэжлийн чиглэлээр нь авч үзэхэд, 74.7 хувь нь мэргэжилтэн эзэлж байна.

ЗУРАГ 8.8. ШААРДЛАГАТАЙ АЖИЛТАН, давхардсан тоогоор, 2021 он



Төсвийн байгууллагад шаардлагатай ажилтны 6.9 хувь нь үйлчилгээний ажилтан, 5.8 хувь нь техникч болон туслах мэргэжилтэн, 4.5 хувь нь менежер, 1.5 хувь нь энгийн ажил, мэргэжилтэн, үлдсэн хувь нь бусад ажил мэргэжилтэн байна.


ХҮСНЭГТ 8.5. ШААРДЛАГАТАЙ АЖИЛТАН, мэргэжлийн чиглэлээр, 2021 он

Мэргэжил	Тоо	%
Бүгд	6 713	100.0
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	44	0.7
Менежер	304	4.5
Мэргэжилтэн	5 015	74.7
Техникч болон туслах мэргэжилтэн	389	5.8
Контор, үйлчилгээний ажилтан	273	4.1
Худалдаа, үйлчилгээний ажилтан	463	6.9
ХАА-н мэргэшсэн ажилтан	3	0.0
Үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан	74	1.1
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	44	0.7
Энгийн ажил, мэргэжил	104	1.5


МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Төсвийн байгууллагын 4.4 мянга буюу 96.1 хувь нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг байна. Эдгээр төсвийн байгууллагад нийт 154.6 мянган компьютер, ухаалаг төхөөрөмж байна. Компьютер, ухаалаг төхөөрөмжийн 78.6 мянга буюу 50.8 хувийг суурин компьютер эзэлж байна.

ЗУРАГ 8.9. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН КОМПЬЮТЕР, УХААЛАГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, хувиар, 2021 он



ЗУРАГ 8. 10. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН КОМПЬЮТЕР, УХААЛАГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, төрлөөр, 2021 он



Төсвийн байгууллагад нийт 154.6 мянган компьютер ашиглагдаж байна. Компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоо 116.6 мянга байна.

ХҮСНЭГТ 8.6. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГАД АШИГЛАЖ
БУЙ КОМПЬЮТЕР, УХААЛАГ ТӨХӨӨРӨМЖ, бүсээр, 2021 он

Бүс	Бүгд	Суурин	Зөөврийн	Таблет	Ухаалаг
Бүгд	154 628	78 599	60 471	5 720	9 838
Баруун	21 531	9178	10558	496	1299
Хангайн	24 820	10771	12188	608	1253
Төвийн	26 609	13085	11358	760	1406
Зүүн	10 327	4625	4979	316	407
Улаанбаатар	71 341	40940	21388	3540	5473

Төсвийн байгууллагад ашиглагдаж байгаа компьютерын 46.1 хувь нь Улаанбаатар хотод, 17.2 хувь нь Төвийн бүсэд, 16.1 хувь нь Хангайн бүсэд, 13.9 хувь нь Баруун бүсэд, 6.7 хувь нь Зүүн бүсэд байна.

Суурин компьютерын 52.1 хувь нь Улаанбаатар хотод, 16.6 хувь нь Төвийн бүсэд, 13.7 хувь нь Хангайн бүсэд, 11.7 хувь нь Баруун бүсэд, 5.9 хувь нь Зүүн бүсэд байна.

Зөөврийн компьютерын 35.4 хувь нь Улаанбаатар хотод, 20.2 хувь нь Хангайн бүсэд, 18.8 хувь нь Төвийн бүсэд, 17.5 хувь нь Баруун бүсэд, 8.2 хувь нь Зүүн бүсэд байна.

Таблетын 61.9 хувь нь Улаанбаатар хотод, 13.3 хувь нь Төвийн бүсэд, 10.6 хувь нь Хангайн бүсэд, 8.7 хувь нь Баруун бүсэд, 5.5 хувь нь Зүүн бүсэд байна.


Харин ухаалаг бусад төхөөрөмжийн 55.6 хувь нь Улаанбаатар хотод, 14.3 хувь нь Төвийн бүсэд, 13.2 хувь нь Баруун бүсэд, 12.7 хувь нь Хангайн бүсэд, 4.1 хувь нь Зүүн бүсэд байна.

Улсын дунджаар нэг нэгжид ногдох компьютер, ухаалаг төхөөрөмжийн тоо 35, нэг нэгжид ногдох компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоо 26 байгаа бол интернэт тогтмол ашигладаг ажиллагчдын тоо 25 байна.

ХҮСНЭГТ 8.7. НЭГ НЭГЖИД НОГДОХ КОМПЬЮТЕР, УХААЛАГ ТӨХӨӨРӨМЖ,
бүсээр, 2021 он

Бүс	Нэг нэгжид ногдох компьютер, ухаалаг төхөөрөмжийн тоо	Нэг нэгжид ногдох компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоо	Нэг нэгжид ногдох интернэт тогтмол ашигладаг ажиллагчдын тоо
Бүгд	35	26	25
Баруун	24	19	18
Хангайн	24	20	20
Төвийн	25	19	18
Зүүн	22	18	17
Улаанбаатар	74	52	53

ЗУРАГ 8.11. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, мэдээллийн технологийн нэгжтэй эсэх, 2021 он



Төсвийн байгууллагын 14.4 хувь буюу 0.7 мянга нь мэдээллийн технологийн нэгжтэй байна.

ЗУРАГ 8.12. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЖИЛЛАГЧИД, хүйсээр, мянган хүн




Төсвийн байгууллагын мэдээллийн технологийн ажиллагчдын тоо 4.5 мянга байна. Эдгээрээс программ хангамжийн ажилтан 2.5 мянга, техник хангамжийн ажилтан 2.0 мянга байна.

ЗУРАГ 8.13. СҮЛЖЭЭ АШИГЛАДАГ ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, сүлжээний төрлөөр, 2021 он



Төсвийн байгууллагын 88.2 хувь буюу 4.1 мянга нь үйл ажиллагаандаа сүлжээ ашигладаг бол тэдгээрийн 39.7 хувь буюу 1.8 мянга (давхардсан тоогоор) нь интранэт/дотоод сүлжээ ашигладаг байна.


ЗУРАГ 8.14. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, цахим технологийн үйлчилгээг нэвтрүүлсэн байдал, 2021 он



Төсвийн байгууллагын 26.1 хувь буюу 1.2 мянга нь инновацын үйл ажиллагааны хүрээнд цахим технологийн үйлчилгээг нэвтрүүлсэн байна.

ЗУРАГ 8.15. ЦАХИМ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТРҮҮЛСЭН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, үйлчилгээний төрөл, дүнд эзлэх хувиар, 2021 он

Инновацын үйл ажиллагааны хүрээнд нэвтрүүлсэн цахим технологийн үйлчилгээний 66.4 хувь нь төсвийн байгууллагын үйлчилгээнд нэвтрүүлсэн программ хангамж, 25.9 хувь нь нийгмийн инновац буюу цахим контент, технологийн программ хангамж байна.



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Төсвийн байгууллагын ажиллагчид, цалин, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогын талаарх мэдээллийг 2020 оны гүйцэтгэлээр энэхүү хэсэгт тусгасан болно.

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод хамрагдсан төсвийн байгууллагын ажиллагчдын тоог бүсээр авч үзвэл, 40.5 хувь нь Улаанбаатар хотод, 18.1 хувь нь Төвийн бүсэд, 17.9 хувь нь Хангайн бүсэд, 15.5 хувь нь Баруун бүсэд, 8.0 хувь нь Зүүн бүсэд байгаа бол өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад Улаанбаатар, Төвийн бүсийн ажиллагчдын дүн 0.4-0.5 нэгж хувиар нэмэгдэж, Баруун, Хангайн, Зүүн бүсүүд 0.2-0.5 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 8.8. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, бүсээр, 2010, 2015, 2020 он

Бүс	2010		2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	150 541	100.0	182 974	100.0	194 390	100.0
Баруун	24 083	16.0	28 708	15.7	30 085	15.5
Хангайн	28 031	18.6	33 095	18.1	34 804	17.9
Төвийн	27 101	18.0	32 530	17.8	35 266	18.1
Зүүн	12 603	8.4	15 626	8.5	15 550	8.0
Улаанбаатар	58 723	39.0	73 015	39.9	78 685	40.5


Улсын хэмжээнд 4.6 мянган төсвийн байгууллагад 194.4 мянган ажиллагчид ажиллаж байгаагаас боловсролын салбарт 86.1 мянга буюу 44.3 хувь нь, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт 61.5 мянга буюу 31.6 хувь нь, нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 28.6 мянга буюу 14.7 хувь нь, бусад салбарт 10.3 мянга буюу 5.3 хувь нь, үлдсэн 7.9 мянга буюу 4.0 хувь нь урлаг, үзвэр, тоглоом наадмын үйл ажиллагааны салбарт ажиллаж байна.

ХҮСНЭГТ 8.9. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, 2010, 2015, 2020 он

Салбар	2010		2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	150 541	100.0	182 974	100.0	194 390	100.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	47 749	31.7	62 243	34.0	61 484	31.6
Боловсрол	63 495	42.2	75 154	41.1	86 139	44.3
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	25 009	16.6	27 109	14.8	28 646	14.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	6 329	4.2	8 341	4.6	7 864	4.0
Бусад	7 959	5.3	10 127	5.5	10 257	5.3

Нийт ажиллагчдын 73.0 мянга буюу 37.6 хувь нь эрэгтэй, 121.4 мянга буюу 62.4 хувь нь эмэгтэй ажиллагчид байна. Төсвийн байгууллагад эмэгтэй ажиллагчид давамгайлж байна.

ЗУРАГ 8.16. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, бүс, хүйсээр, 2020 он



Тооллогын дүнгээр төсвийн байгууллагад 2020 онд 194.4 мянган хүн ажилласан ба тэдгээрийн сарын дундаж цалин 940.9 мянган төгрөг байжээ. Төсвийн байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин Улаанбаатар хотод 999.2 мянган төгрөг, Төвийн бүсэд 969.8 мянган төгрөг, Хангайн бүсэд 903.9 мянган төгрөг, Баруун бүсэд 901.9 мянган төгрөг, Зүүн бүсэд 916.1 мянган төгрөг байна.

50, түүнээс дээш ажиллагчидтай төсвийн байгууллагын сарын дундаж цалин 1039.2 мянган төгрөг, 20-49 ажиллагчидтай байгууллагынх 893.4 мянган төгрөг, 10-19 ажиллагчидтай байгууллагынх 948.3 мянган төгрөг, 1-9 ажиллагчидтай байгууллагынх 920.7 мянган төгрөг байна.

ХҮСНЭГТ 8.10. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, бүс, ажиллагчдын тооны бүлэг, мянган төгрөгөөр, 2020 он

Бүс	Бүгд	Ажиллагчдын тооны бүлэг			
		1-9	10-19	20-49	50, түүнээс дээш
Бүгд	940.9	920.7	948.3	893.4	1 039.2
Баруун	901.9	863.3	930.6	887.8	962.3
Хангайн	903.9	845.2	934.2	895.3	984.6
Төвийн	969.8	1 040.4	961.8	901.3	1 040.8
Зүүн	916.1	947.7	920.7	869.8	999.7
Улаанбаатар	999.2	915.4	1 005.0	901.3	1 096.1

Улсын хэмжээнд нийт 4.6 мянган төсвийн байгууллагад 194.4 мянган ажилтан ажиллаж, 2.4 их наяд төгрөгийн цалин олгосон бөгөөд өмнөх тооллогоос ажиллагчдын тоо 11.4 мянгаар, цалин 837.9 тэрбум төгрөгийн нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 8.11. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, ЦАЛИН,
ажиллагчдын тооны бүлгээр, 2015, 2020 он

Ажиллагчдын тооны бүлэг	2015		2020	
	Ажиллагчдын тоо	Цалин, тэрбум төгрөг	Ажиллагчдын тоо	Цалин, тэрбум төгрөг
Бүгд	182 974	1 566.0	194 390	2 403.9
1-9	5 012	61.4	5 009	53.2
10-19	11 688	102.6	10 734	121.6
20-49	50 577	420.2	54 738	589.4
50, түүнээс дээш	115 697	981.8	123 909	1 639.7

Төсвийн байгууллагын үндсэн бус үйл ажиллагааны орлого 2020 онд 2.8 их наяд төгрөг, үүний туслах үйл ажиллагааны орлого 172.8 тэрбум төгрөг буюу 6.1 хувь, төсөл хөтөлбөрийн санхүүжилт 593.0 тэрбум төгрөг буюу 21.0 хувь, бусад орлого 2.1 их наяд төгрөг буюу 72.9 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 8.12. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН БУС ОРЛОГО, тэрбум төгрөг,
2020 он


Бүс, аймаг, нийслэл	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	Туслах үйл		
		ажиллагааны орлого	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт	Бусад орлого
Бүгд	2 823.8	172.8	593.0	2 058.0
Баруун	67.3	11.4	42.7	13.2
Баян-Өлгий	10.9	1.1	9.0	0.8
Говь-Алтай	19.7	2.8	12.9	4.0
Завхан	12.0	3.3	3.7	5.0
Увс	8.5	0.9	6.1	1.5
Ховд	16.2	3.3	11.1	1.8
Хангайн	140.4	11.5	106.7	22.2
Архангай	13.9	0.5	6.7	6.6
Баянхонгор	10.9	1.2	3.3	6.4
Булган	5.3	1.0	3.1	1.1
Орхон	1.0	0.3	0.1	0.6
Өвөрхангай	22.8	4.2	15.5	3.1
Хөвсгөл	86.6	4.2	78.0	4.4
Төвийн	342.7	59.7	99.4	183.6
Говьсүмбэр	9.2	2.5	4.6	2.1
Дархан-Уул	23.8	2.0	8.0	13.8
Дорноговь	25.8	6.5	12.5	6.8
Дундговь	6.5	3.3	2.1	1.1
Өмнөговь	203.2	37.4	37.8	128.0
Сэлэнгэ	52.2	3.6	18.0	30.7
Төв	22.0	4.4	16.5	1.1
Зүүн	546.3	6.2	20.2	519.9
Дорнод	10.7	2.0	6.9	1.8
Сүхбаатар	5.9	0.7	4.6	0.7
Хэнтий	529.7	3.5	8.8	517.4
Улаанбаатар	1 726.6	84.0	323.9	1 319.1

ӨГӨГДЛИЙН САН


Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын төсвийн байгууллагын асуулгаар өгөгдлийн сангийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулсан.

ЗУРАГ 8.17. ӨГӨГДЛИЙН САНГИЙН НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛ, төрөл, дүнд эзлэх хувиар, 2021 он

Төсвийн байгууллагын 67 нь өөрийн удирдан хөгжүүлдэг 157 өгөгдлийн сантай байна. Өгөгдлийн сангийн нууцын зэрэглэлийг авч үзвэл, 70.1 хувь нь албаны нууцын зэрэглэлтэй, 17.8 хувь нь нээлттэй, 12.1 хувь нь төрийн нууцын зэрэглэлтэй байна.




ЗУРАГ 8.18. ӨГӨГДЛИЙН САНГИЙН БИЧЛЭГИЙН ТҮВШИН, дүнд эзлэх хувиар, 2021 он




Нийт 157 өгөгдлийн санг бичлэгийн түвшнээр авч үзвэл, 52.2 хувь нь нэгтгэсэн буюу бүх төрлийн мэдээлэл агуулсан, 30.6 хувь нь аж ахуйн нэгж, байгууллага, 15.9 хувь нь хувь хүний, 1.3 хувь нь объектын мэдээллийг бүрдүүлсэн байна.

ЗУРАГ 8.19. ӨГӨГДЛИЙН САНГИЙН ХЭРЭГЛЭГЧ, дүнд эзлэх хувиар, 2021 он



Өгөгдлийн сангийн хэрэглэгчдийг авч үзэхэд, 69.4 хувийг эрх бүхий төрийн албан хаагчид, 15.3 хувийг аж ахуйн нэгж, байгууллага, 5.7 хувийг иргэд, 9.6 хувийг бусад төрлийн хэрэглэгч ашигладаг байна.


ЗУРАГ 8.20. ӨГӨГДЛИЙН САНГИЙН ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, дүнд эзлэх хувиар, 2021 он



Өгөгдлийн сангийн программ хангамжийн төрлийг авч үзвэл, 43.3 хувь нь Oracle программ, 24.2 хувь нь MySQL программ, 20.4 хувь нь MSSQL программ, 7.0 хувь нь PostgreSQL программ бол үлдсэн 5.1 хувийг бусад төрлийн программ хангамж ашигласан байна.

Өгөгдлийн сан удирдахдаа дээрх программуудыг ашигладаг бол 56.1 хувь нь өөрийн дата төв дээр, 39.5 хувь нь Үндэсний дата төв дээр, үлдсэн 4.5 хувь нь бусад байршилд өгөгдлийн сангаа байршуулдаг байна.

ЗУРАГ 8.21. ӨГӨГДЛИЙН САНГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүнд эзлэх хувиар, 2021 он



Төсвийн байгууллагын өгөгдлийн сангийн 49.0 хувь нь ХУР системд холбогдсон бол 23.6 хувь нь E-Mongolia-д үйлчилгээ үзүүлдэг гэж хариулсан байна. Өгөгдлийн сангийн 88.5 хувь нь боловсруулалт дүн шинжилгээ хийдэг байна.


Өгөгдлийн сан хөгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг авч үзвэл, 48.4 хувь нь ажиллах хүчний нөөц, 20.4 хувь нь санхүүжилт, 11.5 хувь нь хамгаалалт, аюулгүй байдал, 12.1 хувь нь техник тоног төхөөрөмж, 7.6 хувь нь бусад хүндрэлүүдтэй тулгарч байна.

ЗУРАГ 8.22. ӨГӨГДЛИЙН САН ХӨГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, дүнд эзлэх хувиар, 2021 он




Төсвийн байгууллагууд 2016 оноос хойш үйл ажиллагаандаа өгөгдлийн сан нэлээд нэвтрүүлсэн байна. Өгөгдлийн санг нэвтрүүлсэн хугацааг авч үзэхэд, 49.7 хувь нь 2016-2021 онд, 24.2 хувь нь 2011-2015 онд, 14.6 хувь нь 2006-2010 онд, 11.5 хувь нь 2006 он хүртэлх хугацаанд нэвтрүүлсэн байна.

ЗУРАГ 8.23. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, өгөгдлийн сан үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн хугацаа, дүнд эзлэх хувиар, 2021 он



Төсвийн байгууллагын өгөгдлийн сангийн хөрөнгө оруулалтын хамарсан хугацааг авч үзвэл, 70.1 хувь нь 1-4 жилдээ хийгдсэн, 14.6 хувь нь 1 жил хүртэлх, 12.7 хувь нь 5-10 жил, 2.5 хувь нь 11, түүнээс дээш жилийг хамарсан байна.

ЗУРАГ 8.24. ӨГӨГДЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХУГАЦАА, дүнд эзлэх хувиар, 2021 он




Төсвийн байгууллагын өгөгдлийн санд 45.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол программ хангамжийн хөрөнгө оруулалт 28.5 тэрбум төгрөг буюу 62.1 хувийг, техник хангамжийн хөрөнгө оруулалт 17.4 тэрбум төгрөг буюу 37.9 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 8.13. ӨГӨГДЛИЙН САНД ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, сая төгрөг, 2021 он

Төрөл	Нийт хөрөнгө оруулалт		Программ хангамж		Техник хангамж	
	Дүн	%	Дүн	%	Дүн	%
Бүгд	45 922.2	100.0	28 501.5	100.0	17 420.7	100.0
Oracle	37 370.1	81.4	23 218.9	81.5	14 151.2	81.2
MSSQL	5 546.2	12.1	3 251.2	11.4	2 295.0	13.2
MySql	2 646.7	5.8	1 675.4	5.9	971.2	5.6
PostgreSQL	196.0	0.4	196.0	0.7	-	-
Бусад	163.2	0.4	160.0	0.6	3.2	0.0

Нийт хөрөнгө оруулалтын 81.4 хувь нь Oracle программ, 12.1 хувь нь MSSQL программ, 5.8 хувь нь MySql программ, үлдсэн хэсэг нь бусад программ хангамжид оруулсан хөрөнгө оруулалт байна.


ЗУРАГ 8.25. ӨГӨГДЛИЙН САНГИЙН ПРОГРАММЫН ЛИЦЕНЗ АШИГЛАЛТ, 2021 он



Төсвийн байгууллагын өгөгдлийн санд ашигладаг 317 программын 152 нь лицензтэй байгаа бол 165 лицензгүй байна.

Өгөгдлийн сангийн зардлыг авч үзвэл, жилийн дундаж урсгал зардлын 5.8 тэрбум төгрөг буюу 40.1 хувийг программ хангамжийн зардал, 5.2 тэрбум төгрөг буюу 35.8 хувийг тоног төхөөрөмжийн зардал, 0.7 тэрбум буюу 5.1 хувийг засвар үйлчилгээний зардал, 2.8 тэрбум төгрөг буюу 19.0 хувийг бусад зардал эзэлж байна.

ЗУРАГ 8.26. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨГӨГДЛИЙН САНГИЙН
ЖИЛИЙН ДУНДАЖ УРСГАЛ ЗАРДАЛ, дүнд эзлэх хувиар



9

БҮЛЭГ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА,
төрөл, тооллого явагдсан оноор




БҮЛЭГ 9. | ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТОО

Тооллогоор нийгэм болон гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага; үйлдвэрчний эвлэлийн байгууллага; үндэсний хүмүүнлэгийн байгууллага; шашны байгууллага; сан; улс төрийн нам; олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газар, Монгол Улсад суугаа элчин сайдын яамд; төсөл хөтөлбөрүүдээс мэдээлэл цуглуулсан.

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага нь соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг ойлгоно.

ЗУРАГ 9.1. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, тооллого явагдсан оноор




Ажахуйн нэгжийн 2021 оны тооллогоор 23 852 төрийн бус байгууллага тоологдож, 2006 оноос 10.2 дахин, 2011 оны тооллогоос 4.1 дахин, 2016 оны тооллогоос 85.6 хувиар өсжээ.

Тооллогод 23.9 мянган төрийн бус байгууллага хамрагдсаны 7.8 мянга нь үйл ажиллагаа явуулж байна. Төрийн бус байгууллагын 68.2 хувь буюу 16.3 мянга нь Улаанбаатар хотод байршиж байна.

ХҮСНЭГТ 9.1. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, бүс, аймаг, нийслэл, үйл ажиллагаа
эрхлэлтийн байдлаар, 2021 он

Бүс, аймаг, нийслэл	Төрийн бус байгууллагын тоо	Үйл ажиллагаа эрхлэлтийн байдал	
		Тооллогын хугацаанд үйл ажиллагаа явуулсан	2020 онд үйл ажиллагаа явуулсан
Бүгд	23 852	7 766	6 195
Баруун бүс	1 660	718	510
Баян-Өлгий	396	225	146
Говь-Алтай	175	69	61
Завхан	382	142	109
Увс	285	95	70
Ховд	422	187	124
Хангайн бүс	2 415	938	755
Архангай	308	114	95
Баянхонгор	374	135	106
Булган	191	75	63
Орхон	774	298	243
Өвөрхангай	406	162	123
Хөвсгөл	362	154	125
Төвийн бүс	2 476	867	674
Говьсүмбэр	123	42	25
Дархан-Уул	611	263	216
Дорноговь	365	166	146
Дундговь	189	47	31
Өмнөговь	446	109	72
Сэлэнгэ	375	137	104
Төв	367	103	80
Зүүн бүс	1 031	423	333
Дорнод	421	178	134
Сүхбаатар	225	98	81
Хэнтий	385	147	118
Улаанбаатар	16 270	4 820	3 923

ЗУРАГ 9.2. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, төрөл, дүнд эзлэх хувиар, 2021 он




Тооллогод хамрагдсан ТББ-ын 73.8 хувь нь нийгэмд үйлчилдэг, 26.2 хувь нь гишүүддээ үйлчилдэг байна.

10 ТББ тутмын 3 нь үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-ын 60.9 хувь нь нийгэмд үйлчилдэг, 39.1 хувь нь гишүүддээ үйлчилдэг байна.


Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогоор 23.9 мянган төрийн бус байгууллага тоологдсоноос Орхон, Дархан-Уул аймгууд 600-800 хооронд байгаа бол Булган, Дундговь, Говь-Алтай, Говьсүмбэр аймагт 200 хүртэлх төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хот хамгийн их буюу 16.3 мянган төрийн бус байгууллагатай байна.

ЗУРАГ 9.3. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТАРХАЛТ, аймаг, нийслэлээр, 2021 он



Монгол Улсад бүртгэлтэй төрийн бус байгууллагын дийлэнх нь төрд тавих хяналтыг сайжруулах буюу нийгэмд үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ чиглэлийн төрийн бус байгууллагын тоо сүүлийн 5 жилд 1.8 дахин өссөн байна.

ЗУРАГ 9.4. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, төрийн бус байгууллагын төрөл, тооллого явагдсан оноор



Улсын дунджаар 10000 хүнд ногдох төрийн бус байгууллагын тоо 70 байгаа бол нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын тоо 52 байна.

ХҮСНЭГТ 9.2. 10000 ХҮНД НОГДОХ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, бүсээр, 2021 он

Бүс	10000 хүнд ногдох төрийн бус байгууллага	10000 хүнд ногдох нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
Бүгд	70	52
Баруун	40	26
Хангайн	40	27
Төвийн	48	31
Зүүн	46	27
Улаанбаатар	101	78


Тооллогод хамрагдсан төрийн бус байгууллагын 16.3 мянга буюу 68.2 хувь нь Улаанбаатар хотод, 2.5 мянга буюу 10.4 хувь нь Төвийн бүсэд, 2.4 мянга буюу 10.1 хувь нь Хангайн бүсэд, 1.7 мянга буюу 7.0 хувь нь Баруун бүсэд, 1.0 мянга буюу 4.3 хувь нь Зүүн бүсэд байрлаж байна. ТББ-ын тоог 2016 оны тооллогын дүнтэй харьцуулахад, төрийн бус байгууллага нь Хангайн бүсэд 2.0 нэгж хувиар, Баруун бүсэд 1.3 нэгж хувиар, Зүүн бүсэд 1.0 нэгж хувиар, Төвийн бүсэд 0.6 нэгж хувиар нэмэгдсэн бол Улаанбаатар хотод 4.9 нэгж хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 9.3. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, бүс, аймаг, нийслэл, төрийн бус байгууллагын төрөл, тооллого явагдсан оноор

Бүс, аймаг, нийслэл	2016			2021		
	Бүгд	Нийгэмд үйлчилдэг	Гишүүддээ үйлчилдэг	Бүгд	Нийгэмд үйлчилдэг	Гишүүддээ үйлчилдэг
Бүгд	12 851	9 754	3 097	23 852	17 604	6 248
Баруун бүс	732	565	167	1 660	1 098	562
Баян-Өлгий	215	177	38	396	257	139
Говь-Алтай	75	59	16	175	114	61
Завхан	175	127	48	382	249	133
Увс	125	88	37	285	208	77
Ховд	142	114	28	422	270	152
Хангайн бүс	1 038	700	338	2 415	1 652	763
Архангай	98	68	30	308	190	118
Баянхонгор	153	96	57	374	230	144
Булган	71	43	28	191	112	79
Орхон	344	218	126	774	538	236
Өвөрхангай	183	135	48	406	328	78
Хөвсгөл	189	140	49	362	254	108
Төвийн бүс	1 260	796	464	2 476	1 591	885
Говьсүмбэр	60	38	22	123	82	41
Дархан-Уул	401	275	126	611	404	207
Дорноговь	156	86	70	365	205	160
Дундговь	71	48	23	189	126	63
Өмнөговь	152	109	43	446	304	142
Сэлэнгэ	216	126	90	375	257	118
Төв	204	114	90	367	213	154
Зүүн бүс	428	259	169	1 031	614	417
Дорнод	160	94	66	421	221	200
Сүхбаатар	128	72	56	225	129	96
Хэнтий	140	93	47	385	264	121
Улаанбаатар	9 393	7 434	1 959	16 270	12 649	3 621


Тооллогод хамрагдсан төрийн бус байгууллагын 32.6 хувь буюу 7.8 мянга нь үйл ажиллагаа явуулж байгаа бол 16.1 мянга буюу 67.4 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

ЗУРАГ 9.5. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, төрийн бус байгууллагын төрөл, хувиар, 2021 он



10 ТББ тутмын 3 нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Үйл ажиллагаа явуулаагүй шалтгааныг харахад 58.6 хувь нь түр хугацаанд зогссон байна.

ЗУРАГ 9.6. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, шалтгаан, дүнд эзлэх хувиар, 2021 он



Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод хамрагдсан үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын 46.7 хувийг 1-2 ажиллагчидтай, 29.1 хувийг 3-5 ажиллагчидтай, 12.0 хувийг 6-9 ажиллагчидтай, 7.4 хувийг 10-20 ажиллагчидтай, 4.8 хувийг 21, түүнээс дээш ажиллагчидтай төрийн бус байгууллага эзэлж байна.


Энэ удаагийн тооллогын дүнг 2016 оны тооллогын дүнтэй харьцуулахад 1-2 ажиллагчидтай ТББ-ын эзлэх хувийн жин 8.3 нэгж хувиар нэмэгдэж, бусад ажиллагчдын тооны бүлэг 0.4-3.5 нэгж хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 9.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА,
бүс, аймаг, нийслэл, ажиллагчдын тооны бүлгээр, 2021 он

Бүс, аймаг, нийслэл	Бүгд	Ажиллагчдын тооны бүлэг				
		1-2	3-5	6-9	10-20	21, түүнээс дээш
Бүгд	7 766	3 623	2 263	934	573	373
Баруун бүс	718	316	236	83	45	38
Баян-Өлгий	225	114	79	16	12	4
Говь-Алтай	69	35	12	14	2	6
Завхан	142	67	40	18	13	4
Увс	95	39	34	8	8	6
Ховд	187	61	71	27	10	18
Хангайн бүс	938	411	273	129	66	59
Архангай	114	43	41	13	12	5
Баянхонгор	135	61	27	21	13	13
Булган	75	37	15	12	5	6
Орхон	298	136	98	46	12	6
Өвөрхангай	162	79	46	15	15	7
Хөвсгөл	154	55	46	22	9	22
Төвийн бүс	867	421	262	79	58	47
Говьсүмбэр	42	27	11	2	2	0
Дархан-Уул	263	134	74	27	14	14
Дорноговь	166	71	60	17	9	9
Дундговь	47	29	8	5	4	1
Өмнөговь	109	50	29	12	11	7
Сэлэнгэ	137	62	46	9	10	10
Төв	103	48	34	7	8	6
Зүүн бүс	423	207	116	49	29	22
Дорнод	178	106	40	13	10	9
Сүхбаатар	98	28	36	21	6	7
Хэнтий	147	73	40	15	13	6
Улаанбаатар	4 820	2 268	1 376	594	375	207

Үйл ажиллагаа явуулж байгаа 7.8 мянган төрийн бус байгууллагын 3.0 мянга буюу 38.1 хувь нь 2019, 2020 онд татварын байгууллагад тайлан өгөөгүй байна.

ЗУРАГ 9.7. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА,
тайлагналтын төрлөөр, хувиар, 2019, 2020 он



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Энэ удаагийн тооллогоор ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны ангилал (ICNPI)-аар мэдээлэл цуглуулсан болно. ТББ-ыг үйл ажиллагааны ангиллаар авч үзвэл, бизнес, мэргэжлийн холбоод, эвлэлийн үйл ажиллагаа 3.8 мянга буюу 15.8 хувийг, хөгжлийн хөтөлбөр болон орон сууцтай холбогдох үйлчилгээ явуулдаг ТББ 3.5 мянга буюу 14.6 хувийг, соёл амралт, чөлөөт цагийн үйлчилгээ явуулдаг ТББ 3.1 мянга буюу 12.8 хувийг, боловсрол, судалгаа шинжилгээний үйл ажиллагаа явуулдаг ТББ 2.9 мянга буюу 12.3 хувийг, нийгмийн үйлчилгээ явуулдаг ТББ 2.3 мянга буюу 9.5 хувийг, хандивын байгууллага, сайн дурын үйл ажиллагаа явуулдаг ТББ 1.6 мянга буюу 6.7 хувийг, хүрээлэн буй орчны үйл ажиллагаа явуулдаг ТББ 1.4 мянга буюу 5.9 хувийг, хууль, эрх зүй, өмгөөлөл, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг ТББ 1.1 мянга буюу 4.5 хувийг, шашны үйл ажиллагаа явуулдаг 919 байгууллага буюу 3.9 хувийг, эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулдаг 732 байгууллага буюу 3.1 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 9.5. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, үйл ажиллагааны ангилал, төрийн бус байгууллагын төрөл, дүнд эзлэх хувиар, 2021 он

Үйл ажиллагааны ангилал	Бүгд	Нийгэмд үйлчилдэг	Гишүүддээ үйлчилдэг
Бүгд	23 852	100.0	100.0
Соёл амралт, чөлөөт цагийн үйлчилгээ	3 060	13.9	9.9
Боловсрол, судалгаа шинжилгээний үйл ажиллагаа	2 945	15.1	4.6
Эрүүл мэнд	732	3.8	1.0
Нийгмийн үйлчилгээ	2 270	11.5	3.9
Хүрээлэн буй орчны үйл ажиллагаа	1 402	6.8	3.2

Үйл ажиллагааны ангилал	Бүгд	Төрийн бус байгууллагын төрөл, эзлэх хувиар, 2021 он	
		Нийгэмд үйлчилдэг	Гишүүддээ үйлчилдэг
Хөгжлийн хөтөлбөр болон орон сууцтай холбогдох үйлчилгээ	3 490	12.1	21.7
Хууль, эрх зүй, өмгөөлөл, улс төрийн үйл ажиллагаа	1 064	4.6	4.0
Хандивын байгууллага, сайн дурын үйл ажиллагаа	1 603	7.9	3.5
Олон улсын үйл ажиллагаа	173	0.9	0.4
Шашны үйл ажиллагаа	919	3.3	5.3
Бизнес, мэргэжлийн холбоод, эвлэлийн үйл ажиллагаа	3 762	10.2	31.5
Дээрх бүлэгт ороогүй бусад үйл ажиллагаа	2 432	9.9	11.0

Төрийн бус байгууллагыг төрлөөр авч үзвэл, нийгэмд үйлчилдэг ТББ-ын 15.1 хувийг, гишүүддээ үйлчилдэг ТББ-ын 4.6 хувийг боловсрол, судалгаа шинжилгээний үйл ажиллагаа явуулдаг ТББ эзэлж байгаа бол нийгэмд үйлчилдэг ТББ-ын 10.2 хувийг, гишүүддээ үйлчилдэг ТББ-ын 31.5 хувийг бизнес, мэргэжлийн холбоод, эвлэлийн үйл ажиллагаа явуулдаг ТББ эзэлж байна.

ЗУРАГ 9.8. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, үйл ажиллагааны ангилал, төрийн бус байгууллагын төрөл, эзлэх хувиар, 2021 он



Бизнес, мэргэжлийн холбоод, эвлэлийн үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд нь Зүүн бүсийн ТББ-ын 27.7 хувийг, Баруун бүсийн ТББ-ын 26.3 хувийг, Төвийн болон Хангайн бүсийн ТББ-ын 21.7 хувийг, Улаанбаатар хотын ТББ-ын 12.1 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 9.6. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, үйл ажиллагааны ангилал, бүсээр,
2021 он

Үйл ажиллагааны ангилал	Бүгд	Бүс				
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар
Бүгд	23 852	1 660	2 415	2 476	1 031	16 270
Соёл амралт, чөлөөт цагийн үйлчилгээ	3 060	206	323	350	134	2 047
Боловсрол, судалгаа шинжилгээний үйл ажиллагаа	2 945	151	229	229	71	2 265
Эрүүл мэнд	732	26	76	41	15	574
Нийгмийн үйлчилгээ	2 270	123	228	199	98	1 622
Хүрээлэн буй орчны үйл ажиллагаа	1 402	127	186	196	67	826
Хөгжлийн хөтөлбөр болон орон сууцтай холбогдох үйлчилгээ	3 490	152	244	328	103	2 663
Хууль, эрх зүй, өмгөөлөл, улс төрийн үйл ажиллагаа	1 064	66	104	98	36	760
Хандивын байгууллага, сайн дурын үйл ажиллагаа	1 603	75	110	138	54	1 226
Олон улсын үйл ажиллагаа	173	3	8	9	6	147
Шашны үйл ажиллагаа	919	133	146	149	49	442
Бизнес, мэргэжлийн холбоод, эвлэлийн үйл ажиллагаа	3 762	437	540	523	286	1 976
Дээрх бүлэгт ороогүй бусад үйл ажиллагаа	2 432	161	221	216	112	1 722

Харин хөгжлийн хөтөлбөр болон орон сууцтай холбогдох үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд нь Улаанбаатар хотын ТББ-ын 16.4 хувийг, Хангайн болон Төвийн бүсийн ТББ-ын 11.7 хувийг, Зүүн бүсийн ТББ-ын 10.0 хувийг, Баруун бүсийн ТББ-ын 9.2 хувийг тус тус эзэлж байна.

Төрийн бус байгууллагыг үйл ажиллагааны ангилал, ажиллагчдын тооны бүлгээр авч үзэхэд, хандивын байгууллага, сайн дурын үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын 76.1 хувийг 1-2 ажиллагчидтай ТББ эзэлж байгаа бол шашны үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын 25.7 хувийг 3-5 ажиллагчидтай ТББ, хөгжлийн хөтөлбөр болон орон сууцтай холбогдох үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын 10.4 хувийг 6-9 ажиллагчидтай ТББ эзэлж байна.


ХҮСНЭГТ 9.7. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, үйл ажиллагааны ангилал, ажиллагчдын тооны бүлгээр, 2021 он

Үйл ажиллагааны ангилал	Бүгд	Ажиллагчдын тооны бүлэг					21, түүнээс дээш
		1-2	3-5	6-9	10-20		
Бүгд	23 852	16 127	4 719	1 574	917	515	
Соёл амралт, чөлөөт цагийн үйлчилгээ	3 060	2 223	543	167	89	38	
Боловсрол, судалгаа шинжилгээний үйл ажиллагаа	2 945	2 109	524	160	99	53	
Эрүүл мэнд	732	507	155	38	21	11	
Нийгмийн үйлчилгээ	2 270	1 569	466	132	75	28	
Хүрээлэн буй орчны үйл ажиллагаа	1 402	952	288	97	43	22	
Хөгжлийн хөтөлбөр болон орон сууцтай холбогдох үйлчилгээ	3 490	2 002	859	362	224	43	
Хууль, эрх зүй, өмгөөлөл, улс төрийн үйл ажиллагаа	1 064	742	189	72	42	19	
Хандивын байгууллага, сайн дурын үйл ажиллагаа	1 603	1 220	243	73	45	22	
Олон улсын үйл ажиллагаа	173	118	32	10	6	7	
Шашны үйл ажиллагаа	919	494	236	80	65	44	
Бизнес, мэргэжлийн холбоод, эвлэлийн үйл ажиллагаа	3 762	2 444	782	249	127	160	
Дээрх бүлэгт ороогүй бусад үйл ажиллагаа	2 432	1 747	402	134	81	68	

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ


Төрийн бус байгууллагын 34.3 хувь нь компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг байна. Ашиглаж байгаа компьютер, ухаалаг төхөөрөмжийн 51.5 хувь нь суурин компьютер байна. ТББ-ын 19.3 мянган ажилтан компьютер, ухаалаг төхөөрөмж тогтмол ашигладаг байна.

ЗУРАГ 9.9. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН КОМПЬЮТЕРЫН АШИГЛАЛТ, дүнд эзлэх хувиар, 2021 он



Төрийн бус байгууллагын 31.5 хувь нь сүлжээ ашигладаг байна. Үйл ажиллагаандаа ашигладаг сүлжээний төрлөөр нь авч үзвэл, 81.8 хувь нь интернэт ашигладаг байна. ТББ-ын 18.0 мянган ажилтан интернэт тогтмол ашигладаг байна.

ЗУРАГ 9.10. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН СҮЛЖЭЭ АШИГЛАЛТ, дүнд эзлэх хувиар, 2021 он



Төрийн бус байгууллагын 32.5 хувь нь мэдээ, мэдээлэл авах, илгээх, 16.5 хувь нь и-мэйл авах, явуулах, 15.2 хувь нь харилцагч, хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэх, 12.4 хувь нь төрийн болон олон нийтийн байгууллагуудтай харилцах, 10.0 хувь нь интернэт банкны үйлчилгээнд хамрагдах, 9.1 хувь нь санхүүгийн бусад үйлчилгээнд хамрагдах, 2.4 хувь нь эд юмс, тоног төхөөрөмж удирдах, 1.5 хувь нь бараа бүтээгдэхүүнийг онлайн аар хүргэх зорилгоор интернэт ашигладаг байна.

ЗУРАГ 9.11. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ИНТЕРНЭТ АШИГЛАЛТЫН ЗОРИЛГО, дүнд эзлэх хувиар, 2021 он



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт аж ахуйн нэгжийн тооллогод хамрагдсан төрийн бус байгууллагын эдийн засгийн голлох үзүүлэлтийг авч үзлээ.


Энэ удаагийн тооллогод хамрагдсан ТББ-д 2020 онд 43.9 мянган ажиллагчид ажилласны 25.3 мянга (57.6%) нь эмэгтэй ажиллагчид байна. Бүс нутгаар нь авч үзвэл, 26.2 мянга буюу 59.7 хувь нь Улаанбаатар хотод, 6.1 мянга буюу 14.0 хувь нь Хангайн бүсэд, 5.6 мянга буюу 12.7 хувь нь Төвийн бүсэд, 3.8 мянга буюу 8.7 хувь нь Баруун бүсэд, 2.2 мянга буюу 4.9 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

ХҮСНЭГТ 9.8. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, бүсээр, 2010, 2015, 2020 он

Бүс	2010		2015		2020	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	25 358	12 064	33 549	18 591	43 922	25 304
Баруун	1 719	654	1 650	612	3 818	1 960
Хангайн	2 482	988	2 746	1 294	6 128	3 748
Төвийн	3 447	1 629	2 896	1 582	5 588	3 072
Зүүн	943	387	1 184	607	2 163	1 417
Улаанбаатар	16 767	8 406	25 073	14 496	26 225	15 107


Тооллогод хамрагдсан 23.9 мянган төрийн бус байгууллагын 16.1 мянга буюу 67.6 хувь нь 1-2 ажиллагчидтай, 4.7 мянга буюу 19.8 хувь нь 3-5 ажиллагчидтай, 1.6 мянга буюу 6.6 хувь нь 6-9 ажиллагчидтай, 0.9 мянга буюу 3.8 хувь нь 10-20 ажиллагчидтай, 0.5 мянга буюу 2.2 хувь нь 21, түүнээс дээш ажиллагчидтай байна. 1-2 ажиллагчидтай төрийн бус байгууллагын 78.2 хувь нь, 3-5 ажиллагчидтай ТББ-ын 68.3 хувь нь, 6-9 ажиллагчидтай ТББ-ын 61.0 хувь нь, 10-20 ажиллагчидтай ТББ-ын 60.4 хувь нь, 21, түүнээс дээш ажиллагчидтай ТББ-ын 49.7 хувь нь нийгэмд үйлчилдэг байна.

ЗУРАГ 9.12. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ажиллагчдын тооны бүлэг, ТББ-ын төрлөөр, 2021 он



Төрийн бус байгууллагад ажиллаж байгаа 43.9 мянган ажиллагчдын 23.0 мянга буюу 52.4 хувь нь нийгэмдээ үйлчилдэг ТББ-д ажиллаж байгаагийн 12.7 мянга буюу 55.2 хувийг нь эмэгтэй ажиллагчид байна. Нийт 38.0 мянган сайн дурын ажиллагчдын 68.1 хувь нь нийгэмд үйлчилдэг, 31.9 хувь нь гишүүддээ үйлчилдэг ТББ-д ажилладаг байна.

ЗУРАГ 9.13. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, төрийн бус байгууллагын төрөл, хүйсээр, 2020 он



Төрийн бус байгууллага нийт ажиллагчдадаа 2020 онд 205.3 тэрбум төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь өмнөх тооллоготой харьцуулахад 1.5 дахин нэмэгдсэн байна. ТББ-ын нэг ажилтны жилийн дундаж цалин 4.7 сая төгрөг байна.

ХҮСНЭГТ 9.9. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН ЦАЛИН, бүсээр, 2015, 2020 он

Бүс	2015		2020	
	Цалин, сая төгрөг	Нэг ажилтны жилийн дундаж цалин мянган төгрөг	Цалин, сая төгрөг	Нэг ажилтны жилийн дундаж цалин мянган төгрөг
Бүгд	134 827.5	4 018.8	205 283.4	4 673.8
Баруун	1 868.3	1 132.3	11 407.4	2 987.8
Хангайн	3 378.5	1 230.3	9 876.2	1 611.6
Төвийн	4 277.5	1 477.0	10 863.3	1 944.0
Зүүн	1 281.7	1 082.5	1 507.8	697.1
Улаанбаатар	124 021.5	4 946.4	171 628.8	6 544.5

Төрийн бус байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 532.7 мянган төгрөг байна. 1-2 ажиллагчидтай ТББ-ын ажиллагчдын сарын дундаж цалин 705.2 мянган төгрөг байгаа бол 3-5 ажиллагчидтай байгууллагынх 335.2 мянга, 6-9 ажиллагчидтай байгууллагынх 425.9 мянга, 10-20 ажиллагчидтай байгууллагынх 578.2 мянга, 21, түүнээс дээш ажиллагчидтай байгууллагынх 377.9 мянган төгрөг байна.

ХҮСНЭГТ 9.10. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, үйл ажиллагааны төрөл, ажиллагчдын тооны бүлэг, мянган төгрөгөөр, 2020 он

Төрийн бус байгууллагын төрөл	Бүгд	Ажиллагчдын тооны бүлэг				
		1-2	3-5	6-9	10-20	21, түүнээс дээш
Төрөл	532.7	705.2	335.2	425.9	578.2	377.9
Нийгэмд үйлчилдэг	534.0	659.7	361.4	479.3	444.5	540.2
Гишүүддээ үйлчилдэг	530.9	783.6	303.6	370.7	754.9	194.9

Төрийн бус байгууллага нь 2020 онд 718.9 тэрбум төгрөгийн санхүүжилт авсны 21.0 хувийг олон улсын байгууллагын санхүүжилтээс, 16.1 хувь нь гишүүний татвараас, 13.0 хувь нь хандив, тусламжаас, 49.9 бусад эх үүсвэрээс бүрдэж байна.

ХҮСНЭГТ 9.11. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТ, санхүүжилтийн эх үүсвэр, тэрбум төгрөгөөр, 2015, 2020 он

Эх үүсвэр	2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	1 383.1	100.0	718.9	100.0
Гишүүний татвар	161.4	11.7	116.1	16.1
Хандив	215.6	15.6	93.2	13.0
Олон улсын байгууллагын санхүүжилт	607.3	43.9	150.9	21.0
Бусад	398.7	28.8	358.8	49.9

Төрийн бус байгууллага нь 337.4 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагаандаа зарцуулсны 12.2 хувь нь сургалт, семинар, эвент зохион байгуулахад зарцуулсан зардал, 10.8 хувь нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжид зарцуулсан зардал, 6.2 хувь нь бусдад өгсөн хандив, тусламж, 4.1 хувь нь сурталчилгааны зардал, 66.7 хувь нь бусад зардалд зарцуулсан байна. Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад нийт хөрөнгийн зарцуулалт 42.1 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 9.12. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, зардлын төрөл, тэрбум төгрөгөөр, 2015, 2020 он

Зардлын төрөл	2015		2020	
	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	583.0	100.0	337.4	100.0
Бусдад өгсөн хандив, тусламж	61.3	10.5	20.9	6.2
Сургалт, семинар зохион байгуулахад зарцуулсан зардал	157.0	26.9	41.0	12.2
Сурталчилгааны зардал	9.8	1.7	13.7	4.1
Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжид зарцуулсан зардал	231.3	39.7	36.6	10.8
Бусад	123.6	21.2	225.1	66.7

10


БҮЛЭГ

ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД



♀ 53.3% 46.7% ♂



Хөдөлмөр эрхлэгчид - 53.9 мянга



2 074.4 мян.төг 2 229.5 мян.төг

Улсын дундаж - 2 147.0 мян.төг

ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, үйл ажиллагааны чиглэлээр, мянган хүн



БҮЛЭГ 10. | ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД

Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллого нь хувиараа хөдөлмөр эрхлэгч (ХХЭ)-дийг хамруулсан анхны тооллого болсон онцлогтой.

Энэхүү бүлэгт тооллогын хугацаанд буюу 2021 оны 11 дүгээр сарын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа ХХЭ-дээс бизнесийн үйл ажиллагааны чиглэл, тухайн бизнесийг эрхлэн явуулж байгаа хугацаа, ажлын байрны нөхцөл, бизнесийн төлөв байдал, хандлага, Ковид-19 цар тахлын нөлөө, зээлтэй эсэх, цахим баримтын төлбөрийн системд холбогдсон эсэх зэрэг мэдээллийг цуглуулсан.

ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ТЭДГЭЭРИЙН БҮТЭЦ


Энэ удаагийн тооллогоор 53.9 мянган ХХЭ тоологдсоны 25.2 мянга (46.7%) нь эрэгтэйчүүд, 28.7 мянга (53.3%) нь эмэгтэйчүүд байна. ХХЭ-дийн 26.3 мянга (48.8%) нь Улаанбаатар хотод, 8.4 мянган (15.6%) нь Төвийн бүсэд, 8.2 мянга (15.2%) нь Хангайн бүсэд, 7.9 мянга (14.7%) нь Баруун бүсэд, 3.1 мянга (5.7%) нь Зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 10.1. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД,
бүс, аймаг, нийслэл, хүйсээр

Бүс, аймаг, нийслэл	Бүгд	Хүйс	
		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	53 927	25 199	28 728
Баруун бүс	7 942	4 504	3 438
Баян-Өлгий	1 936	1 384	552
Говь-Алтай	987	473	514
Завхан	1 714	860	854
Увс	1 418	849	569
Ховд	1 887	938	949
Хангайн бүс	8 187	3 692	4 495
Архангай	953	519	434
Баянхонгор	874	456	418

Бүс, аймаг, нийслэл	Бүгд	Хүйс	
		Эрэгтэй	Эмэгтэй
Булган	301	114	187
Орхон	3 078	1 178	1 900
Өвөрхангай	1 429	648	781
Хөвсгөл	1 552	777	775
Төвийн бүс	8 386	3 955	4 431
Говьсүмбэр	338	126	212
Дархан-Уул	2 117	899	1 218
Дорноговь	1 248	571	677
Дундговь	560	261	299
Өмнөговь	625	261	364
Сэлэнгэ	1 685	800	885
Төв	1 813	1 037	776
Зүүн бүс	3 073	1 412	1 661
Дорнод	960	418	542
Сүхбаатар	1 046	519	527
Хэнтий	1 067	475	592
Улаанбаатар	26 339	11 636	14 703

ЗУРАГ 10.1. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ТАРХАЛТ, аймаг, нийслэл, хүйсээр, 2021 он



Аймгаар авч үзвэл, нийт ХХЭ-дийн хамгийн их буюу 3.1 мянга (5.7%) нь Орхон аймагт, хамгийн бага буюу 301 хүн (0.6%) Булган аймагт бүртгэгдсэн байна.


Насны бүлгээр авч үзэхэд, ХХЭ-дийн 2.1 хувь нь 15-24 насны залуучууд (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуус), 79.8 хувь нь 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насны бүлгийнхэн), 18.1 хувь нь 55, түүнээс дээш насныхан байна. Залуучууд бага хувийг эзэлж байгаа нь тэдгээрийн сурч боловсрох, хөдөлмөрийн зах зээлд шинээр оролцоходоо эзэмшсэн мэргэжлээрээ бусад салбарт цалин, хөлстэй ажиллаж байгааг харуулж байна. Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгчид 30-аас дээш насны бүлэгт аажмаар өссөн байна.

ХҮСНЭГТ 10.2. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2021 он

Насны бүлэг	Бүгд	Хүйс	
		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100.0	46.7	53.3
15-24	2.1	57.7	42.3
25-29	5.5	54.7	45.3
30-34	13.3	53.2	46.8
35-39	15.8	50.0	50.0
40-44	16.0	47.2	52.8
45-49	16.0	44.4	55.6
50-54	13.3	42.0	58.0
55, түүнээс дээш	18.1	40.5	59.5


Насны бүлэг дэх хүйсийн ялгааг авч үзэхэд, 15-34 насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 6.5-15.4 нэгж хувиар их байгаа бол 35, түүнээс дээш насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 0.1-19.0 нэгж хувиар их байна.

ЗУРАГ 10.2. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2021 он




Сүүлийн 12 сарын дунджаар авч үзэхэд, ХХЭ арван хүн тутмын долоо нь бие дааж буюу ямар нэгэн хамтрагч эсвэл цалинтай ажилтангүй, үйл ажиллагаагаа эрхэлсэн байна. Харин 16.4 хувь нь нэг хүнтэй, 11.1 хувь нь 2, түүнээс дээш хүнтэй хамтран эсвэл ажилтан хөлслөн цалинжуулж ажиллуулсан байна.

ЗУРАГ 10.3. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ажиллагчдын тооны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2021 он



ХХЭ-дийн бизнесийн үйл ажиллагаа хэр тогтвортой байгааг тухайн үйл ажиллагааг эрхэлсэн хугацаагаар илэрхийлэх боломжтой. Улсын түвшинд ХХЭ арван хүн тутмын нэг нь үндсэн бизнесийн үйл ажиллагаагаа нэг хүртэлх жилийн хугацаанд эрхэлж байгаа бол ХХЭ таван хүн тутмын хоёр нь 1-5 жил, нэг нь 6-10 жил, 11-20 жилийн хугацаанд тус үйл ажиллагааг явуулж байна.

ЗУРАГ 10.4. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, үйл ажиллагаагаа эрхэлсэн хугацаа, хүйс, дүнд эзлэх хувиар, 2021 он



ХХЭ-дийн бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, цар хүрээг илэрхийлэх үзүүлэлтийн нэг нь ажлын байрны нөхцөл юм.

ХХЭ-дийн 61.5 хувь нь тогтсон ажлын байртай буюу дэлгүүр, зах, үйлчилгээний төв, гуанз, зочид буудал зэрэгт, харин 38.5 хувь нь тогтсон ажлын байргүй буюу гудамжинд, зам дагуу түр хугацаагаар байрлуулсан цэг, тээврийн хэрэгсэл, интернэт, цахим худалдаа, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн гэрт, өөрийн гэртээ, хогийн цэгт үйл ажиллагаагаа явуулж байна.


Тогтсон ажлын байртай ХХЭ-дийн 83.1 хувь нь дэлгүүр, зах, үйлчилгээний төвд үйл ажиллагаа явуулж байхад тогтсон ажлын байргүй ХХЭ-дийн дийлэнх нь буюу 24.2 хувь нь гэртээ, тусгай тоног төхөөрөмжгүй орчинд үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 10.5. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ажлын байрны төрөл, хувиар, 2021 он



Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 7.9 хувь нь бизнесийн үйл ажиллагаагаа дэмжүүлэх, өргөжүүлэх, хамгаалах зорилгоор холбоо, нэгдэлд нэгдэж, зохион байгуулалтад орсон байна.

ЗУРАГ 10.6. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, үйл ажиллагаагаа эрхэлсэн хугацаа, холбоо, нэгдэлд нэгдсэн байдал, хувиар, 2021 он



■ Холбоо, нэгдэлд нэгдсэн ■ Үгүй

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


ХХЭ-дийн 16.7 мянга (30.9%) нь жижиглэнгийн худалдааны салбарт, 8.9 мянга (16.5%) нь боловсруулах салбарт, 5.5 мянга (10.3%) нь тээвэр, агуулахын салбарт, 3.4 мянга (6.3%) нь хөдөө аж ахуйн салбарт бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ХҮСНЭГТ 10.3. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД,
үндсэн үйл ажиллагааны чиглэл, хүйсээр

Үйл ажиллагааны чиглэл	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	53 927	100.0%	25 199	100.0%	28 728	100.0%
Хөдөө аж ахуй	3 411	6.3%	2 348	9.3%	1 063	3.7%
Уул уурхай	63	0.1%	52	0.2%	11	0.0%
Боловсруулах	8 887	16.5%	4 130	16.4%	4 757	16.6%
Барилга, дэд бүтэц	2 272	4.2%	1 850	7.3%	422	1.5%
Худалдаа	22 867	42.4%	7 968	31.6%	14 899	51.9%
Үйлчилгээ	16 427	30.5%	8 851	35.1%	7 576	26.4%
Боловсрол	567	1.1%	111	0.4%	456	1.6%
Зочид буудал, зоогийн газар	1 657	3.1%	495	2.0%	1 162	4.0%
Санхүү, даатгал	182	0.3%	76	0.3%	106	0.4%
Тээвэр, агуулах	5 538	10.3%	5 152	20.4%	386	1.3%
Удирдлага	598	1.1%	350	1.4%	248	0.9%
Урлаг, үзвэр	222	0.4%	138	0.5%	84	0.3%
Үл хөдлөх хөрөнгө	517	1.0%	236	0.9%	281	1.0%
Шинжлэх ухаан	900	1.7%	409	1.6%	491	1.7%
Эрүүл мэнд	213	0.4%	49	0.2%	164	0.6%
Бусад	6 033	11.2%	1 835	7.3%	4 198	14.6%

Улсын түвшинд үйл ажиллагааны чиглэлээрх хандлага бүсийн түвшинд мөн хадгалагдаж байгаа ч худалдааны салбарт ХХЭ-дийн эзлэх хувь Хангай бүс болон Улаанбаатар хотод улсын дунджаас 2.4-3.7 нэгж хувиар их, үйлчилгээний салбарт Зүүн бүс болон Улаанбаатар хотод 2.0-6.1 нэгж хувиар их, хөдөө аж ахуйн салбарт Баруун, Төвийн бүсүүд 6.7-8.7 нэгж хувиар, аж үйлдвэрийн салбарт Улаанбаатар хотоос бусад бүсэд 0.5-2.4 нэгж хувиар их байгаа бол барилгын салбарт Улаанбаатар хотод улсын дунджаас 1.2 нэгж хувиар их байна.

ЗУРАГ 10.7. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, үйл ажиллагааны чиглэл, аймаг, нийслэлээр, 2021 он



Үйлчилгээний салбарт тээвэр, агуулахын үйл ажиллагаа эрхлэгчид өндөр хувийг эзэлж байгаа бол аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчид өндөр хувийг эзэлж байна.

ЗУРАГ 10.8. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, үйл ажиллагааны чиглэл, мянган хүнээр, 2021 он



ХХЭ-дийн салбараарх хүйсийн ялгааг авч үзвэл, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, барилга, уул уурхай, олборлолт, хөдөө аж ахуйн салбарт ХХЭ-дийн ихэнх нь (68.8-93.0%) эрэгтэйчүүд, боловсрол, хүний эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйл ажиллагаа, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, худалдааны салбарт дийлэнх (65.2-80.4%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 10.9. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хүйс, дүнд эзлэх хувиар, 2021 он




Сүүлийн 12 сарын дунджаар авч үзэхэд, 53.9 мянган ХХЭ-дийн 39.1 мянга (72.5%) нь бие даан бизнесийн үйл ажиллагаагаа эрхэлсэн бол 14.8 мянган ХХЭ нь 33.7 мянган хүнийг цалин, хөлстэй ажиллуулж эсвэл найз нөхөд, гэр бүлийн бизнесийн хүрээнд хамтран ажилласан байна. Өөрөөр хэлбэл, 53.9 мянган ХХЭ, тэдгээрийн үйл ажиллагаанд цалинтай эсвэл цалингүй оролцсон 33.7 мянган хүн, нийт 87.6 мянган хүн бизнесийн үйл ажиллагаанд оролцсон байна.

ХҮСНЭГТ 10.4. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ажиллагчдын тооны бүлэг, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он

Ажиллагчдын тооны бүлэг	Бүгд	Үйл ажиллагааны чиглэл				
		ХАА	Аж үйлдвэр	Барилга	Худалдаа	Үйлчилгээ
Бүгд	53 927	3 412	9 114	2 153	22 821	16 427
Бие даан	39 087	1 634	5 882	1 416	17 246	12 909
1 ажилтан	8 857	1 088	1 904	245	3 873	1 747
2 ажилтан	2 580	296	612	126	875	671
3 ажилтан	1 164	137	277	79	303	368
4, түүнээс дээш	2 239	257	439	287	524	732
Нийт ажиллагчдын тоо	87 614	7 218	16 053	5 040	33 208	26 095


Үйл ажиллагааны чиглэлээр авч үзэхэд, хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт бие даан бизнесийн үйл ажиллагаа эрхлэгчид 64.5-78.6 хувь байгаа бол хөдөө аж ахуйн салбарт нэг ажилтантай ХХЭ-дийн эзлэх хувь (31.9%), барилгын салбарт 4, түүнээс дээш ажилтантай ХХЭ-дийн эзлэх хувь (13.3%) бусад салбараас их байна.

ЗУРАГ 10.10. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, үйл ажиллагааны чиглэл, ажиллагчдын тооны бүлэг, дүнд эзлэх хувиар, 2021 он




Тооллогоор бизнесийн үйл ажиллагаагаа эхлүүлээд жил хүрэхгүй хугацаа болж байгаа ХХЭ-дийн ихэнх нь худалдаа болон үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 10.11. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа, үйл ажиллагааны чиглэл, хувиар, 2021 он




Тогтсон байртай хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 57.5 хувь нь худалдааны салбарт, 23.2 хувь нь үйлчилгээний салбарт, 13.4 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 5.0 хувь хөдөө аж ахуйн салбарт, 1.0 хувь нь барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 10.12. ТОГТСОН АЖЛЫН БАЙРТАЙ ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД,
үйл ажиллагааны чиглэл, дүнд эзлэх хувиар, 2021 он




ЗУРАГ 10.13. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ажлын байрны эзэмшил, дүнд эзлэх хувиар, 2021 он




ХХЭ-дийн хоёр хүн тутмын нэг (25.8 мянга) нь түрээсийн байранд бизнесийн үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа ХХЭ-дийн 57.6 хувь нь худалдааны салбарт, 26.3 хувь нь үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж байна.

ЗУРАГ 10.14. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ажлын байрны эзэмшил, үйл ажиллагааны чиглэл, хувиар




Тооллогод хамрагдсан ХХЭ-дийн 4.3 мянга буюу 7.9 хувь нь бизнесийн үйл ажиллагаагаа дэмжүүлэх, өргөжүүлэх, хамгаалах зорилгоор холбоо, нэгдэлд нэгдэж, зохион байгуулалтад оржээ. Холбоо, нэгдэлд нэгдэж, зохион байгуулалтад орсон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 41.3 хувь нь үйлчилгээний салбарт, 33.9 хувь нь худалдааны салбарт 15.9 хувь нь аж үйлдвэрийн салбарт байна.

ЗУРАГ 10.15. ХОЛБОО, НЭГДЭЛД НЭГДСЭН ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, үйл ажиллагааны чиглэл, дүнд эзлэх хувиар, 2021 он



ХХЭ-дийн 18.8 мянга (34.9%) нь цахим баримтын төлбөрийн системд холбогдсон, 65.1 хувь нь холбогдоогүй байна. Энэ системд холбогдсон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 46.6 хувь нь жижиглэнгийн худалдааны салбарт, 9.1 хувь нь боловсруулах салбарт байна.

ЗУРАГ 10.16. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, үйл ажиллагааны чиглэл, цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байдал, хувиар, 2021 он



ОРЛОГО

ХХЭ-дийн сүүлийн 12 сард орлого хамгийн их, хэвийн, бага байсан сарын тоо, тухайн сарын дундаж орлогын талаарх мэдээлэлд үндэслэн жилийн орлогын нийт хэмжээг тодорхойлсон.

ХХЭ-дийн 759 (1.4%) нь тооллогын хугацаанд үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Харин ХХЭ-дийн 53.2 мянга (98.6%) нь тооллогын хугацаанаас өмнөх 12 сард үйл ажиллагаа явуулж, нийт 1098.2 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Үүнээс 51.8 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний, 15.0 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 7.1 хувь нь тээвэр ба агуулахын үйлчилгээний, 6.6 хувь нь үйлчилгээний бусад, 6.1 хувь нь хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны орлого байна.

ХҮСНЭГТ 10.5. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ОРЛОГО, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он

Үйл ажиллагааны чиглэл	ХХЭ-дийн тоо	Орлого	
		Дүн, тэрбум төрөг	Дүнд эзлэх хувь
Бүгд	53 927	1 098.2	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	22 821	568.7	51.8
Боловсруулах үйлдвэрлэл	8 931	165.2	15.0
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	5 538	78.2	7.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5 801	72.0	6.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3 412	66.6	6.1
Барилга	2 153	42.4	3.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1 657	38.9	3.5
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	900	14.3	1.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	517	14.1	1.3
Бусад	2 197	37.6	3.4

ХХЭ-дийн сүүлийн 12 сарын сарын дундаж орлого 2.1 сая төгрөг байгаа бол эрэгтэй ХХЭ-ийнх 2.2 сая төгрөг, эмэгтэй ХХЭ-ийнх 2.1 сая төгрөг байна.

ЗУРАГ 10.17. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, хүйс, мянган төгрөгөөр, 2021 он




Үйл ажиллагаа эрхэлж байгаа ХХЭ-дийн дотор 1.3-1.5 сая төгрөгийн орлоготой ХХЭ-дийн эзлэх хувь хамгийн их (39.2%) байна. Хоёр хувиараа хөдөлмөр эрхлэгч тутмын нэг нь сард дунджаар 1.1 сая төгрөгөөс бага орлоготой байна.

ХҮСНЭГТ 10.6. ИДЭВХТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, сарын дундаж орлогын бүлэг, хүйсээр, 2021 он

Сарын дундаж орлогын бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүгд	53 144	100.0%	24 871	100.0%	28 273	100.0%
420.0 хүртэлх	9 309	17.5%	4 210	16.9%	5 099	18.0%
420.1-700.0	9 356	17.6%	4 130	16.6%	5 226	18.5%
700.1-900.0	5 379	10.1%	2 489	10.0%	2 890	10.2%
900.1-1100.0	4 384	8.2%	2 101	8.4%	2 283	8.1%
1100.1-1300.0	3 070	5.8%	1 528	6.1%	1 542	5.5%
1300.1-1500.0	20 814	39.2%	9 962	40.1%	10 852	38.4%
1500.1-2000.0	346	0.7%	187	0.8%	159	0.6%
2000.1-2500.0	199	0.4%	121	0.5%	78	0.3%
2500.1-3000.0	136	0.3%	64	0.3%	72	0.3%
3000.1-ээс дээш	151	0.3%	79	0.3%	72	0.3%

ХХЭ-дийн орлогыг сүүлийн 12 сарын дундажар авч үзвэл, хамгийн өндөр саруудын дундаж нь 3.2 сая төгрөг, хамгийн бага саруудын дундаж 945.6 мянган төгрөг байсан бол хэвийн үйл ажиллагаа явуулсан саруудын дундаж орлого 1.8 сая төгрөг байна. Үүнийг үйл ажиллагааны чиглэлээр дараах зургаар харууллаа.

ЗУРАГ 10.18. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, орлогын түвшин, үйл ажиллагааны чиглэл, мянган төгрөгөөр, 2021 он




ХХЭ-дийн сарын дундаж орлогыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд, уул уурхай, олборлолтын салбарт ХХЭ-дийн орлого хамгийн их буюу 3.0 сая төгрөг, үйлчилгээний бусад салбарынх хамгийн бага буюу 1.3 сая төгрөг байна.

ЗУРАГ 10.19. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, мянган төгрөгөөр, 2021 он



Тооллогоор ХХЭ-дийн зээлийн талаарх мэдээллийг судалсан бөгөөд нийт ХХЭ-дийн 29.0 мянга (53.7%) нь бизнесийн зээлтэй гэжээ. Уг үзүүлэлтийг үйл ажиллагааны чиглэлээр дараах зургаар харууллаа.

ЗУРАГ 10.20. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, зээлтэй эсэх, үйл ажиллагааны чиглэлээр, 2021 он



ДУГНЭЛТ

Тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн 94.7 мянга (62.5%) нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Тэдгээрийн 45.9 мянга (48.5%) нь түр зогссон, 29.5 мянга (31.1%) нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 18.8 мянга (19.8%) нь бүрэн зогссон, 0.6 мянга (0.6%) нь бусад шалтгаантай байна.

Сүүлийн хоёр жил үйл ажиллагаа явуулаагүй (105.5 мянга) нэгжийн 14.9 мянга (14.1%) нь татан буугдах хүсэлтэй бөгөөд эдгээрийн 6.5 мянга нь татварт 2019, 2020 онд тайлан өгөөгүй байна.

Тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн 56.8 мянга нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн 23.0 мянга (40.5%) нь худалдааны салбарт, 5.4 мянга (9.5%) нь боловсруулах үйлдвэрлэл, 2.6 мянга (4.5%) нь хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн 53.0 мянга (93.3%) нь компани, 1.5 мянга (2.6%) нь хоршоо, 1.4 мянга (2.5%) нь нөхөрлөл, 328 (0.6%) нь ТӨҮГ, ОНӨҮГ, 621 (1.1%) нь бусад төрлийн аж ахуйн нэгж байна.

Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 74.4 хувь нь нийслэл Улаанбаатар хотод төвлөрсөн байна.

Сүүлийн 2 жил дараалан үйл ажиллагаа явуулсан 46.0 мянган аж ахуйн нэгжийн 43.1 хувь нь төрийн байгууллагад баримт бичиг, тодорхойлолт зэрэг материал бүрдүүлж өгснөөр үйл ажиллагаа явуулдаг байна. Уул уурхай, олборлолтын салбарт үйл ажиллагаа явуулж буй нэг аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авахдаа дунджаар 34, үйлчилгээний салбарынх 12 баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлж, төрийн байгууллагад өгдөг бол хөдөө аж ахуйн салбар хамгийн бага буюу дунджаар 5 баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлдэг байна.

151.6 мянган аж ахуйн нэгжийн 1.9 хувь буюу 2.9 мянга нь 2020 онд хөрөнгө оруулалт хийсэн байна. Тухайлбал, боловсруулах үйлдвэрлэлийн 2.6 хувь буюу 0.3 мянган аж ахуйн нэгж, хөдөө аж ахуйн салбарын 2.0 хувь буюу 0.2 мянган аж ахуйн нэгж хөрөнгө оруулалт хийсэн байна.

Сүүлийн 2 жил үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсан бөгөөд ажиллах хүчний дутагдалтай 9.0 мянган аж ахуйн нэгжийн 41.9 хувьд нь мэргэжилтэн, 13.9 хувьд нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 11.3 хувьд нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 10.0 хувьд нь техникч болон туслах/ дэд мэргэжилтэн, 8.3 хувьд нь энгийн ажилтан шаардлагатай байна.

Сүүлийн 2 жил дараалан үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсан аж ахуйн нэгжийн 4.2 хувь буюу 1.9 мянга нь экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг байна. Харин аж үйлдвэрийн салбарын 9.1 хувь буюу 0.5 мянга нь, хөдөө аж ахуйн салбарын 4.2 хувь буюу 0.1 мянга нь экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж байна.

Үйл ажиллагаа 2020 онд явуулсан 41.6 мянган аж ахуйн нэгж 75.7 их наяд төгрөгийн орлого олсноос Орхон аймаг 3.0 их наяд төгрөг, Өмнөговь аймаг 2.4 их наяд төгрөгийн орлоготой байгаа нь бусад аймгаас хамгийн өндөр байгаа бол Дундговь аймаг 82.1 тэрбум төгрөг, Говь-Алтай аймаг 98.3 тэрбум төгрөгийн орлоготой буюу хамгийн бага байна.

Тооллогод 53.9 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамрагдсаны 39.1 мянга (72.5%) нь бие даан бизнесийн үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн 53.2 мянга (98.6%) нь тооллогын хугацаанаас өмнөх 12 сард үйл ажиллагаа явуулж, нийт 1.1 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн байна. Нийт борлуулалтын 51.8 хувийг худалдааны салбар, 15.0 хувийг боловсруулах үйлдвэрлэл эзэлж байна.

ЗӨВЛӨМЖ

Тооллогыг зохион байгуулахад гарсан хүндрэл, цаашид ААНБ-ын чиглэлээр авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх зөвлөмжийг энд тусгалаа. Үүнд:

- Тооллогыг бүртгэлд суурилсан байдлаар зохион явуулах бэлтгэл ажлыг хангах үүднээс төрийн байгууллагуудын мэдээллийн сан, маягтыг нэгтгэж, чанарыг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх,
- Тооллогын нэгдсэн мэдээллийн санг төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудтай холбож, бизнес эрхлэгчдийн их өгөгдлийн санг байгуулах,
- Аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллагад өгдөг статистик, татвар, санхүүгийн маягтын үзүүлэлтийг уялдуулж, аж ахуйн нэгж, байгууллагад очих дарамтыг бууруулах, төсвийн үр ашигтай байдлыг ханган ажиллах,
- Үйл ажиллагаа урт хугацаанд явуулаагүй, татвар, санхүүгийн тайланд хамрагдаагүй, татан буугдах хүсэлтэй аж ахуйн нэгжийг нарийвчлан судалж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Боловсруулах болон хөдөө аж ахуйн салбаруудад хөрөнгө оруулалтыг татах ажлыг эрчимжүүлж, тус салбаруудын эдийн засагт эзлэх хувийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээг дэс дараалалтайгаар авч хэрэгжүүлэх,
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн чиглэлийг шинэчлэн сайжруулах, дутагдалтай байгаа мэргэжилтэн бэлтгэхэд төрийн бодлогоор дэмжих;
- Монгол Улсыг бүсчилсэн байдлаар төрөлжүүлэн хөгжүүлэх, хөдөө орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжих, энэ нь хүн амын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйчүүд, ядуурлыг бууруулахад эергээр нөлөөлнө.
- Эдийн засагт хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд зээлийн хүү, авлига, хүнд суртлыг бууруулах арга хэмжээг авах шаардлагатай байна.

ХАВСРАЛТ

Хавсралт нь Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын 5 төрлийн асуулга, үндсэн үр дүнгийн хүснэгтүүдээс бүрдэнэ.

Х **Файл татах:** QR кодыг уншуулж хавсралт хүснэгт, тооллогын асуулгын хуудсыг татаж авах боломжтой.



Хавсралт хүснэгт: Хүснэгт нь аж ахуйн нэгж, байгууллагын байршил, төрөл, эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл, тэдгээрийн эдийн засгийн үзүүлэлт, бизнесийн төлөв байдал, хандлага, цар тахлын нөлөөлөл, инновац, судалгаа хөгжүүлэлт болон төрийн байгууллагын өгөгдлийн сан, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагааны талаарх тоо мэдээллийг агуулсан 195 хүснэгтээс бүрдэнэ.



Аж ахуйн нэгжийн тооллогын асуулга (ААНТ-1): Асуулга нь аж ахуйн нэгжийн хаяг, ерөнхий үзүүлэлт, үйл ажиллагааны байдал, шалтгаан, Ковид-19 цар тахлын нөлөө, мэдээллийн технологи, орлого, зардал, хөрөнгө, хөрөнгө оруулалт, бизнесийн төлөв байдал, хандлага, инновац, судалгаа хөгжүүлэлт зэрэг мэдээллийг агуулсан 9 бүлгээс бүрдэнэ.



Төсвийн байгууллагын тооллогын асуулга (ААНТ-2): Асуулга нь төсвийн байгууллагын хаяг, ерөнхий үзүүлэлт, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, мэдээллийн технологи, өгөгдлийн сан зэрэг мэдээллийг агуулсан 5 бүлгээс бүрдэнэ.



Төрийн бус байгууллагын тооллогын асуулга (ААНТ-3): Асуулга нь төрийн бус байгууллагын хаяг, ерөнхий үзүүлэлт, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төрийн бус байгууллагын төрөл, үйл ажиллагааны чиг үүрэг, гишүүдийн тоо, санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгийн зарцуулалт, мэдээллийн технологи, салбар, төлөөлөгчийн газар зэрэг мэдээллийг агуулсан 5 бүлгээс бүрдэнэ.



Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын тооллогын асуулга (ААНТ-4): Асуулга нь ААНБ-уудын салбар, нэгж, төлөөлөгчийн газрын хаяг, үйл ажиллагааны чиглэл, ажил, үйлчилгээний орлого, ажиллагчдын тоо, цалин, түүнтэй адилтгах зардал зэрэг эдийн засгийн үзүүлэлт агуулсан.



Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тооллогын асуулга (ААНТ-5): Асуулга нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хаяг, ерөнхий мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлт, үйл ажиллагаа явуулж буй байрны эзэмшлийн хэлбэр, бизнесийн төлөв байдал, хандлага, зээлийн мэдээлэл, цахим төлбөрийн баримтын систем (ebarimt.mn)-д холбогдсон эсэх талаарх мэдээллийг агуулсан 2 бүлгээс бүрдэнэ.

ISBN 978-9919-9907-0-1

Хавтасны дизайн:	Үндэсний Статистикийн Хороо
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:	Ү.Батжаргал, Д.Булганбаяр
Цаасны хэмжээ:	70x100 ¹ / ₁₆
Үсгийн гарнитур:	Roboto Light
Бодит хэвлэлийн хуудас:	13.75 х.х
Тооцооны хэвлэлийн хуудас:	17.74 х.х
Хэвлэсэн тоо:	200ш

Офсет хэвлэлийн аргаар Линограф хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Улаанбаатар хот
2022 он

ННА - 60.6
ДАА - 310
А - 31

